Энэ төрлийн гэмт хэрэг 2022 онд цагдаагийн байгууллагад 5259 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1326 буюу 33.7%-иар, орон нутагт 1699 бүртгэгдсэн нь 558 буюу 49.4%-иар, нийслэлд 3571 бүртгэгдсэн нь 768 буюу 27.4%-иар тус тус өссөн байна.



Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 778 буюу 14.8% нь Даваа гарагт, 743 буюу 14.1% нь Мягмар гарагт, 742 буюу 14.1% нь Лхагва гарагт, 751 буюу 14.3% нь Пүрэв гарагт, 825 буюу 15.7% нь Баасан гарагт, 687 буюу 13.1% нь Бямба гарагт, 733 буюу 13.9% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн, цагаар нь авч үзвэл 1494 буюу 28.4% нь 06:00-14:00 цагт, 1419 буюу 27.0% нь 14:00-19:00 цагт, 655 буюу 12.5% нь 19:00-22:00 цагт, 1691 буюу 32.2% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 2349 буюу 44.7% нь гэр, орон сууцанд, 884 буюу 16.8% нь гудамж талбайд, 851 буюу 16.2% нь олон нийтийн газарт, 484 буюу 9.2% нь аж ахуйн нэгжид, 35 буюу 0.7% нь нийтийн тээвэрт, 23 буюу 0.4% нь төрийн байгууллагад, 30 буюу 0.6% нь төрийн бус байгууллагад, 603 буюу 11.4% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэгдсэн хэргийн 402 буюу 7.6% нь согтуугаар, 237 буюу 4.5% нь хүүхэд оролцож, 293 буюу 5.6% нь эмэгтэй хүн оролцож, 363 буюу 6.9% нь бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Хэрэг бүртгэлтийн 4969 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1347 хэрэг буюу 37.2%-иар, үүнээс 1857 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 572 буюу 44.5%-иар тус тус өссөн.

Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 37.4% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.9 нэгжээр өсөж, нийслэлд 32.0% байгаа нь 0.9 нэгжээр буурч, орон нутагт 49.7% байгаа нь 7.1 нэгжээр өссөн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 2611 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 673 буюу 34.7%-иар өссөн. Холбогдогчдын 247 буюу 9.5% нь эмэгтэй, 2364 буюу 90.5% нь эрэгтэй, 366 буюу 14.0% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 623 буюу 35.8%-иар, эмэгтэй хүн 50 буюу 25.4%-иар, хүүхэд 59 буюу 19.2%-иар тус тус өссөн байна.

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 5292 иргэн, 4 хуулийн этгээд, 2385 эмэгтэй хүн, 158 хүүхэд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 1363 буюу 34.7%-иар, хүүхэд 65 буюу 69.9%-иар тус тус өсөж, хуулийн этгээд 1 буюу 20.0%-иар буурсан.

Учирсан хохирол. Иргэн, хуулийн этгээдэд учирсан 16879.6 сая төгрөгийн хохирлын 4784.8 сая төгрөг буюу 28.3%-ийг нөхөн төлүүлж, 201.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 7366.9 сая төгрөг буюу 77.4%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 1529.0 сая төгрөг буюу 47.0%-иар, битүүмжилсэн хөрөнгө 27.7 сая төгрөгөөр буюу 16.0-иар өссөн байна.

3.8.1.2.Халаасны хулгайн гэмт хэрэг

2022 онд энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 457 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 92 буюу 25.2%-иар, нийслэлд 446 бүртгэгдсэн нь 88 хэргээр буюу 24.6%-иар, орон нутагт 11 бүртгэгдсэн нь 4 буюу 57.1%-иар тус тус өссөн байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 81 буюу 17.7% нь Даваа гарагт, 82 буюу 17.9% нь Мягмар гарагт, 66 буюу 14.4% нь Лхагва гарагт, 61 буюу 13.3% нь Пүрэв гарагт, 71 буюу 15.5% нь Баасан гарагт, 50 буюу 10.9% нь Бямба гарагт, 46 буюу 10.1% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн, цагаар нь авч үзвэл 158 буюу 34.6% нь 06:00-14:00 цагт, 207 буюу 45.3% нь 14:00-19:00 цагт, 63 буюу 13.8% нь 19:00-22:00 цагт, 29 буюу 6.3% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 16 буюу 3.5% нь гэр, орон сууцанд, 255 буюу 55.8% нь гудамж талбайд, 95 буюу 20.8% нь олон нийтийн газарт, 47 буюу 10.3% нь нийтийн тээвэрт, 17 буюу 3.7% нь аж ахуйн нэгжид, 27 буюу 5.9% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 16 буюу 3.5% нь гэр, орон сууцанд, 255 буюу 55.8% нь гудамж талбайд, 95 буюу 20.8% нь олон нийтийн газарт, 47 буюу 10.3% нь нийтийн тээвэрт, 17 буюу 3.7% нь аж ахуйн нэгжид, 27 буюу 5.9% нь бусад газарт үйлдэгдсэн.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэгдсэн хэргийн 17 буюу 3.7% нь согтуугаар, 2 буюу 0.4% нь хүүхэд оролцож, 39 буюу 8.5% нь эмэгтэй хүн оролцож, 12 буюу 2.6% нь бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Хэрэг бүртгэлтийн 438 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 91 хэрэг буюу 26.2%-иар, үүнээс 146 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 62 буюу 73.8%-иар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 33.3% байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.1 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 32.6% байгаа нь 8.7 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 66.7% байгаа нь 26.7 нэгжээр тус тус өссөн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 172 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 60 буюу 53.6%-иар өссөн. Холбогдогчдын 35 буюу 20.3% нь эмэгтэй, 137 буюу 79.7% нь эрэгтэй, 3 буюу 1.7% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 43 буюу 45.7%-иар, эмэгтэй хүн 17 буюу 94.4%-иар тус тус өсөж, хүүхэд өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 451 иргэн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 87 буюу 23.9%-иар өссөн байна. Хохирогчдын 355 буюу 78.7% нь эмэгтэй, 116 буюу 25.7% нь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс хохирсон хүн 87 буюу 23.9%-иар, эмэгтэй хүн 69 буюу 24.1%-иар, хүүхэд 45 буюу 63.4%-иар тус тус өссөн байна.

Учирсан хохирол. Хэргийн улмаас иргэдэд учирсан 663.3 сая төгрөгийн хохирлын 157.7 сая төгрөг буюу 23.8%-ийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 237.7 сая төгрөг буюу 55.8%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 98.3 сая төгрөг буюу 2.6 дахин тус тус өссөн байна.

3.8.2. Дээрэмдэх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйл)

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 2022 онд 485 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 119 гэмт хэргээр буюу 32.5%-иар, нийслэлд 396 бүртгэгдсэн нь 91 буюу 29.8%-иар, орон нутагт 89 бүртгэгдсэн нь 28 буюу 45.9%-иар тус тус өссөн байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 63 буюу 13.0% нь Даваа гарагт, 70 буюу 14.4% нь Мягмар гарагт, 54 буюу 11.1% нь Лхагва гарагт, 83 буюу 17.1% нь Пүрэв гарагт, 78 буюу 16.1% нь Баасан гарагт, 67 буюу 13.8% нь Бямба гарагт, 70 буюу 14.4% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн, цагаар нь авч үзвэл 104 буюу 21.4% нь 06:00-14:00 цагт, 107 буюу 22.1% нь 14:00-19:00 цагт, 67 буюу 13.8% нь 19:00-22:00 цагт, 207 буюу 42.7% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 323 буюу 66.6% нь гудамж, талбайд, 65 буюу 13.4% нь гэр орон сууцанд, 45 буюу 9.3% нь олон нийтийн газарт, 17 буюу 3.5% нь аж ахуй нэгжид, 3 буюу 0.6% нь нийтийн тээвэрт, 32 буюу 6.5% нь бусад газарт үйлдэгджээ.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 78 буюу 16.1% нь согтуугаар, 1 буюу 0.2% нь галт зэвсгээр, 56 буюу 11.5% нь хүүхэд оролцож, 23 буюу 4.7% нь эмэгтэй хүн оролцож, 100 буюу 20.6% нь бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 422 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 134 буюу 46.5%-иар өссөн.



Холбогдогчдын 22 буюу 5.2% нь эмэгтэй, 400 буюу 94.8% нь эрэгтэй, 99 буюу 23.5% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 125 буюу 45.5%-иар, эмэгтэй хүн 9 буюу 69.2%-иар, хүүхэд 73 буюу 3.8 дахин тус тус өссөн байна.

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 495 иргэн хохирч, үүнээс 45 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 122 буюу 32.7%-иар, гэмтсэн хүн 10 буюу 28.6%-иар тус тус өссөн байна.

Учирсан хохирол. Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 9428.4 сая төгрөгийн хохирлын 1536.4 сая төгрөг буюу 16.3%-ийг нөхөн төлүүлж, 67.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 8886.5 сая төгрөг буюу 17.4 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 1237.8 сая төгрөг буюу 5.1 дахин, битүүмжилсэн хөрөнгө 56.0 сая төгрөг буюу 6.0 дахин тус тус өссөн байна.

3.8.3.Залилах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйл)

Цагдаагийн байгууллагад 2022 онд энэ төрлийн гэмт хэрэг 11839 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5281 буюу 80.5%-иар, нийслэлд 9810 бүртгэгдсэн нь 4570 буюу 87.2%-иар, орон нутагт 2026 бүртгэгдсэн нь 720 буюу 55.1%-иар тус тус өсөж, бусад газар /хилийн чанд/-д 3 бүртгэгдсэн нь 9 буюу 75.0%-иар буурсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 1860 буюу 15.7% нь Даваа гарагт, 1848 буюу 15.6% нь Мягмар гарагт, 1787 буюу 15.1% нь Лхагва гарагт, 1824 буюу 15.4% нь Пүрэв гарагт, 2028 буюу 17.1% нь Баасан гарагт, 1221 буюу 10.3% нь Бямба гарагт, 1271 буюу 10.7% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн, цагаар нь авч үзвэл 4755 буюу 40.2% нь 06:00-14:00 цагт, 4813 буюу 40.7% нь 14:00-19:00 цагт, 1442 буюу 12.2% нь 19:00-22:00 цагт, 829 буюу 7.0% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 4650 буюу 39.3% нь гэр, орон сууцанд, 1773 буюу 15.0% нь гудамж талбайд, 878 буюу 7.4% нь олон нийтийн газарт, 1313 буюу 11.1% нь аж ахуйн нэгжид, 3225 буюу 27.2% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 24 буюу 0.2% нь согтуугаар, 398 буюу 3.4% нь хүүхэд оролцож, 2901 буюу 24.5% нь эмэгтэй хүн оролцож, 260 буюу 2.2% нь бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Хэрэг бүртгэлтийн 11014 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5739 хэрэг буюу 2.1 дахин, үүнээс 6182 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 3626 буюу 2.4 дахин тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 56.1% байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.7 нэгжээр, нийслэлд 57.7% байгаа нь 7.6 нэгжээр, орон нутагт 47.7% байгаа нь 5.9 нэгжээр тус тус өссөн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 7386 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3379 буюу 84.3%-иар өссөн. Холбогдогчдын 2502 буюу 33.9% нь эмэгтэй, 4884 буюу 66.1% нь эрэгтэй, 406 буюу 5.5% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 2232 буюу 84.2%, эмэгтэй хүн 1147 буюу 84.6%-иар, хүүхэд 282 буюу 3.5 дахин тус тус өссөн байна.

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 11786 иргэн, 19 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 5263 буюу 80.7%-иар, хуулийн этгээд 10 буюу 2.1 дахин тус тус өссөн.

Учирсан хохирол. Иргэн, хуулийн этгээдэд учирсан 229193.4 сая төгрөгийн хохирлын 116161.3 сая төгрөг буюу 50.7%-ийг нөхөн төлүүлж, 1876.6 сая төгрөгийн хөрөнгө

битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 124670.7 сая төгрөг буюу 2.2 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 71230.1 сая төгрөг буюу 2.6 дахин тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 1127.6 сая төгрөг буюу 37.5%-иар буурсан байна.

3.8.4. Мал хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл)

Цагдаагийн байгууллагад 2022 онд энэ төрлийн гэмт хэрэг 778 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 35 буюу 4.7%-иар, орон нутагт 742 бүртгэгдсэн нь 41 буюу 5.8%-иар тус тус өсөж, нийслэлд 36 бүртгэгдсэн нь 6 буюу 14.3%-иар буурсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 111 буюу 14.3% нь Даваа гарагт, 128 буюу 16.5% нь Мягмар гарагт, 123 буюу 15.8% нь Лхагва гарагт, 116 буюу 14.9% нь Пүрэв гарагт, 119 буюу 15.3% нь Баасан гарагт, 90 буюу 11.6% нь Бямба гарагт, 91 буюу 11.7% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 127 буюу 16.3% нь 06:00-14:00 цагт, 151 буюу 19.4% нь 14:00-19:00 цагт, 130 буюу 16.7% нь 19:00-22:00 цагт, 370 буюу 47.6% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 27 буюу 3.5% нь согтуугаар, 16 буюу 2.1% нь хүүхэд оролцож, 14 буюу 1.8% нь эмэгтэй хүн оролцож, 200 буюу 25.7% нь бүлэглэн, 514 буюу 66.1% нь тээврийн хэрэгсэл ашиглаж тус тус үйлдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Хэрэг бүртгэлтийн 687 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 52 хэрэг буюу 8.2%-иар, үүнээс 414 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь 24 буюу 6.2%-иар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 60.3% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.2 нэгжээр, орон нутагт 63.5% байгаа нь 0.7 нэгжээр тус тус буурч, нийслэлд 0.0% байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 753 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51 буюу 7.3%-иар өссөн. Холбогдогчдын 14 буюу 1.9% нь эмэгтэй, 739 буюу 98.1% нь эрэгтэй, 26 буюу 3.5% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 46 буюу 6.6%-иар, эмэгтэй хүн 5 буюу 55.6%-иар, хүүхэд 7 буюу 36.8%-иар тус тус өссөн байна.

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 798 иргэн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 43 буюу 5.7%-иар өссөн.

Учирсан хохирол. Хэргийн улмаас иргэдэд учирсан 3353.1 сая төгрөгийн хохирлын 1694.6 сая төгрөг буюу 50.5%-ийг нөхөн төлүүлж, 289.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 413.4 сая төгрөгөөр буюу 11.0%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 237.2 сая төгрөг буюу 12.3%-иар, битүүмжилсэн хөрөнгө 29.5 сая төгрөг буюу 9.3%-иар тус тус буурсан байна.

Алдагдсан малын тоо. Адуу 1172, Үхэр 1587, Тэмээ 39, Ямаа 1401, Хонь 3204 байна.

3.9. Эдийн засгийн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэг)

2022 онд 162 эдийн засгийн гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 4 хэргээр буюу 2.5%-иар, нийслэлд 131 хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 1 хэргээр буюу 0.8%-иар, орон нутагт 30 хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 2 хэргээр буюу 7.1%-иар тус тус өссөн байна.

3.10. Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 19 дүгээр бүлэг)

2021 онд үндэсний аюулгүй байдлын эсрэг 2 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2022 онд энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдээгүй байна. 2021 онд бүртгэгдсэн дээрх 2 хэрэг нь нийслэлд бүртгэгдсэн байна.



3.11.Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэг)

2022 онд энэ бүлэгт заасан 359 гэмт хэрэг бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 1.0%-ийг эзэлж, өмнөх оноос 397 хэргээр буюу 52.5%-иар, нийслэлд 297 бүртгэсэн нь өмнөх оноос 237 хэргээр 44.4%-иар, орон нутагт 62 бүртгэсэн нь өмнөх оноос 160 хэргээр буюу 72.1%-иар тус тус буурсан байна.

3.11.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйл)

Цагдаагийн байгууллагад 2022 онд энэ төрлийн гэмт хэрэг 229 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 42 буюу 22.5%-иар, нийслэлд 204 бүртгэгдсэн нь 59 буюу 40.7%-иар тус тус өсөж, орон нутагт 25 бүртгэгдсэн нь 17 буюу 40.5%-иар буурсан байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 31 буюу 13.5% нь Даваа гарагт, 35 буюу 15.3% нь Мягмар гарагт, 37 буюу 16.2% нь Лхагва гарагт, 44 буюу 19.2% нь Пүрэв гарагт, 34 буюу 14.8% нь Баасан гарагт, 33 буюу 14.4% нь Бямба гарагт, 15 буюу 6.6% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн, цагаар нь авч үзвэл 44 буюу 19.2% нь 06:00-14:00 цагт, 58 буюу 25.3% нь 14:00-19:00 цагт, 40 буюу 17.5% нь 19:00-22:00 цагт, 87 буюу 38.0% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 97 буюу 42.4% нь гэр, орон сууцанд, 76 буюу 33.2% нь гудамж талбайд, 24 буюу 10.5% нь олон нийтийн газарт, 2 буюу 0.9% нь нийтийн тээвэрт, 1 буюу 0.4% нь төрийн байгууллагад, 1 буюу 0.4% нь төрийн бус байгууллагад, 4 буюу 1.7% нь аж ахуйн нэгжид, 4 буюу 1.7% нь автозамд, 20 буюу 8.7% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэгдсэн хэргийн 1 буюу 0.4% нь согтуугаар, 5 буюу 2.2% нь хүүхэд оролцож, 23 буюу 10.0% нь эмэгтэй хүн оролцож, 37 буюу 16.2% нь бүлэглэн, 217 буюу 94.8% нь мансуурсан үедээ тус тус үйлдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Хэрэг бүртгэлтийн 175 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 18 хэрэг буюу 11.5%-иар өсөж, үүнээс 107 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 11 буюу 9.3%-иар буурсан.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 61.1% байгаа нь өмнөх оны мөн үеэс 14.0 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 61.9% байгаа нь 10.9 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 53.3% байгаа нь 30.0 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 238 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28 буюу 13.3%-иар өссөн. Холбогдогчдын 25 буюу 10.5% нь эмэгтэй, 213 буюу 89.5% нь эрэгтэй, 6 буюу 2.5% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 9.8%-иар, эмэгтэй хүн 92.3%-иар тус тус өсөж, хүүхэд 14.3%-иар буурсан байна.

3.12.Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэг)

Цагдаагийн байгууллагад 2022 онд хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг 94 гэмт хэрэг бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 0.3%-ийг эзэлж байна.

Энэ нь өмнөх оноос 52 хэргээр буюу 80.8%-иар, нийслэлд 58 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 24 хэргээр буюу 70.6%-иар, орон нутагт 36 бүртгэсэн нь өмнөх онтой харьцуулахад 2 дахин тус тус өссөн байна.

3.13. Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэг)

Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 2022 онд 296 бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 0.8%-ийг эзэлж байна. Өмнөх оноос 64 хэргээр буюу 27.6%-иар, нийслэлд 145 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 9 хэргээр буюу 6.6%-иар, орон нутагт 151 бүртгэгдсэн нь өмнөх оноос 56 хэргээр буюу 58.9%-иар тус тус өссөн байна.

3.14. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэг)

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 2022 онд 559 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 42 буюу 7.0%-иар, орон нутагт 514 бүртгэгдсэн нь 35 буюу 6.4%-иар, нийслэлд 45 бүртгэгдсэн нь 7 буюу 13.5%-иар тус тус буурсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 72 буюу 12.9% нь Даваа гарагт, 95 буюу 17.0% нь Мягмар гарагт, 96 буюу 17.2% нь Лхагва гарагт, 97 буюу 17.4% нь Пүрэв гарагт, 87 буюу 15.6% нь Баасан гарагт, 63 буюу 11.2% нь Бямба гарагт, 49 буюу 8.7% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн, цагаар нь авч үзвэл 163 буюу 29.2% нь 06:00-14:00 цагт, 233 буюу 41.7% нь 14:00-19:00 цагт, 70 буюу 12.5% нь 19:00-22:00 цагт, 93 буюу 16.6% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 220 буюу 39.4% нь ойн сав бүхий газар, 39 буюу 7.0% нь хууль бусаар алт олборлож байгаа газар, 130 буюу 23.3% нь хөдөө хээр, 27 буюу 4.8% нь гол, усны ай сав газар, 18 буюу 3.2% нь аж ахуйн нэгжид, 6 буюу 1.0% нь ашиглаж байгаа уурхайд, 30 буюу 5.3% нь ашигт малтмалын орд газарт, 12 буюу 2.1% нь бэлчээрт, 77 буюу 13.8% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэгдсэн хэргийн 1 буюу 0.2% нь согтуугаар, 15 буюу 3.0% нь эмэгтэй хүн оролцож, 79 буюу 14.1% нь бүлэглэн, 29 буюу 5.2% нь галт зэвсгээр, 4 буюу 0.4% нь гадаадын иргэн оролцож тус тус үйлдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Хэрэг бүртгэлтийн 423 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3 хэрэг буюу 0.7%-иар, үүнээс 220 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 31 буюу 12.4%-иар тус тус буурсан.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 52.0% байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.9 нэгжээр, орон нутагт 50.2% байгаа нь 12 нэгжээр тус тус буурч, нийслэлд 48.9% байгаа нь 5.1 нэгжээр өссөн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 448 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 122 буюу 21.4%-иар буурсан. Холбогдогчдын 15 буюу 3.3% нь эмэгтэй, 433 буюу 96.7% нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 110 буюу 20.3%-иар, эмэгтэй хүн 12 буюу 44.4%-иар тус тус буурсан байна.

Хохирсон хүн, хуулийн этгээд. Гэмт хэргийн улмаас 485 иргэн, 9 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 51 буюу 9.5%-иар буурч, хуулийн этгээд 2 буюу 22.2%-иар өссөн.

Учирсан хохирол. Иргэн, хуулийн этгээдэд учирсан 4872.0 сая төгрөгийн хохирлын 3411.8 сая төгрөг буюу 70.0%-ийг нөхөн төлүүлж, 818.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 526.2 сая төгрөг буюу 9.7%-иар, битүүмжилсэн хөрөнгө 247.8 сая төгрөг буюу 23.2%-иар тус тус буурч, нөхөн төлүүлсэн хохирол 1316.7 сая төгрөг буюу 62.8%-иар өссөн байна.

3.15. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг)

2022 онд соёлын өвийн эсрэг гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 9 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 1 хэргээр буюу 12.5%-иар, нийслэлд 5 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1 хэргээр буюу 25%-иар тус тус өсөж, орон нутагт 4 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой адил түвшинд байна.

3.16. Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэг)

2022 онд энэ бүлэгт заасан гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 259 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 108 хэргээр буюу 71.5%-иар, нийслэлд 231 хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 98 хэргээр буюу 73.7%-иар, орон нутагт 28 шинээр бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 10 хэргээр буюу 55.6%-иар тус тус өссөн байна.

3.16.1. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг

“Цахим орчинд үйлдэгдсэн” гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 2022 онд нийт 8563 бүртгэгдсэний 6865 буюу 80.2% нь Улаанбаатар хотод, 1695 буюу 19.6% нь орон нутагт, 3 буюу 0.04% нь бусад газарт /хилийн чанад/ бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Хэргийг гарагаар нь авч үзвэл 1296 буюу 15.2% нь Даваа гарагт, 1282 буюу 15.0% нь Мягмар гарагт, 1217 буюу 14.2% нь Лхагва гарагт, 1300 буюу 15.2% нь Пүрэв гарагт, 1519 буюу 17.7% нь Баасан гарагт, 953 буюу 11.1% нь Бямба гарагт, 996 буюу 11.6% нь Ням гарагт үйлдэгджээ. Хэргийг цагаар нь авч үзвэл 3301 буюу 38.5% нь 06-14 цагийн хооронд, 3422 буюу 40.0% нь 14-19 цагийн хооронд, 1187 буюу 13.9% нь 19-22 цагийн хооронд, 653 буюу 7.6% нь 22-06 цагийн хооронд үйлдэгдэж байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Энэ төрлийн гэмт хэргийн 4120 буюу 48.1% нь гэр орон сууцанд, 1100 буюу 12.8% нь гудамж талбайд, 397 буюу 4.6% нь аж ахуйн нэгжид, 512 буюу 6.0% нь олон нийтийн газарт, 30 буюу 0.4% нь төрийн байгууллагад, 2404 буюу 28.1% нь бусад газарт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэгдсэн хэргийн 12 буюу 0.1% нь согтуугаар, 397 буюу 4.6% нь хүүхэд оролцож, 1966 буюу 22.9% нь эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Цахим орчинд үйлдэгдсэн 8563 гэмт хэрэгт 5664 хүнийг холбогдуулан шалгаж, тэдний 3798 буюу 67.1% нь эрэгтэй, 1866 буюу 32.9% нь эмэгтэй, 402 буюу 7.1% нь 14-17 насны хүүхэд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүн 2805 буюу 98.1%-иар, эмэгтэй хүн 1152 буюу 2.6 дахин, хүүхэд 298 буюу 3.9 дахин тус тус өссөн.

Хохирсон хүн, хуулийн этгээд. Гэмт хэргийн улмаас 8438 хүн хохирсны 3224 буюу 38.2% нь эрэгтэй, 5214 буюу 61.8% нь эмэгтэй, 83 буюу 1.0% нь 11-17 насны хүүхэд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 4103 буюу 94.6% , эрэгтэй хүн 1639 буюу 2.0 дахин, эмэгтэй хүн 2464 буюу 89.6%, хүүхэд 39 буюу 88.6%-иар тус тус өссөн байна.

Учирсан хохирол. Иргэн, хуулийн этгээдэд учирсан 32662.6 сая төгрөгийн хохирлын 10413.8 сая төгрөг буюу 31.9%-ийг нөхөн төлүүлж, 275.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 14153.9 сая төгрөг буюу 76.5%-иар, битүүмжилсэн хөрөнгө 241.3 сая төгрөг буюу 8.0 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 1185.0 сая төгрөг буюу 12.8%-иар тус тус өссөн байна.

3.17. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 27 дугаар бүлэг)

2022 онд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1220 бүртгэгдсэн нь улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 3.5%-ийг эзэлж байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад 305 хэргээр буюу 33.3%-иар, нийслэлд 595 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 152 хэргээр буюу 34.3%-иар, орон нутагт 625 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 153 хэргээр буюу 32.4%-иар тус тус өссөн байна.

3.17.1.Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйл)

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 2022 онд 1214 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 302 буюу 33.1%-иар, орон нутагт 621 бүртгэгдсэн нь 151 буюу 32.1%-иар, нийслэлд 593 бүртгэгдсэн нь 151 буюу 34.1%-иар тус тус өссөн байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 166 буюу 13.7% нь Даваа гарагт, 178 буюу 14.7% нь Иягмар гарагт, 180 буюу 14.8% нь Лхагва гарагт, 162 буюу 13.3% нь Пүрэв гарагт, 185 буюу 15.2 % нь Баасан гарагт, 172 буюу 14.2% нь Бямба гарагт, 171 буюу 14.1% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн, цагаар нь авч үзвэл 338 буюу 27.8% нь 06:00-14:00 цагт, 360 буюу 29.7% нь 14:00-19:00 цагт, 232 буюу 19.1% нь 19:00-22:00 цагт, 284 буюу 23.4% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 474 буюу 41.8% нь орон нутгийн замд, 598 буюу 52.7% нь хотын замд, 12 буюу 1.0% нь аж ахуй нэгжийн замд, 51 буюу 4.5% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэгдсэн хэргийн 219 буюу 18.0%-ийг согтуугаар, 220 буюу 18.1%-ийг эмэгтэй хүн оролцож, 15 буюу 1.2%-ийг хүүхэд оролцож, 10 буюу 0.8%-ийг гадаадын иргэн үйлдсэн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 1051 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 251 буюу 31.4%-иар өссөн. Холбогдогчдын 208 буюу 19.8% нь эмэгтэй, 843 буюу 80.2% нь эрэгтэй, 15 буюу 1.4% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 138 буюу 19.6%-иар, эмэгтэй хүн 113 буюу 2.1 дахин тус тус өсөж, хүүхэд 2 буюу 11.8%-иар буурсан байна.

Хохирсон хүн, хуулийн этгээд. Гэмт хэргийн улмаас 1357 иргэн хохирч үүнээс 279 хүн нас барж, 1039 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 320 буюу 30.9%-иар, нас барсан хүн 41 буюу 17.2%-иар, гэмтсэн хүн 267 буюу 34.6%-иар тус тус өссөн.

Учирсан хохирол. Иргэдэд гэмт хэргийн улмаас учирсан 7432.9 сая төгрөгийн хохирлын 6526.4 сая төгрөг буюу 87.8%-ийг нөхөн төлүүлж, 703.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь хохирлын хэмжээ 2470.3 сая төгрөгөөр буюу 49.8%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 2243.8 сая төгрөг буюу 52.4%-иар, битүүмжилсэн хөрөнгө 94.2 сая төгрөг буюу 15.5%-иар тус тус өссөн байна.

3.18.Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэг)

Цагдаагийн байгууллагад 2022 онд цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 10 бүртгэсэн байна.

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 10 бүртгэсэн нь өмнөх оноос 1 хэрэг буюу 9.1%-иар буурсан байна. Нийслэлд энэ төрлийн гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад ижил түвшинд байна. Харин орон нутагт цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 8 бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 1 гэмт хэргээр буюу 11.1%-иар буурсан байна.

3.19.Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг)


Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг 2022 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй.

4. Мөрдөн шалгах ажиллагаа.

4.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт

Цагдаагийн байгууллага 2022 онд 62109 хэрэгт хэрэг бүртгэлт, 7976 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 70085 хэрэгт ЭХХШТХ-д заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулсны 20933 нь урьд оны үлдэгдэл хэрэг, 46853 нь энэ оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 34, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 2265 хэрэг байна.

График 4. Шалгасан хэрэг




Өмнөх оны мөн үетэй харьцуулбал ЭХХШТХ-д заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэрэг 13560 хэргээр буюу 24.0%-иар өссөн байна.

Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт:

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 46853 буюу 66.9 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 20168 буюу 28.8%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
- 18054 буюу 25.8%-ийг шүүхэд шилжүүлж,
- 2274 буюу 3.2%-ийг хэрэгсэхгүй болгож,
- 5690 буюу 8.1%-ийг бусад мөрдөн байцаалтын хэрэгт нэгтгэн,
- 667 буюу 1.0%-ийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 66.9%, хуулийн анхны хугацаанд 89.2%-ийг шийдвэрлэсэн байна.

График 5. Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт



Хүснэгт 2. 2022 онд хэргийн шийдвэрлэлт хамгийн бага нэгжүүд


Д/д	Цагдаагийн байгууллага	2022 онд нийт шалгасан эрүүгийн хэргийн тоо	Шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо	Хувь
Орон нутаг				
1	Булган	796	453	56.9
2	Өвөрхангай	1234	736	59.6
3	Архангай	889	550	61.9

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2022

4	Сэлэнгэ	1244	794	63.8
5	Орхон	1520	972	63.9
6	Хэнтий	1171	760	64.9
Нийслэл				
1	Хан-Уул дүүргийн цагдаагийн газрын I хэлтэс	3380	1730	51.2
2	Хан-Уул дүүргийн цагдаагийн газрын II хэлтэс	2368	1335	56.4
3	Баянгол дүүргийн цагдаагийн газрын I хэлтэс	3771	2402	63.7
4	Баянгол дүүргийн цагдаагийн газрын II хэлтэс	3560	2292	64.4
5	Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс	795	513	64.5
6	Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын II хэлтэс	4695	3053	65.0


Прокурор, шүүхээс 1268 эрүүгийн хэрэг буцсанаас 1182 хэрэг буюу /93.2%/ -ийг шийдвэрлэж, 86 эрүүгийн хэрэг буюу 6.8%-ийн үлдэгдэлтэй байна.

График 6. Ажиллагаанд шалгагдаж буй үлдэгдэл хэргийн тоо



2022 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгасан гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учирсан 1534.2 тэрбум төгрөгийн хохирлын 1149.2 тэрбум төгрөг буюу 74.9%-ийг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна.

График 7. Хохирол нөхөн төлүүлэлт /сая.төг-өөр/




2022 онд 1808 хүнд холбогдох 23866 хэргийн үлдэгдэлтэй байна. Үүнд хэрэг бүртгэлтийн 22276 /93.3%/, мөрдөн байцаалтын 1590 /6.7%/ хэрэг байна.

4.2. Түдгэлзүүлсэн хэргийн шийдвэрлэлт

2022 онд “Түдгэлзүүлсэн” үзүүлэлтээр цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд орсон нийт 72 эрүүгийн хэрэг (түдгэлзүүлснээс сэргээн шалгаж байгаа, шийдвэрлэсэн, харьяаллын дагуу шилжүүлсэн, одоо түдгэлзүүлсэн байгаа)-ийн 61 буюу 84.7% нь өмнөх оны, 11 буюу 15.3% нь энэ оны хэрэг байна.

График 8. Түдгэлзүүлсэн хэргийн төрөл



Үүнээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.14.2 дахь заалтад заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 65, 31.14.1 дэх заалтад заасан үндэслэлээр 1, 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар түдгэлзүүлсэн 6 хэрэг байна.

График 9. Түдгэлзүүлсэн хэргийн төрөл




График 10. Түдгэлзүүлснээс сэргээсэн хэргийн шийдвэрлэлт

Түдгэлзүүлсэнээс сэргээн шалгасан 38	Шийдвэрлэсэн	Дахин түдгэлзүүлсэн	Ажиллагаанд
	26	10	2
	68.4%	26.3%	5.3%

Үлдэгдэл түдгэлзүүлсэн хэрэг

2022 онд түдгэлзүүлсэн үлдэгдэл 40 хэргийн 36 буюу 90.0% нь өмнөх оны, 4 буюу 10.0% нь энэ оны дугаартай хэрэг байна.

График 11. Үлдэгдэл түдгэлзүүлсэн эрүүгийн хэргийн ангилал




Үлдэгдэл түдгэлзүүлсэн эрүүгийн хэрэгт хүчиндэх 2 (5.0%), хүнийг алах 1 (2.5%), дээрэмдэх 1 (2.5%), мал хулгайлах 1 (2.5%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 4 (10.0%), хулгайлах 5 (12.5%), залилах 16 (40.0%), бусад төрлийн 10 (25.0%) гэмт хэрэг тус тус эзэлж байна.

5.Зөрчил шалган шийдвэрлэлт

Цагдаагийн байгууллагад нийт 2.704.791 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 630.379 буюу 30.4%, 2.701.773 зөрчлийг шийдвэрлэсэн нь 631.823 буюу 30.5% тус тус өссөн байна.

График 12. Бүртгэгдсэн зөрчлийн ангилал



Зөрчил гаргасан:

- 2.561.390 иргэн, 75.401 хуулийн этгээдэд 92.0 тэрбум төгрөгөөр торгох,
- 18.931 хүнийг баривчлах,
- 46.051 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус

ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 600.883 буюу 30.6%-иар, хуулийн этгээдийг торгосон шийтгэл 14.693 буюу 24.2%-иар, баривчилсан шийтгэл 3.654 буюу 23.9%-иар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 12.593 буюу 37.6%-иар тус тус өссөн байна. Нийт ногдуулсан торгуулийн хэмжээ мөн 16.9 тэрбум буюу 22.7%-иар өссөн байна.

Хүснэгт 3. Зөрчлийн шийдвэрлэлт

№	Төв, орон нутгийн цагдаагийн байгууллага	Нийт зөрчил		Зөрчлийн шийдвэрлэлт				
				Нэг. Ердийн журмаар шийдвэрлэсэн				
				Торгосон				
				Нийт зөрчил	Хүн	Хуулийн этгээд	Торгуулийн хэмжээ /мян.төг/	
		2021	2022	3	4	5	6	
1	Баруун бүс	Баян-Өлгий	18315	21043	18813	18742	71	439624.5
2		Говь-Алтай	15629	22013	20304	20300	4	491256.7
3		Завхан	17751	23475	21876	21876		568622.8
4		Увс	19394	24523	21600	21600		545418.5
5		Ховд	20817	27022	24101	24101		551573.8
6	Хангайн бүс	Архангай	19445	26830	25293	25293		796861.4
7		Баянхонгор	17722	22348	19426	19426		502727.8
8		Булган	20297	35850	33531	33531		1099737.2
9		Орхон	20097	25239	21756	21756		754126.0
10		Өвөрхангай	42578	61123	56223	56223		1370793.0
11		Хөвсгөл	24518	25237	22783	22783		652711.5
12	Төвийн бүс	Говьсүмбэр	23107	22477	21603	21602	1	624473.1
13		Дархан-Уул	29464	48965	45854	45854		1560279.3
14		Дорноговь	23083	25687	22756	22756		682793.3
15		Дундговь	18107	21018	20052	20052		663720.0

16		Өмнөговь	24738	36048	33103	33103		923657.3
17		Сэлэнгэ	23436	36150	32682	32682		1003784.5
18		Төв	36157	57821	55070	55070		1566882.7
19	ЗҮҮН БҮС	Дорнод	17532	19566	17211	17211		521584.0
20		Сүхбаатар	13232	15849	14279	14279		365035.0
21		Хэнтий	26380	30677	27629	27629		627403.2
22		Аймгуудын дүн	471799	628961	575945	575869	76	16313065.4
23		Баянгол	106099	127200	112868	112447	421	2129360.5
24		I хэлтэс	10210	12975	9110	9110		188715.0
25		II хэлтэс	17398	17548	14084	14084		176675.5
26		ЗЦ-ын хэлтэс	78491	96677	89674	89253	421	1763970.0
27		Баянзүрх	160200	204450	181014	178661	2353	3967899.3
28		I хэлтэс	8801	8896	3831	3831		147843.5
29		II хэлтэс	7840	10659	7358	7358		170979.0
30		III хэлтэс	5253	5576	2523	2523		108775.0
31		ЗЦ-ын хэлтэс	138306	179319	167302	164949	2353	3540301.8
32		Сүхбаатар	51795	76522	63708	62059	1649	1256830.0
33		I хэлтэс	6538	9194	7474	7474		104825.0
34		II хэлтэс	5807	4793	1247	1247		38675.0
35		ЗЦ-ын хэлтэс	39450	62535	54987	53338	1649	1113330.0
36		Сонгинохайрхан	62018	92865	70849	70420	429	1538414.2
37		I хэлтэс	8335	8601	3175	3175		37205.0
38		II хэлтэс	7020	7703	2600	2600		64849.0
39		III хэлтэс	12967	11114	8123	8123		87910.0
40		ЗЦ-ын хэлтэс	33696	65447	56951	56522	429	1348450.2
41		Хан-Уул	77400	93026	78808	78556	252	1826723.7
42		I хэлтэс	5869	5046	1943	1943		78460.0
43		II хэлтэс	11068	12888	9129	9129		145255.0
44		ЗЦ-ын хэлтэс	60440	75092	67736	67484	252	1603008.7
45		Чингэлтэй	65103	101312	88346	87218	1128	1668280.8
46		I хэлтэс	7409	4415	2246	2246		51110.8
47		II хэлтэс	7676	8791	5010	5010		78395.0
48		ЗЦ-ын хэлтэс	50018	88106	81090	79962	1128	1538775.0
49		Багануур	27154	37680	36457	36456	1	994751.5
50		Багахангай	11620	15810	15559	15557	2	565464.0
51		Налайх	35909	50545	48660	48660		1284510.0
52		Дүүргүүдийн дүн	597298	799410	696269	690034	6235	15232233.9
53	НХЖХОН АБХА	НХЖХГ	2901	4193	4191	4191		178463.5
54		ЭХГ						
55		ДЦШ	394	2075	2075	2075		87585.0
56	НЦУ Г	ХГХТХэлтэс	30	16				
57		ХЖХХэлтэс	939	4175	4175	4175		219555.5
58	ТЦА	ЗЦГ	965313	1203845	1202957	1134277	68680	30789488.3
59		ИАТЦХ	19236	31568	31557	31557		747866.5
60		ТЗЦГ	16419	27261	27044	27043	1	544325.0
61		ЭЦА	83	3257	3168	3168		104446.5
62		Албадан саатуулах төв		30				
63		Улсын дүн	2074412	2704791	2547381	2472389	74992	64217029.6

Зөрчлийн шийдвэрлэлт

Хоёр.Зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шалгасан зөрчил

Нийт зөрчил	Үүнээс:				
	Торгосон			Торгож, эрх хассан	Баривчилсан
	Хүн	Хуулийн этгээд	Торгуулийн хэмжээ /мян.төг/		

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2022

7	8	9	10	11	12
2230	1,191		412922.2	599	450
1709	624	5	377385.0	698	352
1599	747	3	317030.0	514	374
2923	1,771	16	524957.0	739	423
2921	1,524	21	532625.0	883	459
1537	324		301065.0	645	533
2922	1,304	4	547335.0	862	667
2319	1,203	3	397440.0	659	433
3483	1,134	18	806000.0	1,621	687
4900	2,526		569537.0	1,068	974
2454	892		473739.7	937	478
874	261	1	198470.0	404	202
3111	1003	25	756895.0	1,722	385
2931	1,398	28	654860.0	1038	486
966	399	4	208655.0	397	177
2945	1,360	22	696070.0	1,176	336
3468	1,578	11	670700.0	1116	642
2751	982	3	529250.0	1,190	567
2355	622	7	572705.5	1210	355
1570	740	10	322885.0	530	246
3048	1,377	1	548515.0	861	540
53016	22,960	182	10419041.4	18869	9,766
14332	9,665	33	2412685.0	3,620	854
3865	3,540	21	359720.0		241
3464	3,337	12	298010.0		211
7003	2788		1754955.0	3620	402
23436	14,088	72	3961550.0	6,087	2,879
5065	4,145	22	477795.0		862
3301	2,774	41	256480.0		529
3053	2,182	8	238840.0		845
12017	4987	1	2988435.0	6087	643
12814	7,763	40	2386825.0	4,006	868
1720	1,453	32	218130.0		136
3546	3,169	5	193235.0		297
7548	3141	3	1975460.0	4006	435
22016	15,694	7	2925092.5	4,033	2,059
5426	4,617		336440.0		644
5103	4,636	2	295160.0		484
2991	2,617	4	207760.0		363
8496	3824	1	2085732.5	4033	568
14218	9,060	37	2362350.0	3,530	989
3103	2,538	21	308285.0		192
3759	3,182	11	258185.0		426
7356	3340	5	1795880.0	3530	371
12966	7,070	26	2445355.0	4,425	1158
2169	1,805	26	199270.0		223
3781	3,300		218300.0		371
7016	1965		2027785.0	4425	564
1223	662	5	240085.0	382	204
251	112	1	47945.0	83	49
1885	891		440880.0	876	68
103141	65005	221	17222767.5	27042	9128
2	2		110.0		
16	2		405.0		8

888	724	4	128430.0	130	23
11	6	1	3300.0	4	
217	194	1	19960.0	6	6
89	89		8900.0		
30	19		2410.0		
157410	89001	409	27805323.9	46051	18931

6.Замын хөдөлгөөний аюулгүй байдал

6.1.Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол

Улсын хэмжээнд 2022 онд 101233 зам тээврийн осол бүртгэгдсэний 95409 буюу 94.2% нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

Улсын хэмжээнд 2022 онд зам тээврийн ослын шинжтэй 101233 дуудлага хүлээн авч, 24121 зам тээврийн осол бүртгэн шалгасан байна. Тухайн онд авто тээврийн хэрэгслийн тоо 2.4%-иар өсөж, зам тээврийн ослын шинжтэй дуудлага 21973 буюу 27.7%, зам тээврийн осол 1639 буюу 7.3 %-иар тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Зам тээврийн ослын шинжтэй дуудлага

Он	Улсын хэмжээнд ирүүлсэн дуудлагын тоо	Нийслэлд ирүүлсэн дуудлагын тоо	Орон нутагт ирүүлсэн дуудлагын тоо
2021	79260	73867	5393
2022	101233	95409	5824
Өссөн хувь	27.7%	29.2%	8.0%
Өссөн нэгж	21973	21542	431

Хүснэгт 5. Нийслэлд ирүүлсэн зам тээврийн ослын шинжтэй дуудлага

Нутаг дэвсгэр	Бүртгэгдсэн дуудлага	Өссөн тоо	Өссөн хувь
Хан-Уул дүүрэг	15460	4600	41.7%
Баянгол дүүрэг	18100	4656	34.6%
Баянзүрх дүүрэг	24747	5040	25.6%
Сүхбаатар дүүрэг	13226	3387	34.4%
Сонгинохайрхан дүүрэг	15190	2130	16.3%
Чингэлтэй дүүрэг	8266	1704	26.0%
Багануур дүүрэг	47	2	4.4 %
Багахангай дүүрэг	12	1	9.1%
Налайх дүүрэг	181	2201	13.8%

Хүснэгт 6. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол

Нутаг дэвсгэр	2022он	Өссөн тоо	Өссөн хувь
Улс	24121	1639	7.3%
Улаанбаатар хот	20322	1104	5.7%
Орон нутаг	3799	535	16.4%

Хүснэгт 7. Нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн ослын үзүүлэлт

Нутаг дэвсгэр	2022 он	Эзлэх хувь дүүргээр	Өссөн, буурсан тоо	Өссөн, буурсан хувь
Хан-Уул дүүрэг	3403	15,80%	372	12.3%
Баянгол дүүрэг	2973	16,80%	-251	-7.8%

Баянзүрх дүүрэг	5629	23,40%	1136	25,3 %
Сүхбаатар дүүрэг	2913	19,00%	-744	-20,3%
Сонгинохайрхан дүүрэг	3902	16,00%	831	27,1%
Чингэлтэй дүүрэг	1267	8,00%	-262	-17,1%
Багануур дүүрэг	44	1,10%	0	0,0 %
Багахангай дүүрэг	13		3	30,0%
Налах дүүрэг	178		19	11,9%

Дээрх хүснэгтээс үзэхэд нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн ослын 27.7% нь Баянзүрх дүүрэг, 14.6% нь Баянгол дүүрэг, 16.7% нь Сонгинохайрхан дүүрэг, 16.7% нь Хан-Уул дүүрэг, 14.3% нь Сүхбаатар дүүрэг, 6.2% Чингэлтэй дүүрэг, 1.2% нь алслагдсан 3 дүүрэгт тус тус бүртгэгджээ.

Хүснэгт 8. Орон нутагт бүртгэгдсэн зам тээврийн ослын үзүүлэлт

Нутаг дэвсгэр	ЗТО-ын дуудлага, мэдээллийн тоо
Баян-Өлгий	111
Увс	102
Ховд	153
Говь-Алтай	66
Баянхонгор	140
Завхан	107
Хөвсгөл	127
Архангай	158
Өвөрхангай	133
Өмнөговь	303
Орхон	165
Булган	173
Сэлэнгэ	232
Дархан-Уул	178
Төв	655
Улаанбаатар	470
Дундговь	244
Хэнтий	328
Говьсүмбэр	24
Дорноговь	244
Дорнод	141
Сүхбаатар	168

6.2.Бүртгэгдсэн зам тээврийн ослын улирал, сар, 7 хоног, цаг

Бүртгэгдсэн зам тээврийн ослыг:

- ❖ Эд материалын хохиролтой зам тээврийн осол
- ❖ Хүн гэмтсэн зам тээврийн осол гэж ангилан бүртгэлд авч байна.

Эд материалын хохиролтой зам тээврийн осол - зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдлыг авч үзэж байна.

Хүн гэмтсэн осол – зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдлыг авч үзэж байна.

Хүн гэмтсэн осол нь улсын хэмжээнд 3023 бүртгэгдсэнээс нийслэлд 1617 бүртгэсэн бол орон нутагт 1406, эд материалын хохиролтой осол нь улсын хэмжээнд 21098 бүртгэгдсэн бол нийслэлд 18705, орон нутагт 2393 тус тус бүртгэгдсэн байна.

Эд материалын хохиролтой осол

Улсын хэмжээнд 24121 зам тээврийн осол бүртгэн шалгасны 21098 буюу 87.5% нь эд материалын хохиролтой осол байхад 3023 буюу 12.5% нь хүн гэмтсэн /хүний амь нас, эрүүл мэнд хохирсон/ зам тээврийн осол байна.

Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн ослын 15.7% нь орон нутагт бүртгэгдсэн байх бөгөөд Баян-Өлгий, Дархан, Дорноговь, Дундговь, Орхон, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймагт зам тээврийн осол өсжээ.

Улсын хэмжээнд бүртгэсэн зам тээврийн ослын 20223 буюу 83.8% нь мөргөлдөх, 1498 буюу 6.2% нь явган зорчигчийг мөргөх, 1020 буюу 4.1% нь онхолдох /замын хажуу руу унах, өнхрөх г.м/ 875 буюу 3.6% нь үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, шон мөргөсөн/ 23 осол нь зорчигч унагах, 89 осол нь унадаг дугуйтай хүнийг мөргөх, 310 осол нь мал, амьтан дайрах, 119 осол нь бусад хэлбэрээр бүртгэсэн байна.

Хүснэгт 9. Бүртгэсэн зам тээврийн ослын хэлбэр

№	Он	Шалгуур үзүүлэлт	Онхолдох	Тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх	Тээврийн хэрэгслээр явган хүн дайрсан	Тээврийн хэрэгслээр дугуйтай хүн дайрсан	Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөсөн	Зорчигч унагасан	Мал амьтан дайрса	Бусад
Улсын хэмжээнд										
1	2022	Тоо эзлэх/ хувь	984 4,1	20223 83,8	1498 6,2	89 0,4	875 3,6	23 0,1	310 1,3	119 0,5
Улаанбаатар										
2	2022	Тоо эзлэх/ хувь	90 0,4	18214 89,6	1299 6,4	69 0,3	586 2,9	13 0,1	51 0,3	0 0,0
Орон нутаг										
3	2022	Тоо эзлэх/ хувь	894 23,5	2009 52,9	199 5,2	20 0,5	289 7,6	10 0,3	259 6,8	119 3,1

Улсын хэмжээнд явган зорчигч мөргөх хэлбэрээр гарсан зам тээврийн ослын 1299 буюу 86,7% нь нийслэлд бүртгэгдсэн.

Мөн улсын хэмжээнд онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн 984 ослын 894 буюу 90.1% нь орон нутгийн замд гарсан байна.

Монгол Улсад 2022 онд бүртгэсэн зам тээврийн осол гарсан хэлбэрийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад:

Нийслэлд: - мөргөлдөх, явган зорчигч мөргөх, мал амьтан дайрах хэлбэрээр бүртгэгдсэн осол өссөн байхад онхолдох, үл хөдлөх зүйл мөргөх, дугуйтай хүн дайрах, зорчигч унагах, бусад хэлбэрээр бүртгэгдсэн осол буурчээ.

Орон нутагт: - мөргөлдөх, үл хөдлөх зүйл мөргөх, мал амьтан дайрах хэлбэрээр бүртгэгдсэн осол өссөн байхад онхолдох, явган зорчигч мөргөх, зорчигч унагах, дугуйгаар зорчигч мөргөх хэлбэрээр бүртгэгдсэн осол буурчээ.

Нийслэл болон орон нутагт бүртгэгдсэн ослын хэлбэр

Нийслэлд:

- ❖ **Мөргөлдөх – 18214 буюу 89.6%**
- ❖ **Явган зорчигч мөргөх – 1299 буюу 6.4%**
- ❖ Онхолдох – 90 буюу 0.4%
- ❖ Зорчигч унагах – 13 буюу 0.1%
- ❖ Дугуйтай хүн мөргөх – 69 буюу 0.3%
- ❖ Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөх – 586 буюу 2.9%
- ❖ Мал, амьтан дайрах – 51 буюу 0.3% нь бүртгэгдсэн байна.

Орон нутагт:

- ❖ **Мөргөлдөх – 2009 буюу 52.9%**
- ❖ **Онхолдох – 894 буюу 23.5%**
- ❖ Явган зорчигч дайрах – 199 буюу 5.2%
- ❖ Зорчигч унагах – 10 буюу 0.3%
- ❖ Дугуйтай хүн мөргөх – 20 буюу 0.5%
- ❖ Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөх – 289 буюу 7.6%
- ❖ Мал амьтан дайрах – 259 буюу 6.8%
- ❖ Бусад хэлбэрээр – 199 буюу 3.1% нь бүртгэгдсэн байна.

Нийслэлд автомашин мөргөлдөх, явган зорчигч мөргөх хэлбэрийн зам тээврийн осол их бүртгэгдсэн бол харин орон нутагт автомашин мөргөлдөх, онхолдох хэлбэрээр осол их бүртгэгдсэн байна.

Зам тээврийн осол гарсан улирал

Зам тээврийн ослын 31.2% нь өвөл, 23.5% нь хавар, 20.3% нь зун, 25.0% нь намар бүртгэгджээ. Өвлийн улиралд замын гадаргуунд өөрчлөлт орох, халтиргаа гулгаанаас хамааралтай зам тээврийн ослын дуудлага өсдөг учир тухайн улиралд бүртгэгдсэн осол их байна. Хүний амь нас хохирсон осол зун болон намрын улиралд их бүртгэгдсэн нь жолоочийн бэлтгэгдсэн байдал, жолоочид харшлах эм бэлдмэлийн талаарх ойлголт, тухайн улиралд аялал зугаалга, хичээл сургалтын шилжилт хөдөлгөөн хийдэгтэй холбоотой байхад өвлийн улиралд ослын гэмтэл, бэртэл ихэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт 10. Бүртгэгдсэн зам тээврийн ослын үзүүлэлт улирлаар

Улирал	ЗТО-ын шинжтэй дуудлага	Бүртгэгдсэн бүх осол	ТХХАБАЖЭ гэмт хэрэг	Нас барсан хүн	Гэмтсэн хүн
Өвөл	26937 / 26.6	7522 / 31.2	7522 / 15.6	84 / 15.6	592 / 20.6
Хавар	24097 / 23.8	5658 / 23.5	153 / 28.4	153 / 28.4	732 / 25.4
Зун	20982 / 20.7	4907 / 20.3	167 / 31.0	167 / 31.0	737 / 25.6
Намар	29217 / 28.9	6034 / 25.0	135 / 25.0	135 / 25.0	818 / 28.4
Нийт	101233	24121	539	539	2879

Хүснэгт 11. Бүртгэгдсэн зам тээврийн осол гарсан сараар

Сар	Улс	Улаанбаатар	Орон нутаг
1 сар	2156	1867	289
2 сар	2405	2119	286
3 сар	1944	1656	288
4 сар	1818	1564	254
5 сар	1896	1590	306
6 сар	1778	1455	323
7 сар	1433	1032	401

8 сар	1696	1346	350
9 сар	2030	1659	371
10 сар	1988	1629	359
11 сар	2016	1718	298
12 сар	2961	2687	274

Хүснэгт 12. Бүртгэгдсэн зам тээврийн ослын улмаас учирсан хохирол сараар

Сар	Зам тээврийн ослын улмаас	
	Нас барсан хүн	Гэмтсэн хүн
1 сар	28	162
2 сар	21	193
3 сар	39	216
4 сар	52	236
5 сар	62	280
6 сар	53	246
7 сар	58	243
8 сар	56	248
9 сар	56	291
10 сар	48	278
11 сар	31	249
12 сар	35	237

Хүний амь нас хохирсон ослын бүртгэлээс үзэхэд 5 сар болон 7-9 сард хүний амь нас хохирсон тохиолдол их байна.

Зам тээврийн осол гарсан гараг, цагаар


Зам тээврийн ослын гаралт долоо хоногийн бүх өдрүүдэд жигд бүртгэгдсэн байна. Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад Баасан гаригт бүртгэгдсэн зам тээврийн осол өсөх хандлагатай байна.

- ❖ Даваа - 3652 буюу 15.1%
- ❖ Мягмар - 3399 буюу 14.1%
- ❖ Лхагва - 3615 буюу 15.0%
- ❖ Пүрэв - 3450 буюу 14.3%
- ❖ Баасан – 3675 буюу 15.2%
- ❖ Бямба – 3236 буюу 13.4%
- ❖ Ням – 3094 буюу 12.8% нь бүртгэгдсэн тоо гарч байна.

Хүснэгт 13. Зам тээврийн осол бүртгэгдсэн гараг

№	Шалгуур үзүүлэлт	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Улсын хэмжээнд								
1	Тоон үзүүлэлт	3652	3399	3615	3450	3675	3236	3094
	Эзлэх хувь	15.1	14.1	15.0	14.3	15.2	13.4	12.8
Улаанбаатар хотын хэмжээнд								
2	Тоон үзүүлэлт	3093	2894	3069	2907	3080	2695	2584
	Эзлэх хувь	15.2	14.2	15.1	14.3	15.2	13.3	12.7
Орон нутгийн хэмжээнд								
3	Тоон үзүүлэлт	559	505	546	543	595	541	510
	Эзлэх хувь	14.7	13.3	14.4	14.3	15.7	14.2	13.4

График 13. Зам тээврийн осол бүртгэгдсэн гараг



Зам тээврийн осол гарсан цаг хугацаа

Бүртгэгдсэн 24121 зам тээврийн осол гарсан цагийг бүлэглэн авч үзвэл:

- ❖ 07.00-12.00 цагийн хооронд 7165 буюу 29.7%,
- ❖ 13.00-18.00 цагийн хооронд 7939 буюу 32.9%,
- ❖ 19.00-00.00 цагийн хооронд 6639 буюу 27.5%,
- ❖ 01.00-06.00 цагийн хооронд 2378 буюу 9.9% нь бүртгэгджээ.

График 14. Хүний амь эрсэдсэн зам тээврийн осол бүртгэгдсэн цаг хугацаа



Хүснэгт 14. Зам тээврийн осол бүртгэгдсэн цаг хугацаа

ЗТӨ бүртгэгдсэн цаг хугацаа	Улсын хэмжээнд	Улаанбаатарт	Орон нутагт
	Тоо / эзлэх хувь		
07.00-12.00	7165 / 29.7	6378 / 31.4	778 / 20.7
13.00-18.00	7939 / 32.9	6710 / 33.0	1229 / 32.4
19.00-00.00	6639 / 27.5	5378 / 26.5	1252 / 33.0
00.00-06.00	2378 / 9.9	1847 / 9.1	531 / 14.0

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 24121 зам тээврийн ослын 18473 буюу 76.6% нь өдөр, 5648 буюу 21.6% нь шөнийн цагт бүртгэгджээ.

Хүний амь эрсэдсэн 481 зам тээврийн ослын 136 буюу 28.3% нь шөнө, 344 буюу 71.5% нь өдрийн цагт бүртгэгджээ. Улсын хэмжээнд хүний амь эрсэдсэн зам тээврийн ослыг бүлэг цагаар нь авч үзэхэд 07:00-12:00 цагт 102 буюу 21.2%, 13:00-18:00 цагт 137 буюу 28.5%, 19:00-00:00 цагт 172 буюу 35.8%, 01:00-06:00 цагт 70 буюу 14.6% нь тус тус бүртгэгджээ.

Хүснэгт 15. Зам тээврийн осол бүртгэгдсэн цагаар

Цаг	Үзүүлэлт тоо / эзлэх хувь								
	Улсын хэмжээнд			Нийслэлд			Орон нутагт		
1	547	2.3	416	2.0	131	3.4			
2	463	1.9	368	1.8	95	1.7			
3	395	1.6	310	1.5	85	2.2			
4	309	1.3	229	1.1	80	2.1			
5	327	1.4	256	1.3	71	1.9			
6	337	1.4	268	1.3	69	1.8			

7	819	3.4	724	3.6	95	2.5
8	1125	4.7	992	4.9	133	3.5
9	1271	5.3	1146	5.6	125	3.3
10	1457	6.0	1328	6.5	129	3.4
11	1285	5.3	1143	5.6	142	3.7
12	1208	5.0	1045	5.1	163	4.3
13	1362	5.6	1191	5.9	171	4.5
14	1268	5.3	1081	5.3	187	4.9
15	1228	5.1	1023	5.0	205	5.4
16	1414	5.9	1200	5.9	214	5.6
17	1338	5.5	1115	5.5	223	5.9
18	1329	5.5	1100	5.4	229	6.0
19	1215	5.0	985	4.8	230	6.1
20	1149	4.8	887	4.4	262	6.9
21	1005	4.2	805	4.0	200	5.3
22	956	4.0	758	3.7	198	5.2
23	889	3.7	658	3.2	231	6.1
24	1425	5.9	1294	6.4	131	3.4

Улсын хэмжээнд 2022 онд зам тээврийн осолд зам орчны нөхцөл байдлын мэдээлэл тодорхой орсон 24121 зам тээврийн осолд дараах байдлаар зам орчны үзүүлэлтийг гарган харуулав.

Хүснэгт 16. Зам тээврийн осол гарсан зам, орчин, цаг агаарын байдал

№	Цаг агаарын нөхцөл байдал	Ослын тоо	Эзлэх хувь
1	Таатай үед	21546	89.3
2	Цастай	1493	6.2
3	Үүлэрхэг	698	2.9
4	Манантай	20	0.1
5	Шуургатай	68	0.3
6	Бороотой	296	1.2

Хүснэгт 17. Зам тээврийн осол гарсан зам, орчин, цаг агаарын байдал

№	Үзэгдэх орчин	Ослын тоо	Эзлэх хувь
1	Чөлөөтэй	16560	68,7
2	Хязгаарлагдмал	649	2,7
3	Зорчих хэсэг гэрэлтүүлэггүй	1426	5,9
4	Зорчих хэсэг гэрэлтүүлэгтэй	5275	21,9
5	Хангалтгүй	211	0,9

Хүснэгт 18. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын гадаргуу	Ослын тоо	Эзлэх хувь
1	Хуурай	19742	81.8
2	Нойтон	2402	10.0
3	Мөстөй	1872	7.8
4	Бохирдсон	51	0.2

Хүснэгт 19. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын онцлог	Ослын тоо	Эзлэх хувь
1	Тэгш	19733	81.8
2	Хазгай	375	1.6
3	Шулуун	2655	11.0
4	Өгсүүр	553	2.3
5	Уруу	671	2.8
6	Огцом эргэлттэй	134	0.6

Хүснэгт 20. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын ангилал	Ослын тоо	Эзлэх хувь
1	Ердийн	21167	87.8
2	Хорооллын	2555	10.6
3	Тууш	357	1.5
4	Хурдны	42	0.2

Хүснэгт 21. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын хучилт	Ослын тоо	Эзлэх хувь
1	Хатуу хучилттай	21821	90.5
2	Цемент	250	1.0
3	Бетон	85	0.4
4	Сайжруулсан	451	1.9
5	Хөрсөн	1252	5.2
6	Хайрган	262	1.1

Хүснэгт 22. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын хучилт	Ослын тоо	Эзлэх хувь
1	Авто зам /Зорчих хэсэг/	0	0
2	Явган зорчигчийн гарц	410	1.7
3	Автобусны буудал дээр	218	0.9
4	Төмөр замын гарам дээр	22	0.1
5	Гүүрэн дээр	112	0.5
6	Хонгил	25	0.1
7	Уулзвар	4053	16.8

Хүснэгт 23. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын өргөн	Ослын тоо	Эзлэх хувь
1	3.5 м хүртэл	383	1.6
2	3.5-5.5 м	981	4.1
3	5.5-7.0 м	4511	18.7
4	7.0-9.0 м	8928	37.0
5	9.0-12.0 м	6136	25.4

6	12.0-16.0 м	2342	9.7
7	16.0-20.0 м	612	2.5
8	20 м-с дээш	228	0.9


6.3. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг болон зам тээврийн ослын улмаас учирсан хохирол

Хүснэгт 24. Бүртгэгдсэн гэмт хэрэг харьцуулалт

Он	Бүх төрлийн гэмт хэрэг			Хөдөлгөөний аюулгүй байдал, Тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг		
	Тоон үзүүлэлт					
	Улс	Улаанбаатар	Орон нутаг	Улс	Улаанбаатар	Орон нутаг
2021	25429	16534	8895	915	915	472
2022	35340	24310	11030	1220	595	625

Бүртгэгдсэн гэмт хэргийн 1220 буюу 3.5%-ийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 33.3%-иар өсжээ. Энэ төрлийн гэмт хэрэг нь өнгөрсөн оны нийт гэмт хэргийн 4.3%-ийг эзэлж байсан бол 2022 онд ижил үзүүлэлтэй байна.

График 15. Бүртгэгдсэн гэмт хэргийн харьцуулалт



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2022 онд 1220 бүртгэгдсэнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад улсын хэмжээнд 33.3%, орон нутагт 32.4%-иар тус тус буурсан бол нийслэлд 34.3%-иар өсжээ. Мөн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 595 буюу 48.8% нь орон нутагт, 625 буюу 51.2% нь нийслэлд бүртгэгдсэн байна.

Хүснэгт 25. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхцөл байдал

Д/Д	Аймаг, дүүрэг	Бүртгэсэн гэмт хэрэг			Нас барсан хүн			Гэмтсэн хүн		
		2022 он	Өсөлт, бууралт /тоогоор/	Өсөлт, бууралт /хувиар/	2022 он	Өсөлт бууралт /тоогоор/	Өсөлт бууралт /хувиар/	2022 он	Өсөлт бууралт /тоогоор/	Өсөлт бууралт хувиар
1	Архангай	25	-1	-3.8	11	-1	-8.3	19	-3	-13.6
2	Баян-өлгий	24	8	50.0	6	-3	-33.3	20	7	53.8
3	Баянхонгор	27	8	42.1	8	1	14.3	20	8	66.7
4	Булган	29	5	20.8	15	0	0.0	15	-3	-16.7
5	Говь-алтай	13	-2	-13.3	6	3	2	9	-5	-35.7
6	Говьсүмбэр	3	-2	-40.0	0	-2		7	4	2.3
7	Дархан-уул	33	17	2.1	8	5	2.7	24	5	71.4

8	Дорноговь	32	13	68.4	9	4	80.0	30	11	57.9
9	Дорнод	23	-4	-14.8	6	-6	-50.0	21	7	50.0
10	Дундговь	18	-2	-10.0	3	-1	-25.0	12	0	0.0
11	Завхан	26	11	73.3	13	7	2.2	20	7	53.8
12	Орхон	21	-1	-4.5	3	-2	40.0	18	-3	-14.3
13	Өвөрхангай	35	9	34.6	22	15	3.1	18	-3	-14.3
14	Өмнөговь	34	4	13.3	17	12	3.4	29	0	0.0
15	Сүхбаатар	30	14	87.5	8	2	33.3	26	13	2
16	Сэлэнгэ	42	5	13.5	14	5	55.6	45	6	15.4
17	Төв	84	34	68.0	28	12	75.0	65	29	80.6
18	Увс	21	7	50.0	9	2	28.6	11	2	22.2
19	Ховд	40	9	29.0	16	5	45.5	32	10	45.5
20	Хөвсгөл	31	5	19.2	13	3	30.0	22	-8	-26.7
21	Хэнтий	34	6	88.9	9	-1	-10.0	24	11	84.6
22	Баянгол	80	28	53.8	6	-1	-14.3	75	28	59.6
23	Баянзүрх	919	23	24.0	9	1	12.5	112	23	25.8
24	Сүхбаатар	82	32	64.0	4	-3	-42.9	79	31	64.6
25	Сонгинохайрхан	134	25	22.9	23	-7	-23.3	123	37	43.0
26	Хан-уул	100	25	33.3	9	-5	-35.7	92	29	46.0
27	Чингэлтэй	59	12	25.5	2	-5	-71.4	57	17	42.5
28	Багануур	8	5	2.7	2	2		6	3	2
29	Багахангай	2	2	2.7		0		2	2	
30	Налайх	11	0	0	1	0	0.0	8	-3	-27.3

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 595 буюу 48.8% нь нийслэлд, 625 буюу 51.2% нь орон нутагт бүртгэгдсэн байна.

6.4.Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед үйлдэгдсэн зам тээврийн осол, учирсан хохирол

Улсын хэмжээнд 2022 онд жолооч архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс зам тээврийн 1210 осол үйлдэгдэж, явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцохдоо зам тээврийн осолд өртөж хохирсон 179 осол бүртгэгдсэн.

Монгол Улсад 2022 онд бүртгэгдсэн нийт зам тээврийн осол өссөн бол согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн ослын гаралт 18.2%-иар буурчээ.

Хүснэгт 26.Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн ослын нөхцөл байдал

№	Зам тээврийн осол	Нийт осолд эзлэх хувь	Явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсон	
			Нийт осолд эзлэх хувь	Нийт осолд эзлэх хувь
Улсын хэмжээнд				
1	1210	5.0	198	0.8
Улаанбаатар				
2	635	3.1	179	0.9
Орон нутаг				
3	575	15.1	19	0.5

Согтуугаар үйлдсэн зам тээврийн ослын 635 буюу 52.5% нь Улаанбаатарт, 575 буюу 47.5% нь орон нутагт бүртгэгдсэнээс гадна орон нутагт бүртгэгдсэн нийт ослын 15.1% нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос гарчээ.

График 16. Согтуугаар үйлдэгдсэн ослын нөхцөл байдал




График 17. Согтуугаар үйлдэгдсэн ослын нөхцөл байдал



2022 онд согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс 1210 зам тээврийн осол бүртгэгдэж, түүний улмаас 123 хүний амь нас хохирч, 210 хүн гэмтэж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 2 тэрбум 97.2 сая төгрөгийн хохирол учирсан.

Улсын хэмжээнд явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцож өртөж хохирсон 179 осол бүртгэгдсэн.

Хэнтий, Сэлэнгэ, Увс, Булган зэрэг аймагт согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн осол бусад аймагтай харьцуулахад их бүртгэгдсэн. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос үүдсэн осол 18.2%-иар буурсан ч согтуугаар хүний амь нас хохироосон осол 16%-иар өссөн үзүүлэлттэй байна. Орон нутгийн замд бүртгэгдсэн ослын улмаас Төв аймагт 15, Өвөрхангай аймагт 14, Хэнтий аймагт 11 хүн амь насаа алдсан нь бусад аймгаас их байна. Улаанбаатарт согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас Баянзүрх дүүрэгт 6 хүний амь нас, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгт тус бүр 3, Баянгол, Багануур дүүргүүдэд 2, Чингэлтэй дүүрэгт 1 хүний амь нас хохирчээ.

Согтуугаар үйлдэгдсэн осолд өртөж, хохирсон 333 хүний насны байдлыг авч үзвэл: 0-17 насны 37 хүн буюу 11.1%, 18-30 насны 65 хүн буюу 19.5%, 31-35 насны 53 хүн буюу 15.9%, 36-аас дээш насны 178 хүн буюу 53.5%-ийг эзэлж байна.

Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас 100 буюу 30.1% нь эмэгтэй, 233 буюу 69.9% нь эрэгтэй хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирчээ. Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн осолд өртөж гэмтсэн хүний 12 буюу 5.7% хөнгөн, 144 буюу 68.6% нь хүндэвтэр, 54 буюу 25.7% нь хүнд гэмтэл авчээ.

Хүснэгт 27. Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас учирсан хохирол

№	Насны байдал								Хүйсийн байдал			
	Нас барсан хүн				Гэмтсэн хүн				Нас барсан хүн		Гэмтсэн хүн	
	0-17 нас	18-30 нас	31-35 нас	36-аас дээш	0-17 нас	18-30 нас	31-35 нас	36-аас дээш	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
Улсын хэмжээнд												
1	15	23	19	66	22	42	34	112	25	98	75	135
Нийслэлд												
2		3	4	10	10	13	9	29	1	16	19	42
Орон нутагт												
3	15	20	15	56	12	29	25	83	24	82	56	93

Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн ослын улмаас амь нас, эрүүл мэндээрээ хохирсон хүний 93 буюу 27.9% нь явган зорчигч, 145 буюу 43.5% нь тээврийн хэрэгслээр зорчигч, 95 буюу 28.5% нь жолооч байна.


Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас 50 жолооч, 25 явган зорчигч, 48 тээврийн хэрэгслээр зорчигч нас барсан байна.

Хүснэгт 28. Замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр

№	Нас барсан хүн			Гэмтсэн хүн		
	Явган зорчигч	Зорчигч	Жолооч	Явган зорчигч	Зорчигч	Жолооч
Улсын хэмжээнд						
1	25	48	50	68	97	45
Нийслэлд						
2	7		10	24	23	14
Орон нутагт						
3	18	48	40	44	74	31

Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос орон нутагт 106 хүн, нийслэлд 17 хүн нас барсан бол орон нутгийн замд бүртгэгдсэн ослын улмаас Төв, Өмнөговь, Хэнтий аймаг болон нийслэлд Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт хүн нас барсан осол их бүртгэгджээ.

График 18. Согтуугаар үйлдсэн ослын улмаас хохирогч нас барсан тохиолдол



Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох нь жолооч хурд хэтрүүлэх, гэрэл дохио болон өөдөөс ирэх саадыг анзаарахгүй, зогсоох арга хэмжээ авч чадахгүй, анхаарал төвлөрөхгүй байх зэргээр жолоочийн самбаачлах хугацаа болон өөрийгөө хянах чадварт муугаар нөлөөлж ноцтой зам тээврийн осол гарах үндэс болдог.

Согтууруулах ундаа нь автомашин жолоодож буй хүний оюун ухаан, жолоодох ур чадвар, самбаачлах хугацаа, оюун санаанд шууд нөлөөлдөг учраас согтолт их байх тусам эрсдэл нь өндөр байдаг.

6.5. Гэмт хэрэг болон зам тээврийн ослын улмаас учирсан хохирол

Улсын хэмжээнд 35340 гэмт хэргийн улмаас 766 хүн нас барсан нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 12.2%-иар өссөн. Гэмт хэргийн улмаас нас барсан 766 хүний 280 буюу 36.6% нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан байна.

Нас барсан хүний тоон үзүүлэлтийг:

- ❖ Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн
- ❖ Гэмт хэргийн улмаас нас барсан хүн гэж ангилан авч үздэг.

Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн - Зам тээврийн ослын улмаас газар дээрээ болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нас барсан хүн буюу бодит нас баралтын тоон үзүүлэлтийг авч үзсэн.

Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүн - Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас боловсруулан гаргасан үзүүлэлт буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтаар хэрэгсэхгүй болгосон хэрэг болон хохирлыг хасаж тооцсон тоон үзүүлэлтийг авч үзсэн.

Хүснэгт 29. Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний харьцуулалт

№	Харьяалал	ХАБТХАЖЭГэмт хэргийн улмаас гэмтсэн хүн				
		2018	2019	2020	2021	2022
1	Хан-Уул дүүрэг	70	77	53	63	29
2	Баянгол дүүрэг	75	79	45	47	75
3	Баянзүрх дүүрэг	96	118	84	89	112
4	Сүхбаатар дүүрэг	67	72	63	48	79
5	Сонгинохайрхан дүүрэг	84	143	84	86	123
6	Чингэлтэй дүүрэг	43	46	33	40	17
7	Нийслэлд	435	535	362	373	435

Хүснэгт 30. Зам тээврийн ослын улмаас хүүхэд хохирсон талаарх харьцуулалт

№	Харьяалал	Хүүхэд өртсөн зам тээврийн осол				
		2018	2019	2020	2021	2022
1	Хан-Уул дүүрэг	108	69	48	41	76
2	Баянгол дүүрэг	130	84	42	25	60
3	Баянзүрх дүүрэг	187	132	81	57	94
4	Сүхбаатар дүүрэг	123	66	30	24	67
5	Сонгинохайрхан дүүрэг	158	133	67	55	93
6	Чингэлтэй дүүрэг	87	59	24	28	39
7	Нийслэлд	793	543	292	230	429

Хүснэгт 31. Явган зорчигч өртсөн, хохирсон зам тээврийн ослын тоон үзүүлэлт

Он	Осолд өртсөн нийт хүн			Үүнээс Явган зорчигч			Нийт осолд өртсөн хүнд явган зорчигчийн эзлэх хувь явган зорчигч	Нас барсан хүн			Үүнээс Явган зорчигч			Гэмтсэн хүн	Үүнээс Явган зорчигч			Явган зорчигчийн буруутай үйлдлээс гарсан осол						
	Улс	Хот	Орон нутаг	Улс	Хот	Орон нутаг		Улс	Хот	Орон нутаг	Улс	Хот	Орон нутаг		Улс	Хот	Орон нутаг		Улс	Хот	Орон нутаг			
																						2018	2019	2020
2018	5323	3901	1422	2633	2394	239	49.5	61.4	16.8	562	140	422	132	82	50	4761	3761	1000	2501	2312	189	632	549	83
2019	4351	2836	1515	2089	1704	385	48	60.1	25.4	561	131	430	140	88	52	3790	2705	1085	1949	1616	333	530	451	79
2020	3178	1833	1315	1393	1070	323	43.8	58.4	24.6	460	111	119	163	82	81	2718	1722	996	1230	988	242	532	417	116
2021	2858	1617	1241	1224	947	277	42.8	58.6	22.3	383	116	267	129	72	57	2475	1501	974	1095	875	220	442	379	63
2022	3418	1869	1522	1570	1360	210	45.9	71.7	13.8	539	86	453	117	54	63	2879	1810	1069	1453	1306	147	719	612	107

Хүснэгт 32. Гэмт хэргийн улмаас нас барсан хүний харьцуулалт

№	Харьяалал	Гэмт хэргийн улмаас амь эрсдсэн хүн				
		2018	2019	2020	2021	2022
1	Хан-Уул дүүрэг	15	12	12	7	9
2	Баянгол дүүрэг	3	3	5	8	6
3	Баянзүрх дүүрэг	15	21	14	7	9
4	Сүхбаатар дүүрэг	8	9	6	30	4
5	Сонгинохайрхан дүүрэг	29	28	25	14	23
6	Чингэлтэй дүүрэг	9	5	5	7	2
7	Нийслэлд	79	78	67	73	53

Хүснэгт 33. Зам тээврийн ослын шинжтэй дуудлагын харьцуулалт

№	Харьяалал	Зам тээврийн ослын шинжтэй дуулага				
		2018	2019	2020	2021	2022
1	Хан-Уул дүүрэг	9551	10174	9548	11040	15640
2	Баянгол дүүрэг	15382	14118	11252	13444	18100
3	Баянзүрх дүүрэг	20082	19259	16265	19707	24747
4	Сүхбаатар дүүрэг	12324	11203	8477	9839	13226
5	Сонгинохайрхан дүүрэг	12345	11986	10780	13060	15190
6	Чингэлтэй дүүрэг	7442	7071	5736	6562	8266
7	Нийслэлд	77126	72811	61058	73652	95169

Хүснэгт 34. Бүртгэгдсэн зам тээврийн ослын харьцуулалт

№	Харьяалал	Зам тээврийн осол				
		2018	2019	2020	2021	2022
1	Хан-Уул дүүрэг	3680	3671	2776	3031	3403
2	Баянгол дүүрэг	5516	4823	3116	3224	2973
3	Баянзүрх дүүрэг	5863	4508	3753	4493	5629
4	Сүхбаатар дүүрэг	3339	2537	3644	3657	2913
5	Сонгинохайрхан дүүрэг	4567	4289	3625	3071	3902
6	Чингэлтэй дүүрэг	2489	1706	1301	1529	1267
7	Нийслэлд	25454	21604	18215	19005	20087

Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан, гэмтсэн хүн, учирсан хохирол

2022 онд 24121 зам тээврийн ослын улмаас 3418 хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирчээ. Мөн зам тээврийн осолд өртсөн 3418 хүний 539 буюу 15.8% нь нас барж, 2879 буюу 84.2% нь гэмтэж, эрүүл мэндээрээ хохирсон байна.

Хүснэгт 35. Бүртгэгдсэн гэмт хэргийн харьцуулалт

№	Харьяалал	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг				
		2018	2019	2020	2021	2022
1	Хан-Уул дүүрэг	79	83	65	75	100
2	Баянгол дүүрэг	77	78	43	52	80
3	Баянзүрх дүүрэг	108	130	95	96	119
4	Сүхбаатар дүүрэг	64	50	64	50	82
5	Сонгинохайрхан дүүрэг	101	145	104	109	134
6	Чингэлтэй дүүрэг	51	50	36	47	59
7	Нийслэлд	480	565	413	429	574

Хүснэгт 36. Зам тээврийн ослын улмаас учирсан хохирол

Он	Зам тээврийн осол			Зам тээврийн ослын улмаас								
	Улс	Хот	Орон нутаг	Өртсөн хүн			Нас барсан хүн			Гэмтсэн хүн		
				Улс	Хот	Орон нутаг	Улс	Хот	Орон нутаг	Улс	Хот	Орон нутаг
2021	22482	19218	3264	2858	16147	1241	383	116	267	2475	1501	974
2022	24121	20322	3799	1896	1522	1522	539	86	453	2879	1810	1069

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2022

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 1220 гэмт хэргийн улмаас 1321 хүн хохирсны 280 буюу 21.2% нь нас барж, 1041 буюу 78.8% нь хүнд, хүндэвтэр гэмтсэн байна.

Хүснэгт 37. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол


Он	Гэмт хэрэг			Гэмт хэргийн улмаас								
	Улс	Хот	Орон нутаг	Хэрэгт өртсөн хүн			Нас барсан хүн			Гэмтсэн хүн		
				Улс	Хот	Орон нутаг	Улс	Хот	Орон нутаг	Улс	Хот	Орон нутаг
2021	915	443	472	1012	461	551	238	74	164	774	387	387
2022	1220	595	625	1321	610	711	280	56	224	1041	554	487

График 19. 2022 оны байдлаар нас барсан хүн



Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг болон зам тээврийн ослын улмаас нас барсан хүний 453 буюу 84.1% нь орон нутагт, 86 буюу 15.9% нь Нийслэлд байна.

График 20. 2022 оны байдлаар гэмтсэн хүн



Хүснэгт 38. Нас барсан хүн төв, орон нутаг харьцуулалт

Д/д	Төв, орон нутаг	Нас барсан осол			Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн			Гэмт хэргийн улмаас нас барсан хүн		
		2022	Өсөлт бууралт /тоогоор/	Өсөлт бууралт /хувиар/	2022	Өсөлт бууралт /тоогоор/	Өсөлт бууралт /хувиар/	2022	Өсөлт бууралт /тоогоор/	Өсөлт бууралт /хувиар/
1	Архангай	26	12	85.7	26	10	622.5	11	-1	-8.3
2	Баян-Өлгий	7	-8	-53.3	7	-10	-58.8	6	-3	-33.3
3	Баянхонгор	22	11	2д	29	18	2.6 д	8	1	14.3

4	Булган	25	9	56.3	25	7	38.9	15	0	0.0
5	Говь-Алтай	15	9	2.5 д	16	8	2 д	6	3	2 д
6	Говьсүмбэр	1	-3	-75.0	1	-3	-75.0		-2	
7	Дархан-Уул	10	8	5 д	10	7	3.3 д	8	5	2.7 д
8	Дорноговь	15	7	87.5	17	9	2.1 д	9	4	80.0
9	Дорнод	9	-8	-47.1	12	-5	-29.4	6	-6	-50.0
10	Дундговь	24	17	3.4 д	26	19	3.7 д	3	-1	-25.0
11	Завхан	15	7	87.5	20	11	2.2 д	13	7	2.2 д
12	Орхон	5	-1	-16.7	5	-1	-16.7	3	-2	-40.0
13	Өвөрхангай	29	13	81.3	34	15	78.9	22	15	3.1 д
14	Өмнөговь	28	9	47.4	34	10	41.7	17	12	3.4 д
15	Сүхбаатар	14	5	55.6	14	4	40.0	8	2	33.3
16	Сэлэнгэ	22	11	2 д	27	13	92.9	14	5	55.6
17	Төв	50	27	2.2 д	62	37	2.5 д	28	12	75.0
18	Увс	16	8	2 д	16	8	2 д	9	2	28.6
19	Ховд	19	3	18.8	23	6	35.3	16	5	45.5
20	Хөвсгөл	24	15	2.7 д	27	17	2.7 д	13	3	30.0
21	Хэнтий	21	7	50.0	22	6	37.5	9	-1	-10.0
22	Баянгол	7	-1	-12.5	7	-1	-12.5	6	-1	-14.3
23	Баянзүрх	19	9	90.0	19	9	90.0	9	1	12.5
24	Сүхбаатар	4	-7	-63.6	4	-8	-66.7	4	-3	-42.9
25	Сонгинохайрхан	30	-15	-33.3	32	-17	-34.7	23	-7	-23.3
26	Хан-Уул	14	-10	-41.7	14	-10	-41.7	9	-5	-35.7
27	Чингэлтэй	7	0	0.0	7	0	0.0	2	-5	-71.4
28	Багануур	2	0	0.0	2	0	0.0	2	2	
29	Багахангай	0	0			0			0	
30	Налайх	1	-3	-75.0	1	-3	-75.0	1	0	0.0
	Улаанбаатарт	84	-27	-24.3	86	-30	-25.9	56	-18	-24.3
	Орон нутагт	397	158	66.1	453	186	69.7	224	60	36.6
	Улсын хэмжээнд	481	131	37.4	539	156	40.7	280	42	17.6

Хүснэгт 39. Гэмтсэн хүн төв, орон нутаг харьцуулалт

Д/д	Аймаг, дүүрэг	Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн			Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн		
		2022	Өсөлт, бууралт /тоооор/	Өсөлт, бууралт /тоооор/	2022	Өсөлт, бууралт /тоооор/	Өсөлт, бууралт /хувьар/
1	Архангай	53	-17	-24.3	19	-3	-13.6
2	Баян-Өлгий	59	32	118.5	20	7	53.8
3	Баянхонгор	75	46	158.6	20	8	66.7
4	Булган	32	-9	-22.0	15	-3	-16.7
5	Говь-Алтай	16	-6	-27.3	9	-5	-35.7
6	Говьсүмбэр	9	-10	-52.6	7	4	32.3 д
7	Дархан-Уул	73	-1	-1.4	24	10	71.4
8	Дорноговь	58	16	38.1	30	11	57.9
9	Дорнод	70	3	4.5	21	7	50.0
10	Дундговь	42	7	20.0	12	0	0.0
11	Завхан	42	2	5.0	20	7	53.8
12	Орхон	54	-6	-10.0	18	-3	-14.3

13	Өвөрхангай	39	7	21.9	18	-3	-14.3
14	Өмнөговь	31	-2	-6.1	29	0	0.0
15	Сүхбаатар	511	18	54.5	26	13	2 д
16	Сэлэнгэ	84	14	20.0	45	6	14.3
17	Төв	119	3	2.6	65	29	80.6
18	Увс	42	2	5	11	2	22.2
19	Ховд	25	-11	-30.6	32	10	45.5
20	Хөвсгөл	33	-8	-19.5	22	-8	-26.7
21	Хэнтий	62	15	31.9	24	11	84.6
22	Баянгол	252	81	47.4	75	28	59.6
23	Баянзүрх	398	47	13.4	112	23	25.8
24	Сүхбаатар	275	92	50.3	79	31	4.6
25	Сонгинохайрхан	346	-33	-8.7	123	37	43.0
26	Хан-Уул	307	56	23.3	92	29	46.0
27	Чингэлтэй	177	38	27.3	57	17	42.5
28	Багануур	30	21	233.3	6	3	2 д
29	Багахангай		3	300.0	2	2	
30	Налайх	21	4	23.5	8	-3	-27.3
	Улаанбаатарт	1810	309	20.6	554	167	43.2
	Орон нутагт	1069	95	9.8	487	100	25.8
	Улсын хэмжээнд	2879	404	16.3	1041	267	34.5

6.6.Зам тээврийн ослын шалтгаан нөхцөл

Зам тээврийн ослыг:

- ❖ Жолоочийн буруутай үйлдэл;
- ❖ Явган зорчигчийн буруутай үйлдэл;
- ❖ Замын нөхцөл;
- ❖ Техникийн гэмтлээс шалтгаалсан осол гэж ангилна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 24121 зам тээврийн ослын 23277 буюу 96.5% нь жолоочийн буруугаас, 719 буюу 3% нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 125 буюу 0.5% нь замын нөхцөлөөс шалтгаалсан гэж бүртгэгджээ.

Хүснэгт 40. Зам тээврийн ослын шалтгаан

Он	Харьяалал	Жолоочийн буруугаас	Замын нөхцөлөөс	Явган зорчигчийн буруугаас
	Улсын хэмжээнд			
	Нийт ослын тоо	23277	125	719
	нийт осолд эзлэх хувь	96.5	0.5	3.0
	Нийслэлд			
2022	Нийт ослын тоо	19583	110	629
	нийт осолд эзлэх хувь	96.4	0.5	3.1
	Орон нутагт			
	Нийт ослын тоо	3694	15	90
	нийт осолд эзлэх хувь	97.2	0.4	2.4

Зам тээврийн ослын шалтгааныг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад: жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол 53.8%-иар, замын нөхцөлөөс шалтгаалсан осол 2.6%-иар, явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол 62.7%-иар тус тус өсжээ.

Бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгааны 96.5% нь жолоочийн буруутай үйлдлээс болсон байна.

Жолоочийн буруутай ослын шалтгаанаас:

- Хажуу хоорондын зай тохируулаагүйгээс 7760 буюу 32.2%,

- Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн 4352 буюу 18%,
- Эгнээ байр буруу эзэлсэн 2307 буюу 9.6%,
- Ухрах үйлдэл буруу хийсэн 1679 буюу 7%-ийг эзэлсэн байна.

Хүснэгт 41. Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол

Үзүүлэлт	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	Хурд хэтрүүлсэн	Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	Анхаарал болгоомжгүй	Зогсоох арга хэмжээ аваагүй	Уулзвар нэвтрэх	Гэрэл дохио	Эргэх үйлдэл	Зай тохируулаагүй	Гүйцэж түрүүлэх	Эсрэг урсгал	Эгнээ байр	Хүн ба тээвэрлэх журам зөрчсөн	Ухрах	Бусад
Улсын хэмжээнд															
Тоон үзүүлэлт	1210	861	160	3053	773	4352	216	160	7760	195	172	2307	75	1679	304
Эзлэх хувь	5.2	3.7	0.7	13.1	3.3	18.7	0.9	0.7	33.3	0.8	0.7	9.9	0.3	7.2	1.3
Нийслэлд															
Тоон үзүүлэлт	635	580	35	2380	259	3976	168	73	7538	62	76	2167	47	1521	83
Эзлэх хувь	3.2	3.0	0.2	12.1	1.3	20.3	0.9	0.4	38.5	0.3	0.4	11.1	0.2	7.8	0.4
Орон нутагт															
Тоон үзүүлэлт	560	302	147	590	453	253	20	51	176	123	74	127	20	135	143
Эзлэх хувь	17.6	9.5	4.6	18.6	14.3	8	0.6	1.6	5.5	3.9	2.3	4	0.6	4.3	4.5

Хүснэгт 42. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн насны байдал

Нас	Тоо	Эзлэх хувь
12/13/	3	0.4
14-15	6	0.6
16-17	9	0.9
18-24	161	15.3
25-29	154	14.6
30-34	206	19.5
35-39	148	14.0
40-44	118	11.2
45-49	98	9.33
50-54	60	5.7
55-59	46	4.4
60-64	28	2.7
65-69	14	1.3
70-с дээш	6	0.6

Хүснэгт 43. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн нийгмийн байдал

Нийгмийн байдал	Холбогдогчийн тоо	Эзлэх хувь
Төрийн албан хаагч	89	8.4
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	281	26.7
Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	132	12.5
Төрийн бус байгууллагын ажилтан	41	3.9
Малчин	86	0.4
Ажилгүй	385	36.5
Оюутан	27	2.6

Сурагч	9	0.9
--------	---	-----

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон хүний 385 буюу 36.5% эрхэлсэн тодорхой ажилгүй хүн байна. Өнгөрсөн онд 16 сурагч энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байсан бол 2022 онд 9 болж 77.7%-иар буурсан байна.

Явганаар замын хөдөлгөөнд оролцож яваад зам тээврийн осолд өртөж хохирсон хүмүүсийн 632 буюу 40.3% нь ажилгүй, 479 буюу 30.5% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна.

Хүснэгт 44. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн боловсролын байдал


Боловсрол	Холбогдогчийн тоо	Эзлэх хувь
Бүрэн дунд	513	48.7
Дээд	285	27.0
Бага	42	4.0
Тусгай мэргэжлийн дунд	60	5.7
Боловсролгүй	19	1.8
Бүрэн бус дунд боловсролтой	135	12.8

Боловсролын хувьд гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 48.7% нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байна.

Явган зорчигчийн буруугаас шалтгаалсан осол:

- ❖ Явган хүний гарцын шугам, гарамгүй газраар зам хөндлөн гарах
- ❖ Гэрлэн дохио зөрчиж зам хөндлөн гарах
- ❖ Ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур зам хөндлөн гүйх
- ❖ Зогсож буй автомашины урдуур буюу автобуснаас буугаад урдуур нь замын зорчих хэсэгт орох
- ❖ Замын зорчих хэсэг дээр буюу зорчих хэсгийн захаар дагаж явах, согтууруулах ундаа хэрэглэж биеэ авч явах чадваргүй үедээ замын зорчих хэсэг дээгүүр явах, хэвтэх
- ❖ Замын голоор тавьсан тусгаарлах хайс, хашлага дээгүүр давах, доогуур нь шургах
- ❖ Замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжгүй оролцох/ зам хөндлөн гарахдаа гар утсаар ярих, чихэвчний хөгжим сонсох, мессеж бичих/
- ❖ Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулах /эцэг эх, асран хамгаалагчийн буруугаас автомашинд дайрагдах, мөргүүлэх хэлбэрээр хохирох тохиолдол бүртгэгдсээр байна.

График 21. Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол




Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 2022 онд улсын хэмжээнд 719 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн ослын 3%-ийг эзэлж байна. Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан ослын 629 буюу 87.5% нь нийслэлд, 90 буюу 12.5% нь орон нутагт бүртгэгдсэн. Нийт явган зорчигчийн буруутай үйлдэл дотроо явган зорчигч замын хөдөлгөөнд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ, биеэ авч явах чадваргүй байдлаар

оролцсон нь 27.5%, сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулсан 6.1%-ийг тус тус эзэлж байна.

Явган зорчигчид зориулсан зам, замын байгууламж нь стандартын дагуу хийгддэггүй, түүнд тавих хяналт байхгүй, мөн явган зорчигчдын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд соёлтой оролцохыг хүсдэггүй, тэдэнд оногдуулах хууль сахиулах байгууллагаас тавих хяналт хангалтгүй, гаргасан зөрчилд хариуцлага хүлээлгэх механизм хэрэгжихгүй байгаагаас явган зорчигч амь насаа алдах, гэмтэх тохиолдол гарсаар байна. Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол өнгөрсөн онтой харьцуулахад буурсан хэдий ч замын хөдөлгөөнд оролцож байхдаа осолд өртөх, хохирох үзүүлэлт буурахгүй байна.

График 22. Явган зорчигч зам тээврийн осолд өртсөн шалтгаан



Явган зорчигч нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцож хохирсон 198 осол бүртгэгдсэний 179 буюу 90.4% нь нийслэлд, 19 буюу 9.6% нь орон нутагт бүртгэгдсэн.

Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулснаас нийслэлд 36, орон нутагт 9, нийт 45 зам тээврийн осол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 17.7%-иар өссөн байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол өнгөрсөн оны үзүүлэлтээс буурсан хэдий ч замын хөдөлгөөнд оролцож байхдаа осолд өртөх, хохирох явдал буурахгүй байна. Тэд замын сүлжээг аюулгүй ашиглахад төлөвшөөгүй байдаг. Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны /КАРЕК/ улс орнуудын өнөөгийн авто замуудад судалгаа хийж үзэхэд явган зорчигчийн тав тух, аюулгүй байдалтай холбоотой дараах олон асуудлууд байна. Үүнд:

- Явган зорчигчийн (цагаан зураастай) гарцтай боловч жолооч нар түүнийг үл тоодог;
- Өргөн (олон эгнээтэй), өндөр хурдны авто зам дээр цагаан зураастай гарцуудыг олноор гаргасан;
- Явган зорчигчийн хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио, явган зорчигчийн гарцыг тэмдэглэлгүй уулзварын гэрлэн дохио;
- Гэрлэн дохионы асах хугацаа нь явган зорчигч зам гарахад хангалтгүй;
- Хөдөлгөөн ихтэй замын дагуу явган зорчигчдын удирдлагатай гэрлэн дохио хангалтгүй;
- Бусад хэлбэрийн гарц зам ашиглагчдад илүү таатай байхаар хэсэгт явган зорчигчийн гүүрэн болон доогуур гарц бариагүй;
- "Аюулгүй систем"-ийн зарчимд нийцээгүй хурдны хязгаарлалт;
- Суурин газрын дундуур өнгөрөх гол замын хурдны удирдлага зохицуулалт, "Хөдөлгөөн сааруулах" зохицуулалт хангалтгүй;

- Орон нутгийн замд хурдыг зохицуулах, багасгах үйл ажиллагаа хангалтгүй;
- Явган зорчигчдын аюулгүйн арал, явган зорчигчийн налуу зам, хашлага, хажуугийн өргөтгөлүүд дутагдалтай;
- Явган зорчигчийн байгууламжийн засвар үйлчилгээ хангалтгүй (зурвас хуучирч бүдгэрсэн, тэмдэг байхгүй, гэрлэн дохио эвдэрсэн).

Явган зорчигчид бол замын хөдөлгөөнд оролцогчдын хамгийн том бүлэг бөгөөд өдөр, шөнийн аль ч цагт замын сүлжээнд явган зорчигчид тааралдаж болно. Явган зорчигч нь мөн зам ашиглагчдын хамгийн эмзэг бүлэгт тооцогддог. Ийм ч учраас авто замын осолд хамгийн хүнд гэмтэл авдаг. Явган зорчигч нь хууль ёсны замын хөдөлгөөнд оролцогчдын нэг юм. Тэдэнд зам дагуу явах, зам хөндлөн гарахад ээлтэй орчин хэрэгтэй².

Улсын хэмжээнд 2022 онд хүүхэд өртсөн зам тээврийн осол 779 бүртгэгдсэний 443 буюу 56.9% нь нийслэлд, 336 буюу 43.1% нь орон нутагт бүртгэгдсэн.

Зам тээврийн ослын улмаас 76 хүүхэд нас барж, 810 хүүхэд гэмтэл авсны 171 хүүхэд нь хүнд, хүндэвтэр гэмтэл авчээ. Зам тээврийн ослын улмаас нас барсан 539 хүний 76 буюу 14.1% нь хүүхэд, гэмтсэн хүний 28.1% нь хүүхэд байгаа нь хүүхдийн амь эрсдэл 0.8%-иар, гэмтэл 8.5%-иар тус тус өссөн харамсалтай тоон үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт 45. Хүүхэд зам тээврийн осолд өртсөн хэлбэр

Д/д	Үзүүлэлт	Явган зорчигч	Зорчигч	Дугуйгаар зорчигч	Бусад
1	Улсын хэмжээнд	566	252	34	34
	Эзлэх хувь	63.9	28.4	3.8	3.8
2	Нийслэлийн хэмжээнд	364	79	29	8
	Эзлэх хувь	75.8	16.5	6.0	1.7
3	Орон нутгийн хэмжээнд	202	173	5	26
	Эзлэх хувь	49.8	42.6	1.2	6.4

Хүснэгт 46. Хүүхэд өртсөн зам тээврийн осол

Зам тээврийн осол	Нийт хохирсон хүүхэд	Нас барсан хүүхэд	Гэмтсэн хүүхэд
Улсын хэмжээнд			
779	886	76	210
Нийслэлд			
443	480	7	473
Орон нутагт			
336	406	69	337

Хүснэгт 47. Хүүхэд зам тээврийн осолд өртсөн нутаг дэвсгэрээр

Аймаг, дүүрэг	Нас барсан хүүхдийн тоо			Гэмтсэн хүүхдийн тоо		
	2022	Өсөлт бууралт /тоогоор/	Өсөлт бууралт/ хувиар/	2022	Өсөлт бууралт/ тоогоор	Өсөлт бууралт/ хувиар
Архангай	4	-2	-33.3	5	2	66.7
Баян-Өлгий		-3		15	6	66.7
Баянхонгор	5	4	5	24	17	3.4
Булган	6	4	3	10	2	25.0
Говь-Алтай	2		0.0	6	1	20.0
Говьсүмбэр				5	2	66.7
Дархан-Уул	4	2	2	28	10	55.6
Дорноговь	2	-2	-50.0	13	6	85.7
Дорнод	1	1		19	1	5.6
Дундговь	2	1	2	10	3	42.9

² Карекийн замын хөдөлгөөний аюулгүй байдал инженерчлэлийн гарын авлага.(2020). Явган зорчигчийн аюулгүй байдал. 4 дэх тал.

Завхан	3	2	3	9	1	12.5
Орхон	1	1		23	12	2.1
Өвөрхангай	6	6		12	4	50.0
Өмнөговь	2		0.0	9	3	50.0
Сүхбаатар	1	1		11	4	57.1
Сэлэнгэ	2		0.0	19	-2	-9.5
Төв	8	2	33.3	51	8	18.6
Увс	3	2	3	14	9	2.8
Ховд	7	5	3.5	19	8	72.7
Хөвсгөл	4	1	33.3	12	7	2.4
Хэнтий	6	4	3	23	13	2.3
Баянгол дүүрэг		-2		64	38	2.5
Баянзүрх дүүрэг	2	1	2	101	32	46.4
Сүхбаатар дүүрэг				67	40	2.5
Сонгинохайрхан дүүрэг	5	3	2.5	104	44	73.3
Хан-Уул дүүрэг		-4		83	44	2.1
Чингэлтэй дүүрэг		-1		40	9	29.0
Багануур дүүрэг				8	4	2
Багахангай дүүрэг				1		0.0
Налайх дүүрэг				5	-3	-37.5
Улсын хэмжээнд	76	25	49.0	810	325	67.0

Хүүхэд өртсөн осол нь нийслэлд их бүртгэгдсэн ч ослын улмаас амь эрсэдсэн хүүхдийн 90.7% нь орон нутгийн замд бүртгэгдсэн байна. Зам тээврийн осолд өртсөн 779 хүүхдийн 79 буюу 10.1% нь амь эрсдэж, 171 буюу 21.3% нь хүнд, хүндэвтэр, 529 буюу 67.7% нь хөнгөн зэргийн гэмтсэн.

Хүүхэд ихэвчлэн гэр, сургууль, цэцэрлэг гэсэн чиглэлээр зорчиж байгаад зам тээврийн осолд өртдөг байна. Энэ чиглэлээр явахдаа асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр осолд өртдөг хэдий ч жолоочийн хариуцлагагүй үйлдэл, зам, замын байгууламжаас хамаарч осолд өртөх тохиолдол гарсаар байна. Хүүхэд осолд өртсөн байдлыг 2022 оны байдлаар төв, орон нутгаар харьцуулан авч үзэхэд Төв, Ховд, Баянхонгор, Дархан-Уул аймагт хүүхэд өртсөн зам тээврийн осол их бүртгэгдсэн байна.

Авто замын аюулгүй байдал нь замын хөдөлгөөний нэг хэсэг юм. Замын нөхцөл - Замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг чанд мөрдөж иж бүрнээр /замын инженерийн байгууламж, хөдөлгөөн зохицуулах хэрэгсэл гэх мэт/ нь шийдвэрлэж байх шаардлагатай гэж олон улсад үздэг байна. Зам-орчин нь өөрөө замын хөдөлгөөний нэг бүрдэл болдог. Замын нөхцөлөөс шалтгаалсан осол улсын хэмжээнд 125 бүртгэгдсэнээс нийслэлд 110, орон нутагт 15 осол бүртгэгджээ. Дээрх хүчин зүйлд техникийн гэмтэл, гадна гэрэл /замын гэрэл/, зам орчны нөхцөлийг багтаан авч үзэж байгаа ч авто зам, замын байгууламж хариуцсан байгууллагад ослын акт тавигдаж арга хэмжээ тооцсон байдал хангалтгүй байгаагаас замын нөхцөлөөс гарсан ослын үзүүлэлт харьцангуй бага хувийг эзэлсэн хэвээр байна.

График 23. Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан осол



Замын хөдөлгөөний аюулгүй байдал, шуурхай байх үндсэн нөхцөлийн нэг нь зам, замын дэд бүтэц байдаг. Замын эвдрэл, гэмтэл нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол, хэрэг гарах шалтгаан, нөхцөл болдог байна. Өнөөг хүртэл замын эвдрэл гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцөлийг тойрох гэсэн автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан ослын тохиолдлын бурууг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулж байна. Замын хөдөлгөөнд оролцогчдод сайн чанарын, аюулгүй зам хэрэгтэй байдаг учир замын байгууламж хариуцсан албад, гадна талбай, зогсоолын талбай зэрэг нийтэд үйлчлэх эзэмшлийн зам, талбайгаа цэвэрлээгүйгээс уг байгууллагын эзэмшлийн газарт замын нөхцөлөөс үүдэлтэй осолд аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага хүлээлгэвэл зам, замын нөхцөл нь чанарын өндөр түвшинд хүрэх нэг механизм болно гэж үзэж байна.

6.7.Зам тээврийн ослын хэлбэр

Зам тээврийн осол гарч буй хэлбэрийг:

- Тээврийн хэрэгслээр явган зорчигч мөргөх,
- Тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх,
- Тээврийн хэрэгслээр дугуйтай хүн мөргөх,
- Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөх,
- Тээврийн хэрэгслээр онхолдох, замын хажуу руу унах, өнхрөх зэргээр ангилан тоон үзүүлэлтээр гаргадаг байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын 20223 буюу 83.8% нь мөргөлдөх, 1498 буюу 6.2% нь явган зорчигч мөргөх, 984 буюу 4.1% нь онхолдох/замын хажуу руу унах, өнхрөх г.м/, 875 буюу 3.6% нь үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, шон мөргөх/, 23 осол тээврийн хэрэгслээс зорчигч унагах, 89% унадаг дугуйтай хүн мөргөх, 310 буюу өмнөх оноос 37.1%-иар өссөн осол нь мал, амьтан дайрах, 119 осол бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд явган зорчигч мөргөх хэлбэрээр бүртгэгдсэн зам тээврийн ослын 1498 буюу 86.7% нь нийслэлд бүртгэгдсэн байна. Мөн улсын хэмжээнд онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн 984 ослын 894 буюу 90.8% нь орон нутгийн замд бүртгэгдсэн байна.

Монгол Улсад 2022 онд бүртгэгдсэн зам тээврийн осол гарсан хэлбэрийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад:

- Тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх хэлбэрээр гарсан осол 8.9-иар,
- Явган зорчигч мөргөх хэлбэрээр гарсан осол 15.1%-иар,
- Мал, амьтан дайрах хэлбэрээр гарсан осол 59%-иар тус тус өсжээ.

Нийслэл болон орон нутагт бүртгэгдсэн ослын хэлбэр

Нийслэлд:

- Мөргөлдөх - 18214 буюу 89.6%,
- Явган зорчигч мөргөх -1299 буюу 6.4%,
- Онхолдох – 90 буюу 0.4%,
- Тээврийн хэрэгслээс зорчигч унагах - 13 буюу 0.1%,
- Дугуйтай хүн мөргөх – 69 буюу 0.3%,
- Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөх - 586 буюу 2.9%,
- Мал, амьтан дайрах – 51 буюу 0.3 хувийг эзэлж бүртгэгдсэн байна.

Орон нутагт:

- Мөргөлдөх – 2009 буюу 52.9%,
- Явган зорчигч дайрах – 199 буюу 5.2%,
- Онхолдох – 894 буюу 23.5%,
- Зорчигч унагах – 10 буюу 0.3%,
- Дугуйтай хүн мөргөх - 20 буюу 0.5%,
- Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөх – 289 буюу 7.6%,
- Мал амьтан дайрах - 259 буюу 6.8%,
- Бусад хэлбэрээр 122 буюу 3.7 %-ийг эзэлж бүртгэгдсэн байна.

Нийслэлд автомашин мөргөлдөх, явган зорчигч мөргөх хэлбэрээр, орон нутагт автомашин мөргөлдөх, онхолдох хэлбэрээр осол их бүртгэгдсэн.

Тээврийн хэрэгслээр онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн осол

Улсын хэмжээнд: - Онхолдох хэлбэрээр 984 зам тээврийн осол бүртгэгдсэний 894 буюу 90.9% нь орон нутгийн замд бүртгэгдсэн байна. Онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн осол орон нутагт 236 (98.3%), нийслэлд 4 (1.7%) бүртгэгдсэн байна. Мөн нийслэлд онхолдох хэлбэрээр Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Багануур дүүрэгт тус бүр 1 осол бүртгэгдэж хүний амь нас хохирсон байна. Онхолдох хэлбэрээр гарсан ослын улмаас 152 жолооч, 111 тээврийн хэрэгслээр зорчигч амь насаа алдсан байна.

График 24. Орон нутагт бүртгэгдсэн хүн нас барсан осол



График 25. Орон нутагт бүртгэгдсэн зам тээврийн осол



Орон нутагт онхолдох хэлбэрээр гарч буй зам тээврийн осол нь бүрэн бус мотоциклоор замын хөдөлгөөнд оролцох, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, хурд хэтрүүлэх, замын нөхцөлөөс шалтгаалсан байх магадлалтайгаас гадна замын нөхцөлд хурд тохируулан яваагүйгээс шалтгаалсан байна.

Зам тээврийн осолд холбогдсон тээврийн хэрэгслийн төрөл

Зам тээврийн осолд холбогдсон тээврийн хэрэгслийн 20887 буюу 86.6% нь суудлын, 1749 буюу 7.3% нь ачааны, 835 буюу 3.5% нь автобус, 27 буюу 0.1% нь механизм, 480 буюу 2.0% нь мотоцикл, 143 буюу 0.6% нь унадаг дугуй байна.

Манай улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 64.2%-ийг суудлын автомашин эзэлж байгаатай холбоотой зам тээврийн осолд холбогдсон автомашины 86.6% буюу дийлэнх хувийг суудлын автомашин эзэлж байна.

Хүснэгт 48. Зам тээврийн осолд холбогдсон автомашины төрөл

ЗТО холбогдсон тээврийн хэрэгслийн төрөл							
№	Үзүүлэлт	Суудлын	Ачааны	Автобус/т ом, бага оврын/	Механизм	Мотоцикл	Унадаг дугуй
Улсын хэмжээнд							
1	Тоон үзүүлэлт	20887	1749	835	27	480	143
	Эзлэх хувь	86.6	7.3	3.5	0.1	2.0	0.6
Нийслэлд							
2	Тоон үзүүлэлт	18035	1263	811	6	130	77
	Эзлэх хувь	88.7	6.2	4.0	0.0	0.6	0.4
Орон нутагт							
3	Тоон үзүүлэлт	2852	486	24	21	350	66
	Эзлэх хувь	75.1	12.8	0.6	0.6	9.2	1.7

Улсын хэмжээнд 54819 мотоцикл бүртгэлтэйгээс түүний 10384 буюу 18.9% нь нийслэлд, 44435 буюу 81.1% нь орон нутагт бүртгэлтэй байна. Өвөрхангай, Баян-Өлгий, Төв, Увс аймгийн мотоциклын хэрэглээ бусад аймгаас их байна.

Монгол Улсад 2022 онд бүртгэгдсэн мотоциклын тоо өнгөрсөн оны үзүүлэлтээс 23.5%-иар буурсан. Улсын хэмжээнд мотоциклоор үйлдэгдсэн зам тээврийн осол 480 бүртгэгдэж, 120 хүн нас барж, 242 хүн гэмтсэн байна. Тухайн ослын 350 буюу 72.9% нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Хүснэгт 49. Мотоциклоор үйлдэгдсэн зам тээврийн ослын байдал

Аймаг, дүүрэг	Бүртгэгдсэн осол			Нас барсан хүн			Гэмтсэн хүн		
	2022	Өсөлт бууралт/ тоогоор/	Өсөлт бууралт/ хувиар/	2022	Өсөлт бууралт/ тоогоор	Өсөлт бууралт/ хувиар	2022	Өсөлт бууралт/ тоогоор/	Өсөлт бууралт/ хувиар/
Архангай	28	16	2	12	7	2.4	16	8	50.0
Баян-Өлгий	15	-8	-34.8	3			8	-3	-27,3
Баянхонгор	14	-8	-36.4	7	2	40	3	-10	-76,9
Булган	13	-3	-18.8	9	4	80	3	-4	-57.1
Говь-Алтай	10	1	11.1		3	2	2	-1	-33.3
Говьсүмбэр	2	-1	-33.3	6	-1		1		
Дархан-Уул	3	8	-25				2	-1	-33.3
Дорноговь	24	-10	50		1	33.3	20	11	2.2
Дорнод	10	5	-50	4	-2	-33.3	5	-7	-58.3
Дундговь	21	5	31.3	4	5	2.6	15	2	20
Завхан	15	-2	50	8	2		5	-1	-16.7
Орхон		-1		2				-2	
Өвөрхангай	27	10	-3.6		2	20	10	-5	-33.3
Өмнөговь	31	1	47.6	12	1	11.1	14	8	2.3
Сүхбаатар	15	-1	7.1	10	5	3.5	7		
Сэлэнгэ	15	4	-6.3	7	2	2	8	-6	-42.9
Төв	35	1	12.9	4	1	10	23	3	15
Увс	14	2	7.7	11	-1	-16.7	8	6	4
Ховд	16	7	14.3	5	2	2	4	-2	-33.3
Хөвсгөл	20	-2	53.8	4	3	2	8	2	33.3
Хэнтий	22	2	-8.3	6	-5	-55.6	10	1	11.1
Баянгол дүүрэг	15	-6	15.4	4			10		
Баянзүрх дүүрэг	20	5	-16.7				16	-4	-20
Сүхбаатар дүүрэг	26	-9	23.8				14	5	55.6
Сонгинохайрхан дүүрэг	8	-2	-52.9		-3		4	-5	-55.6
Хан-Уул дүүрэг	31	7	-6.1		-1	-33.3	17	-1	-5.6
Чингэлтэй дүүрэг	16	-1	77.8	2			11	3	-27,3
Багануур дүүрэг	2	-1	-33.3				1		37.5
Багахангай дүүрэг								-1	
Налайх дүүрэг	2								
Нийслэл	130	-5	33.7	2	-4	-66.7	73	-3	3.9
Орон нутаг	135	23	7.0	118	31	35.6	169	-1	-0.6
Улсын хэмжээнд	480	18	3.9	120	27	29.0	242	-4	-1.6

7. Эрүүлжүүлэгдсэн хүн

Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагааны талаар авч үзвэл 2022 онд 63879 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6600 буюу 9.4%-иар буурсан. Эрүүлжүүлэгдсэн хүний 51597 буюу 80.8% нь нийслэлд 12282 буюу 19.2% нь орон нутагт эрүүлжүүлэгдсэн байна.

Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 58180 буюу 91.1% нь эрэгтэй, 5699 буюу 8.9% нь эмэгтэй, 112 буюу 0.2% нь хүүхэд байна.

Архины албадан эмчилгээнд 440 хүн, сайн дурын эмчилгээнд 937 хүнийг хамруулсан байна.

8. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил

Цагдаагийн байгууллага нь 2022 онд Цагдаагийн албаны тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, улсын хэмжээнд зохион байгуулж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжил, арга зүй, удирдлагаар ханган, үр дүнг тооцож ажилласан.

2022 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны салбар төлөвлөгөөг 4 бүлэг, 60 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцон Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд хүргүүлж ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сар шинэ-2022”, “Тэнэмэл-1,2,3”, “Зөвийг зөвлөө”, “Цахим соёл”, “Мал мах-Хяналт”, “Шийдвэрлэлт”, “Carback”, “Арлын дугаар”, “Ломбард хяналт”, “Халаас”, “РС-бүртгэл”, “Халхавч”, “Эрэлч нохой-2022”, “Илрүүлэлт-Оргодол-2022”, “Тэрбум мод” аяны хүрээнд “Байгалиа бүтээе-I.II”, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, “Залилан”, “Хичээл эхэллээ”, “Unsend”, “Намайг алгас” зэрэг тусгай арга хэмжээ 12, хэсэгчилсэн 1755, нийт 1760 арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээллийг түгээх ажлын хүрээнд “Амрыг эрье” 20 минутын нэвтрүүлгийн 96 удаагийн дугаар бэлтгэж, МҮОНТ-ийн 1, 2 дугаар суваг болон Эх орон, Боловсрол, ETV, TV-5, TV-4, TV-9, OTV, News channel, ТВ-6 зэрэг 12 телевизээр 420 удаагийн давталттайгаар дамжуулан олон нийтэд хүргэн ажилласан. Мөн “Police podcast” хөтөлбөрийн хүрээнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэстэй хамтран 31 удаагийн ярилцлага бэлтгэн түгээсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан. Хуульд согтууруулах ундааны хэрэглээ, түүний худалдаа, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, архидан согтуурах, согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэх зорилго бүхий аливаа үйл ажиллагааг хориглох шинэлэг 9 зохицуулалтыг тусгасан.

Олон улсын сайн туршлага, дэвшилтэд технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран нийслэл хотын теле камерын тоог нэмэгдүүлж, ашиглалтыг үр дүнтэй болгох “Аюулгүй хот”-ыг бий болгох зорилтын хүрээнд өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд тохируулан камерын хяналттай “Ногоон бүс” төслийг хэсэгчлэн зохион байгуулах ажлын хүрээнд эхний ээлжинд Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо 1 дүгээр дөчин мянгатын нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээгээр дүүргийн хэмжээнд хулгайлах, халаасны хулгайн гэмт хэргийн 31.7% үйлдэгддэг, өдөртөө Улаанбаатар хотын иргэдийн 60 орчим хувь нь зорчин өнгөрдөг, аж ахуй нэгжийн төвлөрөлт, дэд бүтэц зэрэг хүчин зүйлд тулгуурлан сонгон авч, теле камерын хяналтад бүрэн оруулах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн.



Олон улсад хэрэгжиж буй “Green zone” төсөл нь дэлхийн 3 орон буюу Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хот, Оросын Холбооны Улсын Москва хот, Англи Улсын Лондон хотод амжилттай хэрэгжиж, камерийн хяналтаар нийт гэмт хэргийн 45-47 хувийг илрүүлсэн тэргүүн туршлага байгааг үндэслэн Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны 19.7 га газрын 61 цэгт 145 камер шинээр байршуулах, түүнд шаардагдах төсөв тооцоонд тулгуурлан төр, хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага, иргэдийн хамтын санхүүжилтын дэмжлэгтэйгээр камер суурилуулах ажлыг зохион байгуулсан.

“Ногоон бүс”-д Монгол Улсын телехяналтын тоног төхөөрөмжийн (MNS6423:2019) стандартыг хангасан 4 мегапиксел үзүүлэлт бүхий 145 ширхэг камерыг 61 цэгт суурилуулан теле хяналтын нэгдсэн сүлжээнд холбон 24 цагаар цагдаагийн байгууллагаас хяналт тавин ажиллаж байна. Телехяналтын нэгдсэн төв нь нийтийн эзэмшлийн гудамж, талбайд суурилуулсан камеруудын дүрсийг нэгтгэж харах зорилго бүхий 25 ширхэг ханан дэлгэц байх бөгөөд нэг дор 800 ширхэг камерийн дүрсийг хянах стандартын шаардлагад нийцсэн зориулалтын шал, хана, хөргүүр зэргийг цогцоор нь шийдвэрлэснээрээ онцлог юм.

“Залилах” гэмт хэрэгт иргэн, хуулийн этгээдийг өртөхөөс урьдчилан сэргийлэх, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хор уршгийг таниулах зорилгоор энэ оны 06, 09 дүгээр сард 2 удаа улсын хэмжээнд урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 95 сэрэмжүүлэг мэдээллийг төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын цахим орчинд түгээснийг 1.596.893 хүн дэмжиж, 252.079 хүн эерэг сэтгэгдэл үлдээж, 1.774.577 хүн бусадтай хуваалцаж, давхардсан тоогоор 10.024.438 хүнд хүрсэн байна.

Уг арга хэмжээний хугацаанд 858 залилах гэмт хэрэг бүртгэгдсэнээс 154 хэрэг буюу 17.9%-ийг шүүхэд шилжүүлж, 191 хэрэг буюу 22.2%-ийг хааж, 605 хэрэг буюу 70.5%-ийг бусад хэрэгт нэгтгэн шийдвэрлэж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт 4,7%-иар буурсан эерэг үр дүн гарсан.

Мөн “Бүү шилжүүл” уриатай “Unsend” аяныг 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 29-ний өдөр цахим орчинд “Залилах” гэмт хэргээс урьдчилан олон талт арга хэмжээ зохион байгуулж “Lebo”, “Хулан шоу” интертаймент үйлчилгээ үзүүлэгч компаниудтай хамтран богино хэмжээний видео-4, постер-8-г бэлтгэн Монголбанк, Монголын банкны холбооны цахим хуудсуудаар болон бусад дагагч өндөртэй цахим хуудас, группуудээр дамжуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

Банк бус санхүүгийн байгууллагын холбооны гишүүн 41 иргэнд “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, “Татвар төлөхөөс зайлсхийх”, “Залилах гэмт хэргийн ойлголт” сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан.

Хөндлөнгийн, хараат бус менежментын тогтолцооны стандартын баталгаажуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг “МонСертф” ХХК-аас “Дэлхийн чанарын долоо хоног”-г тохиолдуулан зохион байгуулсан “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо” сэдэвт уулзалтад ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс “Цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр нийт 65 иргэнд мэдээлэл хийсэн.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/388 дугаар захирамжийн хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд 188 байршилд 4860 граж буулгаж газар чөлөөлөх ажил хийгдэх үед тус албанаас байршил тус бүрд барилгын ажил хийгдэх үед хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Олон улсын аюулгүй жолоодлогын 10 дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нутагшуулах зорилгоор “Зөвийг хэвшүүлье” уриатай 10 төрлийн нөлөөллийн арга хэмжээний хүрээнд явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “Гэрлээр анхааруулъя”, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх

зорилготой “Гар утас”, унадаг дугуй, цахилгаан дугуй, мопед, мотоциклын жолоочийн аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Хамгаалах малгай”, явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах, сургууль орчмын бүсэд хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийг аюулгүй тээвэрлэхтэй холбоотой “Явган зорчигчийн аюулгүй байдал-Сургууль орчмын бус-Хүүхэд”, орон нутгийн замд хурд хэтрүүлэх, ядарсан үедээ жолоо барих, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих халтиргаа гулгааны үед зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Дугуй” нөлөөллийн арга хэмжээг тус тус зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцож ажилласан.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн санхүүжилтээр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнийг таних, илрүүлэх анхаарах асуудал” сэдэв гарын авлагыг 300 ширхэгийг хэвлүүлэн 6 аймаг, 3 цагдаагийн хэлтэс, ШШГЕГ-ын 3 байгууллагын нийт 1550 алба хаагчдад албан хэрэгцээнд ашиглуулахаар хүлээлгэн өгсөн.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль, орчин аялал, жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн мн-144/мн-187/мн-22 дугаар тушаалаар баталсан “Устгал” нэгдсэн арга хэмжээний удирдамж, төлөвлөгөө, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр баталсан салбар төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, мансууруулах үйлчилгээтэй олсны ургамал (каннабис)-ын тархац тогтоогдсон 11 аймаг болон нийслэлийн хэмжээнд зэрлэг байдлаар ургаж буй уг ургамлыг устгах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус нэгдсэн арга хэмжээг зохион явуулж улсын хэмжээнд 84,314,280 төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлж 1924.36 га талбайд устгал хийх ажлыг зохион явуулсан.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон 8 иргэнд сэтгэл зүйн болон, эрүүл мэнд, хууль зүйн туслалцааг төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор зохих журмын дагуу шуурхай үзүүлж байна. Тухайлбал;

Насанд хүрээгүй хохирогчдыг хөндлөнгийн нөлөөлөлд автуулахгүй байх бусад аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар”, “Хүүхэд хамгаалах төвийн хамгаалах байр”, “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ, “Талита Ази” ТББ-уудтай хамтран ажилласан.

Азийн сан олон улсын байгууллагын “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” төслийн хүрээнд боловсруулсан “Алба хаагчдыг чадавхжуулах нь” суралцагчийн гарын авлагад алба хаагч холбогдох саналыг өгч ажилласан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хүн амын сан”-тай хамтран хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” үндэсний чуулганыг хамтарсан багийн 825 гишүүдийг хамруулж Төрийн ордны Их Монгол танхимд 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан.

Нийслэлийн байгаль орчны газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа зэрэг байгууллагатай хамтран “Самар-2022” хэсэгчилсэн арга хэмжээг 2022 оны 09 дүгээр сарын 05-наас 15-ны өдөр Баянзүрх дүүргийн 11, 14, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Манзуширын ам, Баянголын ам,



Хуайндайгийн ам, Сүхбаатар дүүргийн 19, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Бэлх, Гүнжийн, Хандгайт, Их Бага баяны ам, Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Богдхан уулын Түргэний ам, Жаргалантын ам, Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо Зүрх уулын ам зэрэг ногоон бүсэд нийт 32 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 120 отог, 673 иргэнийг уулнаас буулгаж, 89 шуудай цайруулсан самар, 104 шуудай боргоцойг хураан авч, зөрчлийн шинжтэй 20 үйлдлийг илрүүлж, иргэдэд Ойн тухай хууль тогтоомж зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, уулнаас буулгах, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг “Ногоон дуу хоолой” нэрийн дор 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд орон даяар “Зөв мод-Зөв арчилгаа” уриатайгаар Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. Дээрх аяны хүрээнд мод тарьж ургуулахтай холбоотой технологийн заавар, зөвлөмж бүхий шинжлэх ухаан, танин мэдэхүйн үндсэн видео шторк 10, зурагт постер 18-г тус тус бэлтгэж, олон нийтэд сурталчилсныг 114.462 хүн дэмжиж, 12.509 хүн эерэг сэтгэгдэл үлдээж, 130.154 хүн бусдад түгээсэн нь давхардсан тоогоор 14.265.656 хүнд хүрч иргэдийг мод тарихад уриалсан, мод тарих, ургуулах соёлыг дэлгэрүүлсэн, хандлага мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн, буруу дадал хандлагад эергээр нөлөөлсөн, зөв үйлдэлд уриалж сэдэлжүүлсэн арга хэмжээ болсон.

Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 01-нээс 30-ны өдөр, 10 дугаар сарын 03-ны өдрөөс 15-ны өдөр хүртэлх хугацаанд “Байгалиа бүтээе” нөлөөллийн аяныг 2 удаа тус тус зохион байгуулж, эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалж зохицон амьдрах, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилго бүхий шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран хавар, намрын мод тарих ургуулах зөвлөгөө зөвлөмж 4, иргэдийг мод тарихад уриалан бэлтгэсэн 62 видео шторк, сайтын сурвалжлага-5, нийтлэл-4, 52 зурагт постер, контентуудыг давхардсан тоогоор орон сууцны 1830 лифт, орон нутаг, нийслэлийн 30, иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшлийн 62, худалдаа, үзвэр үйлчилгээний 122, нийт 214 сурталчилгааны лед самбаруудад байршуулж, төв, орон нутгийн 44 телевизээр 3357 удаа 420.913 секунд хугацаагаар олон нийтэд хүргэж, зорилтод мэдээллийг 43 фм радиогоор 38 өдрийн турш түгээж, цахим орчинд байршуулж түгээснийг 523.836 хүн дэмжиж, 728.271 хүн эерэг сэтгэгдэл үлдээж, 3.318.777 хүн бусдад түгээсэн ба давхардсан тоогоор 40.547.100 хүнд хүрсэн байна.

Нийслэл хотод орон гэргүй тэнэмэл байдлаар амьдардаг иргэдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах, нийгэмшүүлэх “Тэнэмэл” тусгай арга хэмжээг 2022 оны 2, 3 дугаар сард 2 удаа зохион байгуулж, нийт 209 хүнийг олж тогтоон, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулснаас 13 иргэнийг ар гэрт нь, коронавируст халдвар /ковид-19/-ын эерэг хариу гарсан 1 иргэнийг “Энэрэл” эмнэлэгт, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх “Нийгмийн хамгааллын тусгай төв”, “Өлзийт асар”, “Титэм констракшин”, “Дөлгөөн минж”, “Шинэ амьдрал ялагч” зэрэг 5 төрийн болон төрийн бус байгууллагуудад 195 иргэнийг хүлээлгэн өгч ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран иргэд, олон нийтийг согтууруулах ундааны хорт зуршил, буруу хэрэглээнээс татгалзуулах, түүнээс үүдэн гарах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд “Намайг алгас” нөлөөллийн аяныг зохион байгуулж, бэлтгэл ажлын хүрээнд аяны брэндинг, стратегийг боловсруулж, олон нийтийн дундах архины өргөн хэрэглээг бууруулах, зохисгүй хэрэглээг бууруулах, зөв хандлага,

сонголт, шинэ соёлыг төлөвшүүлэх, дэмжихэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны 28 ажил, арга хэмжээг төлөвлөн гүйцэтгэсэн. 88 видео шторк, 36 зурагт постерыг мэргэжлийн байгууллагуудаар бүтээлгэн, Ажлын хэсгээс 54 дэмжих видеог бэлтгэн олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Бэлтгэсэн видео контент, мэдээ, мэдээллийг төв, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн 130, худалдаа, үзвэр үйлчилгээний 214, нийт 344 сурталчилгааны лед дэлгэцээр нийтийн орон сууцны 900 лифт, 42 телевиз, 30 фм радиогоор тус тус түгээж, автобусны буудал болон автозам дагуу 143, бусад байршилд 38, нийт 181 мэдээллийн самбарт “Намайг алгас” сурталчилгаа, мэдээллийн постерыг байршуулсан.

Иргэдийг соён гэгээрүүлэх, идэвхжүүлэх зорилгоор уулзалт, өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг давхардсан тоогоор 609 удаа зохион байгуулж, тараах материал 30.000 ширхэг хэвлэн төв, орон нутгийн худалдаа үйлчилгээний газар болон иргэд олноор цугладаг цэгүүдэд тараасан. Уг аяныг сурталчлах өдөрлөгийг улсын томоохон их, дээд сургуулийн 1200 гаруй оюутан, залуусыг хамруулан 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “ЮЖ Арина” цогцолборт зохион байгуулж, хэвлэл, мэдээллийн 23 телевиз, цахим хуудсаар олон нийтэд түгээсэн.

Нөлөөллийн арга хэмжээний үр дүнд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага мэдээлэл 1044, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчил гаргасан гэх дуудлага мэдээлэл 337 нэгжээр тус тус буурсан эерэг үзүүлэлт гарсан. Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд нийт 188 мэдээлэл бэлтгэн цахим орчинд түгээсэн нь давхардсан тоогоор 1.437.228 хүнд таалагдаж, 4.326.623 хүн бусадтай хуваалцаж, 402.332 хүн эерэг сэтгэгдэл илэрхийлж, 67.060.623 хүнд хүрсэн байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Тарвага-2022”, “Эрчимжүүлэлт-2022”, “Эрэлч нохой-2”, “Усны сан бүхий газар-2022”, “Төр хурахын ам-2022”, “Самар-2022”, “Эрэлч нохой-3” хэсэгчилсэн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцсон. Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасан байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр “Эко-2022” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, гэмт хэргийн шинжтэй 2 үйлдэл, 37 зөрчил илрүүлсэн.

Тээврийн цагдаагийн албанаас нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран “E-Police” аппликейшныг 2018 оноос нэвтрүүлсэн бөгөөд 2022 онд “E-police” аппликейшн-ы талаар олон нийтэд сурталчлах чиглэлээр дараах ажлыг зохион байгуулсан. Тухайлбал; Урьдчилан сэргийлэх хэлтсээс нийт алба хаагчдын гар утсанд “E-Police” аппликейшинг суулгах ажлыг зохион байгуулж, хяналт тавих үйл ажиллагаанд ашиглаж хэвшсэн. “E-Police апп”-д ирүүлсэн 88686 зөрчлийг баталгаажуулан тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчийн бүртгэлтэй хаягаар шийтгэлийн хуудсыг хүргүүлж ажилласан. Цахим орчинд “Замын хөдөлгөөний дүрэм” зөрчиж буй талаар иргэдээс ирүүлсэн мэдээллийг тус албаны Мөрдөн шалгах газрын Зөрчил хянан шийдвэрлэх хэлтэстэй хамтран бүртгэн авч, нийт цахимаар ирсэн 657 зөрчилд арга хэмжээ тооцуулахаар харьяа дүүрэг дэх замын цагдаагийн нэгжүүдэд хүргүүлж, энэ талаар иргэдэд “Paparazzi Traffic Mongolia”, “Цахим замын цагдаа” болон “Тээврийн цагдаагийн алба”-ны цахим хаягаар эргэн мэдээлж ажилласан.

Хулгайлах, халаасны хулгайн гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, 2022 оны эхний хагас жилд “Мал мах- Хяналт”, “Сар шинэ-2022”, “Илрүүлэлт оргодол”, “Шийдвэрлэлт”, “Carback”, “Арлын дугаар”, “Ломбард хяналт”, “Халаас”, “Бүртгэл” зэрэг ерөнхий болон тусгай арга хэмжээг зохион байгуулснаар нийслэлд 2022 оны эхний 05 сарын байдлаар хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 26.1%-тай ба урьд оны мөн үеийнхээс 1.0%-иар, халаасны хулгайн гэмт хэргийн илрүүлэлт 22.1%-тай ба 5.4%-иар тус тус өссөн байна.



Халаасны хулгайн гэмт хэргийн талаарх 5189 мэдээлэлд дүн шинжилгээ хийж, 26 бүлэг, 995 сэжигтэй этгээдийг тогтоон, бүлэглэлийн зураглал гаргаж, тэдгээрийн гэмт үйлдлийг баримтжуулж, хяналт тавин ажиллаж байна.

“Халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр ерөнхий боловсролын 1949 сурагч, “Улаанбаатар эрдэм” их сургуулийн 60 оюутан, алба хаагч, нийт 2009 иргэнд сургалт орж, мэдээ мэдээлэл өгч, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр 3 мэдээллийг олон нийтэд хүргэсэн.

ASAP санд эрэн сурвалжлагдаж буй 18, эрэн хайсан 15, олдсон 4, баривчилсан 9 хүний нийт 46 зурагт мэдээллийг фэйсбүүк хуудсанд байршуулж, бусад мэдээллийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээсэн ба дээрх мэдээллүүдийн нийт тархалт давхардсан тоогоор 4,600,000 гаруй фэйсбүүк хэрэглэгчид хүрч, 7527 цахим хэрэглэгч бусадтай хуваалцаж, 2198 сэтгэгдэл үлдээсэн ба 15426 хүнд таалагдсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан А/253, А/252 дугаар тушаалаар сайн дурын бүлгэмийн ажиллах журмын хэрэгжилтийг хангах “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”, “School police” буюу эцэг, эхийн эргүүлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, сурталчлах чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн 415 бүлгэмийн 4280 сурагч, 5975 иргэнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Аймаг, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран улсын хэмжээнд өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 21, чуулга уулзалт 2, АХА тэмцээн 2, “Томчуудад хэлэх бидний үг”, “Дэвжээ” тэмцээнийг 7 удаа зохион байгуулж, нийт 2440 сурагчдыг хамруулж, хүүхдийн эрхийн тухай ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 33 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах, олон нийтийн санал, санаачилгыг дэмжих, олон нийтийн байцаагч ажиллуулах зэргээр иргэдийн оролцоог нэмэгдүүлж, тэдний санал, санаачлагыг дэмжиж 2022 онд 198181 иргэн, 8655 төрийн байгууллага, 2428 төрийн бус байгууллага, 10495 аж ахуйн нэгж, байгууллага, 1350 олон нийтийн цагдаа, 1480 олон нийтийн байцаагч, 3548 хүн, хөршийн хяналтын бүлэг, 819 малчдын бүлэг, холбоо, нөхөрлөл, 392 оюутан цагдаа, 1394 өсвөрийн сэргийлэгч, хамтарсан багийн 2092, ерөнхий боловсролын 1946 сургуулийн “School police” эргүүлийн иргэдийг тус тус татан оролцуулж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтэд мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх чиглэлээр тасралтгүй зохион явуулж байгаа төдийгүй, эрдэм шинжилгээ, судалгаа, дүн мэдээнд суурилсан арга хэмжээг зохион байгуулж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ПРОКУРОР - PROSECUTION

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
3. ХЯНАЛТ ТАВЬСАН ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ
4. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦСОН БАЙДАЛ
5. ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТАВЬСАН ХЯНАЛТ
6. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ





2022 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ



ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН ХЭРЭГ НЭЭХЭЭС ТАТГАЛЗСАН

53496



ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН ХЭРЭГ НЭЭСЭН

31012



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЖ ЯЛЛАГДАГЧААР ТАТСАН

13184



2022 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ



ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗСАН

55979



ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ НЭЭСЭН

31598



ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН ХЭРЭГ НЭЭСЭН

2111



ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШАЛГАЖ ШИЙДВЭРЛЭСЭН

141791



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЖ ЯЛЛАГДАГЧААР ТАТСАН

77



2022 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН ХЭРЭГ



НЭГТГЭСЭН

262



ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН ХЭРГИЙГ ХААСАН

19604



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЖ ЯЛЛАГДАГЧААР ТАТСАН

11059



2022 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН МӨРДӨН БАЙЦААЛТЫН ХЭРЭГ



НЭГТГЭСЭН

9443



ТҮДГЭЛЗҮҮЛСЭН

166



ЭХҮЯТ-ЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН

97



ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН

740



ЯЛЛАХ ДҮГНЭЛТ ҮЙЛДСЭН

14944



ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ



ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 6.7-1

523



ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 6.7-1.1

151



ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 6.7-1.2

372



ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХЭРЭГ

5922



ШҮҮХЭЭР ХЭЛЭЛЦЭГДСЭН ЭСЭРГҮҮЦЭЛ



БИЕЛСЭН
ЭСЭРГҮҮЦЭЛ

485



ХЯНАЛТЫН ШАТНЫ
ШҮҮХЭЭР
ХЭЛЭЛЦЭГДСЭН
ЭСЭРГҮҮЦЭЛ

30



ДАВЖ ЗААЛДАХ
ШАТНЫ ШҮҮХЭЭР
ХЭЛЭЛЦЭГДСЭН
ЭСЭРГҮҮЦЭЛ

694



ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТАВЬСАН ХЯНАЛТЫН АЖЛЫН ТАЛААР



НЭЭЛТТЭЙ
ДЭГЛЭМТЭЙ

4394



ХААЛТТАЙ
ДЭГЛЭМТЭЙ

1493



ТУСГАЙ
НЭГЖИД

36



СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН
ТУСГАЙ БАЙГУУЛЛАГАД
(ӨСВӨР НАСНЫ)

83



ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТАВЬСАН ХЯНАЛТЫН АЖЛЫН ТАЛААР



ХОРИХООС ӨӨР
ТӨРЛИЙН ЯЛААР
ШИЙТГҮҮЛСЭН

15480



ТОРГОХ ЯЛААР
ШИЙТГҮҮЛСЭН

9094



ЦАГДАН ХОРИХ, БАРИВЧЛАХ, АЛБАДАН СААТУУЛАХ БАЙРУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВЬСАН ХЯНАЛТЫН ТАЛААР



ЦАГДАН ХОРИХ
БАЙРНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА

1541



БАРИВЧЛАХ
БАЙРНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА

826



АЛБАДАН СААТУУЛАХ
БАЙРНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА

712

1.1.Прокурорын байгууллагын үндсэн чиг үүрэг

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага юм.

1.2.Прокурорын байгууллагын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт


Прокурорын байгууллага нь Улсын Ерөнхий Прокурорын газар, аймаг, нийслэлийн прокурорын газар, сум буюу сум дундын болон дүүргийн прокурорын газраас бүрдэнэ. Прокурорын хяналтын ажлын онцлогийг харгалзан дагнасан чиг үүрэгтэй Тээврийн прокурорын газар үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 1. Прокурорын байгууллагын тогтолцоо



Улсын ерөнхий прокурорын газар нь дараах бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 2. Улсын ерөнхий прокурорын газрын бүтэц, зохион байгуулалт



- Орон тооны бус зөвлөл
1. Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл;
 2. Прокурорын мэргэжлийн зөвлөл;
 3. Прокурорын ёс зүйн зөвлөл
 4. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл;
 5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөл;
 6. Эрдмийн зөвлөл.

Улсын ерөнхий прокурорын зарим зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг:

Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн чиг үүрэг:

- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажлыг боловсронгуй болгох бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;
- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажилд мөрдөгдөж буй хууль, заавар, журмын хэрэгжилтийг нэг мөр хангуулах ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар Улсын ерөнхий прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх;
- Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан, харьяа прокурорын газарт нэгдэн сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг дангаараа болон Сургалтын төвтэй хамтран зохион байгуулах;
- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажилд зөрчлийн хууль тогтоомж, Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан заавар, журмын хэрэгжилтийг дангаараа болон бусад газар, хэлтэстэй хамтран шалгах, судлах;
- Зөрчлийн хэрэгт олгох дугаарын хуваарилалтыг хийх, зөрчлийн хэргийн дугаар олголтод хяналт тавих, тайланг нэгтгэх;
- Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэгдсэн судалгааг тогтмол шинэчлэн, хяналтад бүрэн хамруулах арга хэмжээ авах;

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн чиг үүрэг:

- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажлыг боловсронгуй болгох бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;
- Эрүүгийн хууль тогтоомж, удирдамжийн баримт бичгийг боловсронгуй болгох талаар Улсын ерөнхий прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэг, материалыг хянах, танилцах;
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажилд эрүүгийн хууль тогтоомж, Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан заавар, журмын хэрэгжилтийг дангаараа болон бусад газар, хэлтэстэй хамтран шалгах, судлах;
- Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих чиглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, биелэлт, үр дүнг тооцох;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдоос гаргасан гомдлын дагуу холбогдох эрүүгийн хэрэг, материалыг татаж, гомдлын үндэслэлийг хянан, дээд шатны прокурорт танилцуулж шийдвэрлүүлэх, шаардлагатай гэж үзвэл прокурорын даалгавар бичиж, биелэлтийг тооцох;

Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн чиг үүрэг:

- Шүүхэд төрийг төлөөлөх ажлыг боловсронгуй болгох бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;
- Шүүхэд төрийг төлөөлөх ажлын чиглэлээр Улсын ерөнхий прокурорын тушаалаар баталсан заавар, журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах;
- Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;

- Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд оролцож, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт хууль зүйн дүгнэлт гаргах, хэрэг хянан хэлэлцэх явцад илэрсэн мөрдөгч, прокурор, улсын яллагчийн гаргаж буй нийтлэг зөрчлийг тухай бүр судалж дүгнэн, харьяа прокурорын газарт ажлын чиглэл, зөвлөмж өгөх, мэдээлэл хүргүүлэх;

- Хяналтын шатны шүүхийн шийдвэрийг хууль зөрчсөн гэж үзвэл Улсын ерөнхий прокурорт танилцуулж, эсэргүүцэл бичих эсэх асуудлыг шийдвэрлүүлэх;

- Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанд оролцох Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн /бүрэн эрхээ шилжүүлсэн тохиолдолд/ шүүх хуралдаанд гаргах хууль зүйн дүгнэлтийн төслийг боловсруулж, шүүх хуралдаанд оролцох бэлтгэлийг хангах;

Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн чиг үүрэг:

- Ял эдлүүлэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажлыг боловсронгуй болгох бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;

- Ял эдлүүлэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих чиглэлээр хууль тогтоомж, удирдамж, баримт бичгийг боловсронгуй болгох талаар Улсын ерөнхий прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;

- Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;

- Ял эдлүүлэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажилд хууль тогтоомж, Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан заавар, журмын хэрэгжилтийг дангаараа болон бусад хэлтэстэй хамтран шалгах, танилцах;

- Хяналтын чиглэлээр ирүүлсэн гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэх;

- Ялтан шилжүүлэх тухай хууль тогтоомж, олон улсын гэрээний хэрэгжилтийг Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэстэй хамтран зохион байгуулах;

Хэрэг эрхлэх газрын чиг үүрэг:

- Прокурорын байгууллагын хүний нөөцийн бодлого, хөгжлийн асуудлыг хариуцан, хүний нөөц бүрдүүлэх, прокурор, ажилтныг чадавхжуулах ажлыг нэгтгэн зохион байгуулах;

- Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, тендерийн үйл ажиллагаа, аж ахуй, хангалт, үйлчилгээ, прокурор, ажилтны цалин хөлс, ажиллах нөхцөл боломж, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг нэгтгэн зохион байгуулах, энэ чиглэлээр гаргах Улсын ерөнхий прокурорын шийдвэр, бусад баримт бичгийн төслийг бэлтгэх, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт үр дүнг тооцох;

- Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд прокурорын байгууллагын тухайн жилийн урсгал зардлын болон хөрөнгө оруулалтын төсвийн багцыг төлөвлөж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

- Прокурорын байгууллагын нэгдсэн төсвийн хүрэлцээ, цаг үеийн шаардлага, инфляц зэргийг харгалзан нэмэгдэл төсөв батлуулах, хүндрэлтэй асуудлыг шийдвэрлүүлэх санал боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулан төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

- Тухайн жилийн Төсвийн тухай хуулиар батлагдсан прокурорын байгууллагын урсгал зардлын болон хөрөнгө оруулалтын төсвийн хуваарилалтын талаар санал боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулах;

- Батлагдсан төсвийн хүрээнд харьяа прокурорын газрын санхүүжилтийг сар бүр тооцох, олгогдоогүй санхүүжилтийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, санхүүжилтийг төлөвлөгөөний дагуу шийдвэрлүүлэх;

Сургалт, судалгааны хүрээлэнгийн чиг үүрэг:

- Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж болон харьяа прокурорын газраас сургалтын хэрэгцээ, шаардлагын талаарх саналыг авч нэгтгэн судалсны үндсэн дээр прокурор, ажилтанд зориулсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- Прокурор ажилтны анхан, үргэлжилсэн шатны болон давтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхтэй холбоотой сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, биелэлтийг хангах;
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу сургалтын хөтөлбөрийг боловсруулан магадлан итгэмжлүүлсний үндсэн дээр тухайн сургалтыг дангаараа болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Эрдэм шинжилгээний байгууллага, хууль зүйн их, дээд сургууль, бусад байгууллагатай хамтран эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал зохион байгуулах, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, бүтээл гаргах;
- Хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаарх судалгааг Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй хамтран гүйцэтгэх;
- Сургалтын гарын авлага, ном, товхимол гаргах;

2.Прокурорын байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөө

Прокурорын байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулсан.

Зураг 3. Монгол Улсын прокурорын байгууллагын стратеги төлөвлөгөө

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, гадаад, дотоод орчны хурдацтай өөрчлөлт нь прокурорын байгууллагын үйл ажиллагааг шинэ түвшинд эргэн харах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль 2017 онд шинэчлэгдэн батлагдсанаар эрх зүйн шинэ орчны хүрээнд зөрчлийн хэрэг бүртгэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох үйл ажиллагааг төгөлдөржүүлж, боловсронгуй болгоход энэхүү стратеги төлөвлөгөө чиглэж байна.



Стратеги төлөвлөгөөг ухаалаг (smart), зорилго тодорхой байх (specific), хэмжиж болохуйц (measurable), зорилгодоо хүрч болохуйц байх (achievable), бодитой байх (revelant), цаг хугацаатай байх (time bound efforts) гэсэн зарчмыг баримтлан боловсруулсан.

Энэхүү стратеги төлөвлөгөө нь Монгол Улсын прокурорын байгууллагын үйл ажиллагааны 2023-2026 онд баримтлах бодлогын баримт бичиг юм. Стратеги төлөвлөгөө батлагдан хэрэгжсэнээр прокурорын байгууллагын өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаагаа сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэх юм.

Прокурорын байгууллага нь 2023-2026 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөнд дараах 5 зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон. Үүнд:

- ✓ “Олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх”;
- ✓ “Прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах”;
- ✓ “Прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох”;
- ✓ “Хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг сайжруулах”;
- ✓ “Цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх”.


Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд прокурорын байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшил, инновацыг нэвтрүүлэх, ажлын үр нөлөө, бүтээмжийг нэмэгдүүлэх, их өгөгдлийг бодлогын шийдвэр гаргахад ашиглах, зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, статистикийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зэрэг арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.1. Хяналт тавьсан зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн үзүүлэлт

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий 34 байгууллагын 10464 эрх бүхий албан тушаалтан судалгаанд хамрагдсанаас 33.2% нь цагдаагийн байгууллагын, 13.2% нь мэргэжлийн хяналтын байгууллагын, 12.4% нь татварын байгууллагын, 6.6% нь гаалийн байгууллагын, 0.8% нь гадаадын иргэн, харьяатын байгууллагын эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанд улсын хэмжээнд 82 прокурор хяналт тавин ажиллажээ.


Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагууд 2022 онд зөрчлийн талаарх нийт 233090 гомдол, мэдээлэл хүлээн авч, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн шалгасан нь өмнөх оноос 26898 буюу 13%-иар өсжээ.

График 1. Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Нийт гомдол, мэдээллийн 156058 буюу 66.9%-д нь улс, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрууд, 77032 буюу 33.1%-д нь бусад орон нутгийн прокурорын газрууд тус тус хяналт тавьж ажиллажээ.

График 2. Улс, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүдийг харуулбал




Дээрх үзүүлэлтээс харвал зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байдлаар Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүргийн прокурорын газрууд тэргүүлж байгаа бол Улсын ерөнхий прокурорын газар, Тээврийн прокурорын газар, Багануур дүүргийн прокурорын газар хамгийн бага үзүүлэлттэй байна.

Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байдлаар Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн прокурорын газрууд хамгийн их байгаа бол Улсын ерөнхий прокурорын газар, Багануур дүүргийн прокурорын газар, Тээврийн прокурорын газар хамгийн бага байна.

Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллээс зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсэн байдлаар хамгийн их нь Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн прокурорын газрууд байгаа бол хамгийн бага нь Улсын ерөнхий прокурорын газар, Тээврийн прокурорын газар, Багануур дүүргийн прокурорын газар байна.

Мөн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллээс эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шийдвэрлэсэн тохиолдлоос хамгийн их нь Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрууд байгаа бол хамгийн бага нь Тээврийн прокурорын газар болон Нийслэлийн прокурорын газар байна.

График 3. Орон нутгийн прокурорын газрын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд



Орон нутгийн прокурорын газруудын хувьд зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн тохиолдол Баянхонгор, Хэнтий, Сэлэнгэ аймгийн прокурорын газруудад хамгийн их байгаа бол Говьсүмбэр, Дорноговь, Төв аймгийн прокурорын газарт хамгийн бага байна.

Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байдлаар Өвөрхангай, Ховд, Сэлэнгэ аймгийн прокурорын газар хамгийн их байгаа бол Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар аймгийн прокурорын газар хамгийн бага байна.

Зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсэн тохиолдол Өвөрхангай, Сэлэнгэ, Орхон аймгийн прокурорын газруудад хамгийн их, Дундговь, Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн прокурорын газруудад хамгийн бага, эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн тохиолдол Орхон, Сэлэнгэ, Өвөрхангай аймгийн прокурорын газруудад хамгийн их, Архангай, Дундговь, Хөвсгөл аймгийн прокурорын газруудын хувьд хамгийн бага, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тохиолдол Ховд, Дархан-Уул, Говь-Алтай аймгийн прокурорын газруудад хамгийн их, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс аймгийн прокурорын газрын хувьд бүртгэгдээгүй байна.

2.2.Хяналт тавьсан зөрчлийн хэрэг, түүний шийдвэрлэлт

Прокурорын байгууллага нь 2022 онд нийт 2698521 зөрчлийн хэрэгт хяналт тавьж ажилласан байна. Үүнийг шийдвэрлэлтийн байдлаар нь авч үзвэл газар дээр нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, шийтгэл оногдуулсан хэрэг 2523325 буюу 93.5%-ийг, бүртгэж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэж шийтгэл оногдуулсан хэрэг 141791 буюу 5.25%-ийг, зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн хэрэг 33405 буюу 1.23%-ийг тус тус эзэлж байна.

Үүнийг өмнөх жил буюу 2021 оны прокурорын байгууллагын хяналт тавьсан нийт 2046624 зөрчлийн хэрэгтэй харьцуулбал 651897 хэргээр буюу 31.8%-иар, хяналт тавьсан зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийг өмнөх жилтэй харьцуулбал газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан шийдвэр 623172 буюу 32.8%-иар, бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан шийдвэр 25330 буюу 21.7%-иар, зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн шийдвэр 3395 буюу 11.3%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Улс, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын хяналт тавьсан зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд

	Прокурорын байгууллагын хяналт тавьсан нийт зөрчлийн хэрэг	Газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн
2021	2046624	1900153	116461	30010
2022	2698521	2523325	141791	33405
Өөрчлөлтийн үзүүлэлт	+31.8%	+32.7%	+21.7%	+11.3%

2.3.Прокурорын байгууллагын хяналт тавьсан зөрчлийн хэргийн нутаг дэвсгэрийн үзүүлэлт Нийслэлийн үзүүлэлт

Хүснэгт 2. Улс, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын хяналт тавьсан зөрчлийн хэргийн үзүүлэлтүүд

Нэгж газрын нэрс	Хяналт тавьсан зөрчлийн хэргийн тоо
УЕПГ	91
Нийслэл ПГ	3072
Баянгол ДПГ	367216
Баянзүрх ДПГ	374901

Сонгинохайрхан ДПГ	149988
Сүхбаатар дүүргийн ПГ	282858
Хан-Уул ДПГ	177584
Чингэлтэй ДПГ	519478
Багануур ДПГ	38657
Налайх, Багахангай ДПГ	69873
Тээврийн ПГ	61796
Нийт	2045514

Дээрх тоон үзүүлэлтийг авч үзвэл Чингэлтэй дүүргийн прокурорын газар нь хамгийн их буюу 519478 хэрэгт хяналт тавьсан нь нийт зөрчлийн хяналт тавьсан хэргийн 25.3%-ийг эзэлж байна.

Орон нутгийн үзүүлэлт

Хүснэгт 3. Орон нутгийн прокурорын газрын хяналт тавьсан зөрчлийн хэргийн үзүүлэлтүүд

Нэгж газрын нэрс	Хяналт тавьсан зөрчлийн хэргийн тоо
Архангай АПГ	27290
Баян-Өлгий АПГ	21423
Баянхонгор АПГ	22638
Булган АПГ	36731
Говь-Алтай АПГ	22854
Говьсүмбэр АПГ	22942
Дархан-Уул АПГ	50752
Дорноговь АПГ	26413
Дорнод АПГ	21003
Дундговь АПГ	21492
Завхан АПГ	23895
Орхон АПГ	26034
Өвөрхангай АПГ	62549
Өмнөговь АПГ	37470
Сүхбаатар аймгийн ПГ	16816
Сэлэнгэ АПГ	36120
Төв АПГ	65694
Увс АПГ	25093
Ховд АПГ	28665
Хөвсгөл АПГ	25760
Хэнтий АПГ	31373
Нийт	653007

Тухайн жилд орон нутгийн прокурорын газрууд нь нийт 653007 зөрчлийн хэрэгт хяналт тавьсан. Үүнээс, Төв аймгийн прокурорын газар хамгийн их буюу 65694 хэрэгт хяналт тавьсан нь нийт зөрчлийн хэргийн 10%-ийг эзэлж байна. Харин Сүхбаатар аймгийн прокурорын газар нийт 16816 зөрчлийн хэрэгт хяналт тавьсан нь нийт хэргийн 2.5%-ийг эзэлж байна.

2.4.Прокурорын байгууллагын хяналт тавьсан зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн үзүүлэлт

Нийслэлийн үзүүлэлт

Хүснэгт 4. Улс, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын хяналт тавьсан зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд

Нэгж прокурорын газрын нэрс	Газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн
УЕПГ	0	60	31
Нийслэл ПГ	97	2551	424
Баянгол ДПГ	352839	12603	1774

Баянзүрх ДПГ	354305	16608	3988
Сонгинохайрхан ДПГ	129970	16968	3050
Сүхбаатар дүүргийн ПГ	269133	11695	2030
Хан-Уул ДПГ	163565	11430	2589
Чингэлтэй ДПГ	504790	12524	2164
Багануур ДПГ	36972	1298	387
Налайх, Багахангай ДПГ	66376	3059	438
Тээврийн ПГ	59469	2117	210
Нийт	1937516	90913	17085

Нийслэлийн хувьд зөрчлийн хэргийг газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан нийт 1937516 хэрэг бүртгэгдсэн байна. Үүнээс Чингэлтэй дүүргийн прокурорын газар хамгийн өндөр шийдвэрлэлтийн үзүүлэлттэй (26%) байна.

Зөрчлийн хэргийг бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан хэргийн тухайд нийт 90913 бүртгэгдсэнээс хамгийн их үзүүлэлтийг Баянзүрх дүүргийн прокурорын газар (18.2%), хамгийн бага үзүүлэлтийг Улсын ерөнхий прокурорын газар (0.06%), зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргийг нээсэн хэргийн тухайд нийт 17085 бүртгэгдсэнээс хамгийн их үзүүлэлтийг Баянзүрх дүүргийн прокурорын газар (23.34%), хамгийн бага үзүүлэлтийг Улсын ерөнхий прокурорын газар (0.18%) эзэлж байна.

Орон нутгийн үзүүлэлт


Хүснэгт 5. Орон нутгийн прокурорын газрын хяналт тавьсан зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд

Нэгж прокурорын газрын нэрс	Газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн
Архангай АПГ	25073	1519	698
Баян-Өлгий АПГ	18393	2311	719
Баянхонгор АПГ	19067	2596	975
Булган АПГ	33845	2233	653
Говь-Алтай АПГ	20694	1602	558
Говьсүмбэр АПГ	21922	707	313
Дархан-Уул АПГ	46847	3092	813
Дорноговь АПГ	22685	3007	721
Дорнод АПГ	17617	2781	605
Дундговь АПГ	20158	1069	265
Завхан АПГ	21829	1487	579
Орхон АПГ	21848	3164	1022
Өвөрхангай АПГ	57151	3694	1704
Өмнөговь АПГ	33704	3051	715
Сүхбаатар аймгийн ПГ	14963	1392	461
Сэлэнгэ АПГ	31816	3107	1197
Төв АПГ	62014	2719	961
Увс АПГ	21451	2967	675
Ховд АПГ	24361	3608	696
Хөвсгөл АПГ	22913	1870	977
Хэнтий АПГ	27458	2902	1013
Нийт	585809	50878	16320

Орон нутгийн хувьд зөрчлийн хэргийг газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан нийт 585809 хэрэг бүртгэгдсэн ба үүнээс хамгийн өндөр үзүүлэлтийг Төв аймгийн прокурорын газар (10.5%), хамгийн бага үзүүлэлтийг Сүхбаатар аймгийн прокурорын газар (2.5%), зөрчлийн хэргийг бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан нийт 50878

хэрэг бүртгэгдсэн ба үүнээс хамгийн өндөр үзүүлэлтийг Өвөрхангай аймгийн прокурорын газар (7.2%), хамгийн бага үзүүлэлтийг Говьсүмбэр аймгийн прокурорын газар (1.3%), зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргийг нээсэн нийт 16320 хэрэг бүртгэгдсэн ба үүнээс хамгийн өндөр үзүүлэлтийг Өвөрхангай аймгийн прокурорын газар (10.4%), хамгийн бага үзүүлэлтийг Дундговь аймгийн прокурорын газар (1.6%) тус тус үзүүлж байна.

График 4. Шүүхээс баривчлах болон торгох шийтгэл оногдуулсан байдал



Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрээс биелэгдээгүй шийдвэрийг хангуулахаар харьяалах шүүхэд хүсэлт гаргасан байдал өмнөх оноос 70.3%-иар өссөн бол шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд баривчлах шийтгэлээр солиулах санал гаргасан байдал өмнөх оноос 2.8 дахин өссөн байна.


График 5. ЭБАТ-ны хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн болон шийтгэл оногдуулсан шийдвэрийг хянаад прокурор дүгнэлт бичсэн байдал



Нийслэл, дүүргийн хэмжээнд Чингэлтэй дүүргийн прокурорын газар 455, Хан-Уул дүүргийн прокурорын газар 421, Баянзүрх дүүргийн прокурорын газар 268, аймгийн хэмжээнд Сэлэнгэ аймгийн прокурорын газар 306, Өвөрхангай аймгийн прокурорын газар 286, Архангай аймгийн прокурорын газар 178 прокурорын дүгнэлт тус тус бичсэн нь хамгийн их бол, Сүхбаатар дүүргийн прокурорын газар 73, Тээврийн прокурорын газар 27, Багануур дүүргийн прокурорын газар 15, аймгийн хэмжээнд Өмнөговь аймгийн прокурорын газар 22, Баян-Өлгий аймгийн прокурорын газар 26 прокурорын дүгнэлт бичсэн нь хамгийн бага байна.

Прокурор зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах чиглэлээр нийт 8134 зөвшөөрөл олгосон нь өмнөх оноос 3411 буюу 72.2%-иар өсжээ.

График 6. Зөвшөөрөл олгосон байдал



Эрх бүхий албан тушаалтнаас хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй явуулсан 294 ажиллагааны 292 ажиллагааг хүчинтэйд тооцож, хүчингүйд тооцсон 2 тохиолдол байна. Дээрх хугацаанд эрх бүхий албан тушаалтнаас гаргасан прокурорын зөвшөөрөл авах санал 34, хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй явуулсан 2 ажиллагааг прокуророос хүчингүй болгожээ.

Прокурор эрх бүхий байгууллагад нийт 470 удаа шалгалт хийсэн нь өмнөх оноос 75 буюу 19%-иар, судалгаа 158 удаа хийсэн нь 23 буюу 17%-иар тус тус өсжээ. Хяналт, шалгалтын явцад болон шалгалт, судалгаагаар хүн, хуулийн этгээдийн эрхийг зөрчсөн 4469 зөрчил илрүүлсэн нь өмнөх оноос 2679 буюу 1.5 дахин, 3451 хүний зөрчигдсэн эрхийг сэргээсэн нь 2414 буюу 2.3 дахин өссөн байна.

2.5.Прокурорын байгууллагын хяналт тавьсан зөрчлийн хэргийг тодорхой төрлөөр харуулсан үзүүлэлт

1.Нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил

Нийт 20 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд энэ төрлийн нийт 143275 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйл Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах зөрчил хамгийн их буюу 104.167 (72.70%), 5.17, 5.18, 5.20 дугаар зүйлд заасан зөрчлүүд бүртгэгдээгүй байна.

2.Нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчил

Нийт 28 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд нийт 9529 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 6.20 дүгээр зүйл “Хүүхдийн эрхийг зөрчих” зөрчил хамгийн их буюу 5878 (61.68%), харин 6.9, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.16, 6.21, 6.23, 6.25, 6.28 дугаар зүйлд заасан зөрчлүүд бүртгэгдээгүй байна.

3.Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил

Нийт 17 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд энэ төрлийн нийт 1691 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл буюу Амьтны тухай хууль зөрчих зөрчил хамгийн их буюу 562 (33.23%), харин 7.5 дугаар зүйл буюу Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль зөрчих, зөрчил бүртгэгдээгүй байна.

4.Нийтийн өмч, өмчлөх эрхийн эсрэг зөрчил

Нийт 9 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд энэ төрлийн нийт 5091 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 8.8 дугаар зүйл “Эд хөрөнгө устгах, гэмтээх” зөрчил хамгийн их буюу 3205 (62.65%), 8.2 дугаар зүйл “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль зөрчих” зөрчил хамгийн бага буюу 5 бүртгэгдсэн байна.

5.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил

Нийт 11 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд тус төрлийн нийт 25 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйл “Боловсролын тухай хууль зөрчих” зөрчил 19, 9.2 дугаар зүйл “Бага, дунд боловсролын тухай хууль зөрчих” зөрчил, 9.7 дугаар зүйл “Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих” зөрчил тус бүр 2, 9.10 дугаар зүйл “Монгол хэлний тухай хууль зөрчих” зөрчил, 9.11 дүгээр зүйл “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль зөрчих” зөрчил тус бүр 1 бүртгэгдсэн бол бусад зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

6.Аж ахуйн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил

Нийт 29 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд энэ төрлийн нийт 2533 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 10.4 дүгээр зүйл “Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих” зөрчил хамгийн их буюу 1238 (48.87%), харин 10.3, 10.5, 10.6, 10.8, 10.9, 10.12, 10.14, 10.17, 10.18, 10.19, 10.22, 10.23, 10.28, 10.29 дүгээр зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

7.Үнэт цаас, банк санхүү, гааль, татвар, даатгалын журмын эсрэг зөрчил

Нийт 32 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд энэ төрлийн нийт 34835 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 11.15 дүгээр зүйл “Жолоочийн даатгалын тухай хууль зөрчих” зөрчил хамгийн их буюу 31351 бүртгэгдсэн нь 90 хувийг эзэлж байна. Харин 11.4, 11.11, 11.16, 11.17, 11.20, 11.23, 11.25, 11.26, 11.27, 11.28 дугаар зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

8.Барилга, үйлдвэрлэл, эрчим хүчний журмын эсрэг зөрчил

Нийт 12 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд энэ төрлийн нийт 363 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан бай ба Зөрчлийн тухай хуулийн 12.1 дугаар зүйл “Барилгын тухай хууль зөрчих” зөрчил хамгийн их буюу 138 (38%), харин 12.9 дүгээр зүйл “Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль зөрчих”, 12.10 дугаар зүйл “Нийтийн зориулалттай инженерийн байгууламжид хууль бусаар холбогдох хэрэгсэл хэрэглэх журам зөрчих”, 12.12 дугаар зүйл “Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль зөрчих” зөрчлүүд бүртгэгдээгүй байна.

9.Хөдөө аж ахуй, газар тариалангийн талаар тогтоосон журмын эсрэг зөрчил

Нийт 9 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд энэ төрлийн нийт 1466 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 13.5 дугаар зүйл “Мал, махны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх журам зөрчих” зөрчил хамгийн их буюу 1216 (82.94%), 13.12, 13.3, 13.4, 13.6, 13.7, 13.8 дугаар зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

10.Мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил

Нийт 12 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд энэ төрлийн нийт 2460502 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйл “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих” зөрчил хамгийн их буюу 2,383,730 байгаа нь энэ төрлийн зөрчлийн 96.87%-ийг бүрдүүлж байна. Харин 14.9 дүгээр зүйлд заасан зөрчил огт бүртгэгдээгүй байна.

11.Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил

Нийт 31 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд энэ төрлийн 25103 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 15.9 дүгээр зүйл “Хуурамч дуудлага, мэдээлэл өгөх” зөрчил 12.448 бүртгэгдэж хамгийн их буюу 49.58 хувийг бүрдүүлж байна. Харин 15.8, 15.12, 15.13, 15.16, 15.18, 15.19, 15.28, 15.29, 15.31 дүгээр зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

12.Монгол Улсын хилийн аюулгүй байдлын болон гадаад иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад зорчих журмын эсрэг зөрчил

Нийт 4 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд энэ төрлийн 561 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 16.1 дүгээр зүйл “Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих” зөрчил хамгийн их буюу 332 (59.18%), харин 16.3, 16.4 дүгээр зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

13. Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил

Нийт 1 төрлийн зөрчил хамаардаг ба 2022 онд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан “Сонгуулийн хууль зөрчих” 24 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна.

3.1. Хяналт тавьсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн үзүүлэлт


Прокурорын байгууллагаас 2022 онд нийт 103451 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хяналт тавьж ажилласан нь өмнөх оноос 32411 буюу 45.6%-иар өсжээ. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн 78967 буюу 76.3%-д нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрууд, 24484 буюу 23.7%-д аймгийн прокурорын газруудаас хяналт тавин ажиллажээ.

Нийт гомдол, мэдээллийн 101964 буюу 98.6%-ийг цагдаагийн байгууллага, 1397 буюу 1.4%-ийг Авлигатай тэмцэх газар, 90 буюу 0.1%-ийг тагнуулын байгууллага тус тус хүлээн авч шалгасан байна.

Хүлээн авч шалгасан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл Говьсүмбэр аймагт 2.9%-иар буурч, бусад газруудад 6.3-67.1%-иар өссөн байна.

Гомдол, мэдээлэл өссөн нь цар тахлын хөл хорио цуцлагдаж, ард иргэдийн амьдрал хэвийн горимд шилжсэн, кибер орчинд хууль бусаар халдах, цахим хэрэгсэл ашиглаж үйлдэгдсэн, тэр дундаа залилах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл өссөнтэй холбоотой гэж дүгнэсэн.

График 7. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Хяналт тавьсан нийт гомдол, мэдээллийн 51.7%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан нь өмнөх оноос 17994 буюу 50.7%-иар, 30%-д нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь 9253 буюу 42.5%-иар, 12.7%-д нь эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 4653 буюу 54.5%-иар тус тус өссөн.

Нийт хяналт тавьсан гомдол, мэдээллийг нэгжүүдээр харьцуулж харуулбал дараах үзүүлэлттэй байна.

График 8. Нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг харуулбал




Дээрх үзүүлэлтээс харвал гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шийдвэрлэсэн байдал Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн прокурорын газар хамгийн их бол Багануур, Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар хамгийн бага байна.

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж шийдвэрлэсэн шийдвэрийн тухайд хамгийн их нь Баянзүрх, Баянгол, Чингэлтэй дүүргийн прокурорын газрууд байгаа бол хамгийн бага нь Нийслэл, Багануур дүүргийн прокурорын газрууд байна.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байдлаар Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн прокурорын газрууд хамгийн их байгаа бол Багануур, Налайх, Багахангай дүүргийн прокурорын газрууд хамгийн бага үзүүлэлттэй байна.

График 9. Орон нутгийн прокурорын газруудын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг харуулбал



Орон нутгийн прокурорын газрын тухайд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шийдвэрлэсэн байдал Төв, Сэлэнгэ, Өмнөговь аймгийн прокурорын газруудад хамгийн их байгаа бол Говьсүмбэр, Увс, Говь-Алтай аймгийн прокурорын газруудад хамгийн бага байна.

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан байдал Хөвсгөл, Дархан-Уул, Архангай аймгийн прокурорын газруудад хамгийн их байгаа бол Говь-Алтай, Говьсүмбэр, Баян-Өлгий аймгийн прокурорын газруудын хувьд хамгийн бага байна.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байдал Хэнтий, Орхон, Төв аймгийн прокурорын газруудад хамгийн их байгаа бол Говьсүмбэр, Өвөрхангай, Завхан аймгийн прокурорын газруудад хамгийн бага үзүүлэлттэй байна.


3.2.Хяналт тавьсан хэрэг бүртгэлтийн хэргийн үзүүлэлт

Прокурорын байгууллага нь 2022 онд хэрэг бүртгэлт явуулсан нийт 58369 хэрэгт хяналт тавьсан нь өмнөх оноос 9131 буюу 18.5%-иар өсжээ. Хэрэг бүртгэлт явуулсан нийт хэргийн 57000 буюу 97.7%-ийг цагдаагийн байгууллага, 1294 буюу 2.2%-ийг Авлигатай тэмцэх газар, 69 буюу 0.1%-ийг тагнуулын байгууллага, 6 буюу 0.01%-ийг хамтарсан ажлын хэсгээр шалгасан байна.

Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн 42810 буюу 73.3%-д нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрууд, 15559 буюу 26.7%-д орон нутгийн прокурорын газрууд хяналт тавин ажиллажээ.

Хэрэг бүртгэлт явуулсан нийт хэргийн 39870 буюу 68.3%-ийг “Өмчлөх эрхийн эсрэг”, 8021 буюу 13.7%-ийг “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг”, 2980 буюу 5.1%-ийг “Хүний амьд явах эрхийн эсрэг”, 1608 буюу 2.8%-ийг “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг”, 1177 буюу 2%-ийг “Авлигын гэмт хэрэг”, 1152 буюу 2%-ийг “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг” гэмт хэрэг тус тус эзэлж байна.

График 10. Хэрэг бүртгэлтийн хэргийн шийдвэрлэлт



3.3.Хяналт тавьсан мөрдөн байцаалтын хэргийн үзүүлэлт

Мөрдөн байцаалт явуулсан нийт 26149 эрүүгийн хэрэгт хяналт тавьж ажилласны 24424 буюу 93.6% нь 2022 онд шинээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэргүүд байна.

Мөрдөн байцаалт явуулсан хэргийн 25647 буюу 98.1%-ийг цагдаагийн байгууллага, 456 буюу 1.7%-ийг Авлигатай тэмцэх газар, 43 буюу 0.2%-ийг тагнуулын байгууллага, 3 буюу 0.01%-ийг хамтарсан ажлын хэсгээр шалгасан байна.

Мөрдөн байцаалтын хэргийн 17396 буюу 66.5%-д нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрууд, 8753 хэрэг буюу 33.5%-д орон нутгийн прокурорын газруудаас тус тус хяналт тавин ажиллажээ.


Мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийн 13855 буюу 53.0%-ийг “Өмчлөх эрхийн эсрэг”, 8702 буюу 33.3%-ийг “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг”, 1241 буюу 4.7%-ийг “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг”, 632 буюу 2.4%-ийг “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг”, 504 буюу 1.9%-ийг “Хүрээлэн байгаа орчны эсрэг” гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Мөрдөн байцаалт явуулсан хэрэг өмнөх оноос Баянхонгор аймагт 9.7%-иар, Говь-Сүмбэр аймагт 7.9%-иар, Дорнод аймагт 3.9%-иар, Дундговь аймагт 1.9%-иар, Булган аймагт 1.2%-иар тус тус буурсан бол бусад прокурорын газруудад 0.2-53.0%-иар өсжээ.

Нийслэлийн хэмжээнд хяналт тавьсан нийт 17396 хэргийн 4109 буюу 23.6%-д Баянзүрх дүүргийн прокурорын газар, 2806 буюу 16.1%-д Сүхбаатар дүүргийн прокурорын газар, 2458 буюу 14.1%-д Баянгол дүүргийн прокурорын газар хяналт тавьсан нь хамгийн их бол 628 буюу 3.6%-д Тээврийн прокурорын газар, 327 буюу 1.9%-д Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар, 162 буюу 0.9%-д Багануур дүүргийн прокурорын газар хяналт тавьсан нь хамгийн бага байна.

Орон нутгийн прокурорын газруудаас хяналт тавьсан нийт 8753 хэргийн 738 буюу 8.4%-д Хөвсгөл аймгийн прокурорын газар, 726 буюу 8.3%-д Төв аймгийн прокурорын газар, 561 буюу 6.4%-д Өвөрхангай аймгийн прокурорын газар, 553 буюу 6.3%-д Сэлэнгэ аймгийн прокурорын газар, 540 буюу 6.2%-д Дорноговь аймгийн прокурорын газар хяналт тавьсан нь хамгийн их бол Увс аймгийн прокурорын газар 256 буюу 2.9%-д, Дундговь аймгийн прокурорын газар 209 буюу 2.4%-д, Говь-Алтай аймгийн прокурорын газар 204 буюу 2.3%-д, Говьсүмбэр аймгийн прокурорын газар 117 буюу 1.3%-д тус тус хяналт тавьсан нь хамгийн бага байна.

График 11. Мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт



3.4. Мөрдөн байцаалтын хэргийн яллагдагч

Прокурорууд 2022 онд 26149 хэрэгт 17232 хүн, 50 хуулийн этгээдийг яллагдагчаар татсаны 1127 буюу 6.5% нь өсвөр насны яллагдагч байна.


3.5. Хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хохирогчийн байдал

Прокурорын байгууллагаас хянасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хохирогчийн ерөнхий тоон үзүүлэлт нь өмнөх оноос 48.9%-иар өссөн, мөн бусад үзүүлэлт ч өссөн дүнтэй байна. Тухайлбал, эмэгтэй хохирогч (52.9%), насанд хүрээгүй хохирогч (51.9%), амь насаар хохирсон хүн (20.6%), эрүүл мэндээр хохирсон хүн (16.7%), гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн тоо (11.4%) тус тус өсжээ.

Хүснэгт 6. Прокурорын хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хохирогчийн 2021, 2022 оны харьцуулсан үзүүлэлтүүд

	Нийт хохирогч	Эмэгтэй хохирогч	Насанд хүрээгүй хохирогч	Амь насаар хохирсон хүн	Эрүүл мэндээр хохирсон хүн	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн
2021	26359	12007	1383	2003	10349	661
2022	39258	18369	2101	2417	12083	737
Өөрчлөлтийн үзүүлэлт	+48.9%	+52.9%	+51.9%	+20.6%	+16.7%	+11.4%

График 12. Прокурорын хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хохирогчийн 2021, 2022 оны харьцуулсан үзүүлэлтүүд



3.6. Прокурорын байгууллагын хяналт тавьсан эрүүгийн хэргийг Эрүүгийн хуульд заасан бүлгээр авч үзвэл:

Хүснэгт 7. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (ЭХ-ийн 10 дугаар бүлэг)

Гэмт хэргийн төрөл	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүсгэсэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
10.1 дүгээр зүйл. Хүнийг алах	429	3	242	4	15	210
10.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах	2	0	1	0	0	1
10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	2702	0	7	3	2072	2226
10.5 дугаар зүйл. Эх нярай хүүхдээ алах	9	0	1	0	2	5
10.6 дугаар зүйл. Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	188	11	73		38	112
Нийт	3330	14	324	7	2127	2554

Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэгт хамаарах нийт 3330 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба энэ нь хяналт тавьсан нийт хэргийн 4.46%-ийг эзэлж байна.

Энэхүү 3330 хэргийн 0.4%-ийг хэрэгсэхгүй болгож, 9.72%-ийг шүүхэд шилжүүлж, 0.21%-ийг бусад хэрэгт нэгтгэж, 63.87%-ийг хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байна.

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргээс “Хүнийг алах” гэмт хэрэг (12.88%), “Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх” (81.14%), “Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох” (5.64%) гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлж байна.

Хэрэгсэхгүй болгосон хэргийн тухайд “Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох” (78.57%), шүүхэд шилжүүлсэн хэргийн тухайд “Хүнийг алах” (74.69%), нэгтгэсэн хэргийн тухайд “Хүнийг алах” (57.14%), хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тухайд “Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх” (97.41%), тухайн жилд шинээр үүссэн хэргийн тухайд “Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх” (87.15%) гэмт хэргүүд тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (ЭХ-ийн 11 дүгээр бүлэг)

Гэмт хэргийн төрөл	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүсгэсэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	821	8	433	10	97	498
11.2 дугаар зүйл. Сэтгэл санаа хүчтэй давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах	10	2	5	0	1	7
11.3 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	150	11	50	0	40	100
11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	1293	43	736	20	148	1001
11.5 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	162	5	20	0	63	126
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн Алтанширээ, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайхандулаан, Мандах, Иххэт, Хөвсгөл, Хатанбулаг, Сайншанд сумд
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн Улиастай, Алдархаан, Дөрвөлжин, Завхан-Мандал, Идэр, Отгон, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Сантмаргац, Сонгино, Шилүүстэй, Яруу, Эрдэнэхайрхан сумд
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн Баяндалай, Булган, Гурвантэс, Даланзадгад, Мандал-Овоо, Номгон, Ноён, Сэврэй, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо сумд
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Богд, Уянга, Тарагт, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Нарийн тээл, Хайрхандулаан, Сант, Төгрөг, Баянгол, Арвайхээр сумд
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Зүүнбүрэн, Ерөө, Түшиг, Шаамар, Хүдэр, Жавхлант,

			Цагааннуур, Хушаат, Сүхбаатар сумд
17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн Дөргөн, Буянт, Дарви, Дуут, Жаргалант, Зэрэг, Манхан, Мянгад, Мөнххайрхан, Чандмань, Эрдэнэбүрэн, Ховд сумд
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн Батноров, Батширээт, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Хэрлэн Цэнхэрмандал сумд

1.3.2. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд “Шүүх байгуулах тухай” Монгол Улсын 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар Аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийг иргэний, эрүүгийн болон захиргааны шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосны дагуу Нийслэлийн шүүх нь Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх болон зохион байгуулагдаж Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж болон Төв аймгийн Зуунмод, Алтанбулаг, Баян-Өнжүүл, Заамар, Лүн зэрэг 22 сум, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг дэвсгэрийг харьяалан шүүн таслах ажлыг хэрэгжүүлсэн байна.

“Шүүх байгуулах тухай” Монгол Улсын 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар давж заалдах шатны шүүхийг байгуулж тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосны дагуу Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх болон өөрчлөгдөж, нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийг харьяалан шүүн таслах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Орон нутгийн шүүхийн хувьд 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан “Монгол Улсын Шүүхийн тухай” хуульд “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулна” гэж заасны дагуу орон нутгийн хувьд давж заалдах шатны 9 шүүхийг байгуулахаар 2013 оны 1 дүгээр сарын 24-нд батлагдсан “Шүүх байгуулах тухай” хуульд заасан. 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн Шүүх байгуулах тухай хуулийн дагуу орон нутагт давж заалдах шатны 8 шүүх ажиллаж байсан. 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн “Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-д зааснаар эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны нийт 25 шүүх ажиллахаар өөрчлөлт оруулсан.

Хүснэгт 3. Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

№	Шүүх	Байршил	Харьяалах нутаг дэвсгэр
1	Архангай аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дорноговь аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
9	Дорнод аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дундговь аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Завхан аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
12	Орхон аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Өмнөговь аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
14	Өвөрхангай аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
15	Сүхбаатар аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Сэлэнгэ аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
17	Төв аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Увс аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
19	Ховд аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
20	Хөвсгөл аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

21	Хэнтий аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
22	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

1.3.3. Улсын Дээд Шүүхийн эрүүгийн хэргийн танхим

“Шүүхийн зохион байгуулалтын тухай” 1949 оны хуулиар Улсын Дээд шүүхийн эрх хэмжээг коллегиор ялган тодорхойлсноороо 1943 оныхоос онцлог юм. Коллегиуд харьяаллынхаа хэргийг 1 гишүүн, 2 ардын төлөөлөгчтэй, 2 дугаар шатны журмаар бол хэргийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ гэж хамтран шийдвэрлэх хэлбэрийг тодруулан тогтоосон байдаг.

1960 оны Үндсэн хуулийн 6 дугаар бүлэгт БНМАУ-д шүүн таслах ажлыг БНМАУ-ын Дээд шүүх, аймаг, хотын шүүх, тусгай шүүх, мөн ардын хэсгийн шүүх гүйцэтгэнэ гэж шүүхийн системийг тодорхойлжээ. Энэ үеэс Улсын Дээд шүүхийн зохион байгуулалтын бүтэц нь тус шүүхийн эрх хэмжээ, үйл ажиллагааны төрөл онцлогт нарийн зохилдсон хэмээн үздэг. Шүүхийн зохион байгуулалтын хууль тогтоомжид зааснаар Улсын Дээд шүүх нь Улсын Дээд шүүхийн бүгд хурал, Улсын Дээд шүүхийн тэргүүлэгчид, эрүүгийн хэрэг эрхэлсэн коллеги, иргэний хэрэг эрхэлсэн коллеги, цэргийн коллеги гэсэн зохион байгуулалтын үндсэн бүтэцтэй байлаа. Улсын Дээд шүүхийн гурван коллеги нь 1993 он хүртэл шүүн таслах ажлыг дагнан эрхэлж, шүүхийн хяналтыг хэрэгжүүлж байв.

Ардчилсан хувьсгал ялж 1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийг баталсны дараа 1993, 2002 онд батлагдсан “Шүүхийн тухай хууль”-ийн дагуу Улсын Дээд шүүх нь Ерөнхий шүүгч, Эрүү, Иргэний хэргийн танхимын тэргүүн, 14 шүүгч, нийт 17 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байв.

2012 онд батлагдсан Монгол Улсын “Шүүхийн тухай хууль”-иар “Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөөс доошгүй шүүгчээс бүрдэнэ. Улсын Дээд шүүхийн шүүгч эрүү, иргэн, захиргааны хэргийн дагнасан танхимын аль нэгд харьяалагдах бөгөөд түүнийг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх өөр танхимын шүүн таслах ажиллагаанд оролцуулахыг хориглоно.” гэж Улсын Дээд шүүхийн бүрэлдэхүүнийг хуульчлан тогтоож, улмаар хууль батлагдахаас өмнө уг танхимд ажиллаж байсан бүрэлдэхүүнд өөрчлөлт орж Танхимын тэргүүн болон 7 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн юм.

1.4. Бүтэц орон тоо

2021 онд нийт 30 шүүгчийн сул орон тоонд шүүгчийн хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлт хийсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 13 шүүгчийг шинээр, 1 шүүгчийг дэвшүүлэн, 16 шүүгчийг шилжүүлэн томилуулж, 1 шүүгчийг томилолтоор ажиллуулсан.

2021 онд 6 шүүгч өөрийн бичгээр гаргасан хүсэлтээр, 10 шүүгч өндөр насны тэтгэвэрт гарах, 2 шүүгч нас барсан үндэслэлээр нийт 18 шүүгчийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар албан тушаалаас нь тус тус чөлөөлсөн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайланд дурдсанаар 2022 оны 01 сарын 03-ны өдрийн байдлаар Монгол Улсын бүх шатны 117 шүүхэд нийт 512 шүүгч ажиллаж байгаагаас анхан шатны шүүхэд 389, давж заалдах шатны шүүхэд 101, хяналтын шатны шүүхэд 22 шүүгч тус тус ажиллаж байна.

Хүснэгт 4. Шүүгчдийн тоо

Шүүх		УИХ-ын 2016 оны 42-р тогтоолоор баталсан шүүгч, Ерөнхий шүүгчийн орон тоо		2019 оны эцэс дэх шүүгчийн тоо		2020 оны эцэс дэх шүүгчийн тоо		2021 оны эцэс дэх шүүгчийн тоо				
Хяналт шатны шүүх		25		22		22		22				
Давж заалдах шатны шүүх	Иргэн	24	159	22	110	20	111	18	103			
	Эрүү	24		20		22		21				
	Эрүү, Иргэний	95		56		54		50				
	Захиргаа	16		12		15		14				
Анхан шатны шүүх	Дүүрэг (иргэн)	99	540	82	484	87	388	87	522	389	518	
	Дүүрэг (эрүү)	85		55		66		68				
	Захиргаа	104		73		71		73				
	Сум дунд	Эрүү		93		63		66				65
		Иргэн		120		74		71				72
		Дагнаагүй		39		27		28				28

1.5. Хүндрэлтэй нөхцөл байдал

2016 онд УИХ-ын 42 дугаар тогтоолоор бүх шатны шүүхүүдийн шүүгчдийн орон тоог шинэчлэн тогтоосон байдаг. Ингэхдээ тухайн орон нутгийн хүн амын нягтаршил, шүүгчдийн ажлын ачаалал, шүүхийн үйлчилгээг ард иргэдэд хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх зэрэг асуудлыг харгалзан үзэж орон тооны хязгаарыг баталсан байдаг.

2022 онд Дүүргийн эрүүгийн хэргийн шүүхүүдэд нийт 67.3 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид дунджаар эрүүгийн 115.0 хэрэг ногдож байна. Энэ нь өмнөх онтой харьцуулбал шүүгчийн тоо 65.2 байснаас 2.1 хүнээр өсөж, нэг шүүгчид ногдох хэргийн тоо 97.3 байснаас 115.0 хэрэг болж 17.7 хэргээр өссөн дүнтэй гарсан байна. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарын ачаалал 27.2-32.4 хэргээр дунджаас өндөр байгаа бол Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хэргийн ачаалал 6.7 дахин бага буюу харьцангуй бага байгааг харуулж байна. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчид ногдох хэргийн ачаалал дунджид хамгийн ойр байна.

2. Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт

2.1. Анхан шатны шүүх

2022 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд нийт 20199 хүн, 17 хуулийн этгээдэд холбогдох 16355 эрүүгийн хэрэг хүлээн авснаас 4 хуулийн этгээд, 1100 хүнд холбогдох 624 хэргийг прокурорт буцааж, 165 хүнд холбогдох 117 хэргийг түдгэлзүүлж, 1 хуулийн этгээд 600 хүнд холбогдох 337 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 237 хүнд холбогдох 113 хэргийг хэрэгсэхгүй болгож, 149 хүнд холбогдох 82 хэргийг цагаатгаж, нийт 14202 хэргийг шийдвэрлэж 10 хуулийн этгээд, 16350 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, үүнээс 1583 хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 254 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 11263 хүнд ял шийтгэл оногдуулсан байна. Нийт эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 2022 оны эцэст 1156 хэргийн үлдэгдэлтэй байжээ. Өнгөрсөн онтой харьцуулбал хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 17.7%-иар, ял шийтгүүлэгчдийн тоо мөн 27.8%-ийр тус тус өссөн дүнтэй байна.

Хүснэгт 5. Анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, ял шийтгүүлэгчдийн тоо

№	Шүүх	Хэргийн тоо		Өсөлт, бууралт		Ял шийтгүүлэгчдийн тоо		Өсөлт, бууралт	
		2021 он	2022 он	Тоо	Хувь	2021 он	2022 он	Тоо	Хувь
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	303	335	32	10.6	246	379	133	54.1
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	156	194	38	24.4	154	189	35	22.7
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	331	229	-102	-30.8	230	192	-38	-16.5
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	276	280	4	1.4	249	259	10	4.0
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	135	159	24	17.8	133	143	10	7.5
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	96	91	-5	-5.2	98	99	1	1.0
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	341	418	77	22.6	325	383	58	17.8
8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	178	247	69	38.8	142	227	85	59.9
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	395	385	-10	-2.5	382	427	45	11.8
10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	144	169	25	17.4	107	171	64	59.8
11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	156	202	46	29.5	136	182	46	33.8
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	324	401	77	23.8	341	420	79	23.2
13	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	198	265	67	33.8	169	285	116	68.6

14	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	144	129	-15	-10.4	140	130	-10	-7.1
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	203	259	56	27.6	152	213	61	40.1
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	174	210	36	20.7	132	194	62	47.0
17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	478	507	29	6.1	386	528	142	36.8
18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	185	231	46	24.9	178	226	48	27.0
19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	185	248	63	34.1	153	238	85	55.6
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	330	383	53	16.1	269	356	87	32.3
21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	284	227	-57	-20.1	282	220	-62	-22.0
22	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	93	106	13	14.0	92	105	13	14.1
23	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	85	86	1	1.2	55	69	14	25.5
24	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	140	148	8	5.7	115	159	44	38.3
25	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	89	121	32	36.0	68	112	44	64.7
26	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	122	140	18	14.8	112	124	12	10.7
27	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	69	77	8	11.6	51	77	26	51.0
28	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	49	66	17	34.7	36	70	34	94.4
29	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	60	150	90	150.0	53	184	131	247.2
30	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1460	1835	375	25.7	1482	1900	418	28.2
31	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	940	1187	247	26.3	868	1311	443	51.0

32	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	777	985	208	26.8	683	975	292	42.8
33	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	861	954	93	10.8	904	1083	179	19.8
34	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	728	849	121	16.6	703	814	111	15.8
35	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1272	1558	286	22.5	1360	1578	218	16.0
36	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	99	127	28	28.3	92	126	34	37.0
37	Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	17	17	0	0.0	14	18	4	28.6
38	Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	191	227	36	18.8	171	228	57	33.3
Нийт		12068	14202	2134	17.7	11263	14394	3131	27.8

Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх 2022 онд өмнөх оноос 2.5 дахин их хэргийг шийдвэрлэсэн нь Улсын хэмжээнд шийдвэрлэсэн хэргийн тоо нь өмнөх оноос хамгийн ихээр нэмэгдсэн шүүх болж байна. Харин Өмнөговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Хэнтий аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Баянхонгор аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх гэсэн 3 шүүхийн шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос буурсан дүнтэй байна.

2.2. Шийдвэрлэсэн гэмт хэргийн төрөл

2022 онд улсын хэмжээнд эрүүгийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргээс “Хүнийг алах” гэмт хэрэг 18 хэргээр буюу 9.1%-иар, “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг 2 хэргээр буюу 2.0%-иар, “Хүн худалдаалах” гэмт хэрэг 3 хэргээр буюу 50.0%-иар тус тус буурсан бол “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах” гэмт хэрэг 72 хэргээр буюу 22.0%-иар, “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах” гэмт хэрэг 1091 хэргээр буюу 21.8%-иар, “Хүчиндэх” гэмт хэрэг 17 хэргээр буюу 4.9%-иар, “Хулгайлах” гэмт хэрэг 345 хэргээр буюу 27.5%-иар, “Дээрэмдэх” гэмт хэрэг 6 хэргээр буюу 3.1%-иар, “Залилах” гэмт хэрэг 79 хэргээр буюу 10.7%-иар, “Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрэх” гэмт хэрэг 7 хэргээр буюу 2 дахин, “Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах” гэмт хэрэг 30 хэргээр буюу 20.4%-иар, “Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих” гэмт хэрэг 286 хэргээр буюу 36.3%-иар, бусад төрлийн гэмт хэрэг 24 хэргээр буюу 7.6%-иар өсжээ.

Хүснэгт 6. Хянан шийдвэрлэсэн зарим хэрэг

№	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо				Хорих ял онгодуулах
		Өсөлт, бууралт				Өсөлт, бууралт				
		2021 он	2022 он	Тоо	Хувь	2021 он	2022 он	Тоо	Хувь	
1	Хүнийг алах	197	179	-18	-9.1	205	177	-28	-13.7	0
2	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	327	399	72	22.0	322	402	80	24.8	1
3	Хүний эрүүл мэндэд хөнгөн	5006	6097	1091	21.8	4926	6509	1583	32.1	13

	хохирол учруулах									
4	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	99	97	-2	-2.0	60	84	24	40.0	10
5	Хүчиндэх	346	363	17	4.9	328	333	5	1.5	50
6	Хүн худалдаалах	6	3	-3	-50.0	10	9	-1	-10.0	0
7	Хулгайлах	1253	1598	345	27.5	1129	1529	400	35.4	363
8	Дээрэмдэх	191	197	6	3.1	229	257	28	12.2	35
9	Залилах	736	815	79	10.7	705	851	146	20.7	64
10	Улсын хилээр барааг хууль бусаар хил нэвтрүүлэх	7	14	7	100.0	10	17	7	70.0	0
11	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	147	177	30	20.4	186	241	55	29.6	28
12	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	788	1074	286	36.3	419	679	260	62.1	361
13	Бусад	2965	3189	224	7.6	2734	3306	572	20.9	744
	Нийт	12068	14202	2134	17.7	11263	14394	3131	27.8	1669

2022 онд хянан шийдвэрлэсэн зарим хэргийг ял шийтгүүлэгчдийн байдлаар нь авч үзвэл “Хүнийг алах” гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 13.7%-иар, “Хүн худалдаалах” гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 10.0%-иар тус тус буурсан бол “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах” гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 24.8%-тао, “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах” гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 32.1%-иар, “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 40.0%-иар, “Хулгайлах” гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 35.4%-иар, “Дээрэмдэх” гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 12.2%-иар, “Залилах” гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 20.7%-иар, “Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрэх” гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 70.0%-иар, “Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах” гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 29.6%-иар, “Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих” гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 62.1%-иар, бусад төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 20.9%-иар тус тус өссөн байна.

2.3. Оногдуулсан ял, хариуцлагын төрөл

2022 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс улсын хэмжээнд 8165 хүн, 10 хуулийн этгээдийг торгох ялаар, 1552 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ялаар, 1761 хүнийг зорчих эрхийг хязгаарлах ялаар, 2919 хүнийг хорих ялаар тус тус шийтгэж, 96 хүүхдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг, 23 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг тус тус хэрэглэсэн байна. Хорих ял шийтгүүлсэн хүмүүсээс биечлэн эдлүүлсэн 2806, тэнссэн 1, өсвөр насны хүн 63, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг 24 хүний шийтгэх тогтоолыг хойшлуулжээ. Өнгөрсөн 2021 оноос торгох ялаар ял шийтгүүлсэн хүний тоо 32.3%-иар, нийтэд тустай ажил хийлгэх ялаар ял шийтгүүлсэн хүний тоо 2.2%-иар, хорих ял шийтгүүлсэн хүний тоо 15.9%-иар тус тус өссөн дүнтэй байна.

Хүснэгт 7. Шүүхээс оногдуулсан ял, хариуцлагын төрөл

№	Хэргийн төрөл	Өсөлт, бууралт				Нийт гэм буруутайд тооцогдсоноос эзлэх хувь		Зөрүү /+/, /-/
		2021 он	2022 он	Тоо	Хувь	2021 он	2022 он	
1	Торгох	6179	8175	1996	32.3	47.2	50.0	2.8
2	Хорих	2518	2919	401	15.9	19.2	17.9	-1.4
3	Нийтэд тустай ажил хийлгэх	1518	1552	34	2.2	11.6	9.5	-2.1
4	Зорчих эрхийг хязгаарлах	1049	1761	712	67.9	8.0	10.8	2.8
5	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	63	96	33	52.4	0.5	0.6	0.1
6	Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ	15	23	8	53.3	0.1	0.1	0.0
7	Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх	1560	1583	23	1.5	11.9	9.7	-2.2
9	Эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн	190	254	64	33.7	1.5	1.6	0.1

2022 онд 8165 хүн, 10 хуулийн этгээдэд 11 тэрбум 369 сая 847 мянга 200 төгрөгийн торгох ял, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ хэрэглэж 413 хүн, 35 хуулийн этгээдээс 14 тэрбум 334 сая 385 мянга 024 төгрөгийг тус тус гаргуулан улсын орлого болгосон байна. Мөн шүүхээс 698 хүн, 18 хуулийн этгээдэд эрх хасах нэмэгдэл ял хэрэглэж, 982 хүнд үүрэг хүлээлгэж, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг тус тус хэрэглэсэн байна

2.2.1.Сэжигтнийг баривчлах арга хэмжээ

2022 онд улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр нийт 273 сэжигтнийг баривчлах тухай материал хүлээн авснаас 246 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 27 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ. Баривчлах зөвшөөрөл олгосон нийт хүмүүсийн 2.8%-ийг эмэгтэй хүн, 1.6%-ийг өсвөр насны хүн тус тус эзэлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтнийг баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоог өмнөх онтой харьцуулбал 17 хүнээр буюу 9.6%-иар, баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо 9 хүнээр буюу 6.1%-иар, баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо 26.7%-иар тус тус буурсан байна. Харин баривчлах зөвшөөрөл олгосон өсвөр насны хүний тоо 7 дахин, эмэгтэй хүний тоо 2.1 дахин өсжээ.

Хүснэгт 8. Баривчлагдсан сэжигтний тоо

№	Утга	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	Хувь
1	Баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоо	161	178	17	9.6
2	Баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо	139	148	9	6.1
3	Баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо	22	30	8	26.7

2.2.2.Таслан сэргийлэх арга хэмжээ

2022 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд зааснаар Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс улсын хэмжээнд 3710 хүн, хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар ирүүлснээс 3158 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар, 527 хүнд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар, 25 хүн, хуулийн этгээдэд тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх арга хэмжээг авахуулахаар тус тус ирүүлжээ.

Нийт цагдан хорих зөвшөөрөл олгосон хүмүүсийн 107 буюу 4.1% нь эмэгтэйчүүд, 27 буюу 1.0% нь өсвөр насны хүн байна.

Хүснэгт 9. Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүний тоо

№	Утга	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	Хувь
1	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн хүний тоо	2934	3158	224	7.6
2	Хязгаарлалт тогтох таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн хүний тоо	229	527	298	2.3 дахин
3	Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх	34	25	-9	-26.5
4	Үүнээс: хуулийн этгээд	0	0	0	-

2022 онд улсын хэмжээнд нийт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн 3158 хүний 2592 буюу 82.1%-ийг нь цагдан хорьж, 202 хүн буюу 6.4%-д нь шүүгч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, 67 буюу 2.1%-ийг шүүгч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, 297 буюу 9.4%-ийг шүүгч цагдан хорихоос татгалзаж шийдвэрлэсэн байна.

Цагдан хорих зөвшөөрлийн 25.2%-ийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан”, 17.9%-ийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлсан”, 0.3%-ийг “Шүүгчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 1 хүнийг “Мөрдөгчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.9%-ийг “Хохирогчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 1.6%-ийг “Өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 1.2%-ийг “Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.3%-ийг “Гэмт хэрэг хамтран үйлдсэн хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 23.7%-ийг “Гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 12.2%-ийг “Урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн”, 0.4%-ийг “Шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 2.7%-ийг “Прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 13.6%-ийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан” үндэслэлээр тус тус олгожээ. Доорх хүснэгтэд тоон мэдээллийг үзүүлсэн болно.

График 2. Сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар шүүгчийн гаргасан захирамжийн төрөл



Улсын хэмжээнд 2022 онд шүүхээс сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар нийт 6729 шүүгчийн захирамж гарсан байна. Үүнээс яллагдагчаар цагдан хорих тухай 1407 захирамж, цагдан хорих хугацааг сунгах тухай 2658 захирамж, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай 230 захирамж, яллагдагчийг цагдан хорихоос татгалзах тухай 383 захирамж, цагдан хорих хугацааг сунгахаас татгалзах тухай 331 захирамж гарсан нь нийт захирамжийн 74.3%-ийг эзэлж байна.

Хүснэгт 10. Сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар гаргасан шүүгчийн захирамжийн тоо

№	Сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар гаргасан нийт шүүгчийн захирамж	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	Хувь
1	Сэжигтнийг баривчлах тухай	120	241	121	100.8
2	Сэжигтнийг баривчлахаас татгалзах тухай	19	21	2	10.5
3	Сэжигтнийг суллах тухай	15	64	49	326.7
4	Яллагдагчаар цагдан хорих тухай	1426	1407	-19	-1.3
5	Яллагдагчийг цагдан хорихоос татгалзах тухай	213	383	170	79.8
6	Шилжүүлэн цагдан хорих тухай	123	137	14	11.4
7	Шилжүүлэн цагдан хорихоос татгалзах тухай	16	10	-6	-37.5
8	Цагдан хорих хугацааг сунгах тухай	3460	2658	-802	-23.2
9	Цагдан хорих хугацааг сунгахаас татгалзах тухай	189	331	142	75.1
10	Шүүхэд хянагдаж буй яллагдагчийн хорьж мөрдөх хугацааг сунгах тухай	22	106	84	4.8 дахин
11	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох тухай	96	56	-40	-41.7
12	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай	163	230	67	41.1
13	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжид гарсан гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай	195	452	257	2.8 дахин
14	Тогтоосон газраас гарч явах тухай	8	8	0	0.0
15	Тогтоосон нутаг дэвсгэрээс гарч явах тухай	17	14	-3	-17.6
16	Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах тухай	158	445	287	2.8 дахин
17	Тодорхой газар очихыг хязгаарлах тухай	20	1	-19	-95.0
18	Тодорхой хүнтэй уулзахыг хориглох тухай	26	23	-3	-11.5
19	Тогтоосон замаар зорчихыг даалгах тухай	4	0	-4	-100.0
20	Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай	13	57	44	4.4 дахин
21	Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох тухай	11	67	56	6.1 дахин
22	Төрийн албанд ажиллахыг түдгэлзүүлэх тухай	5	9	4	80.0
23	Тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг түдгэлзүүлэх тухай	11	9	-2	-18.2
24	Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх тухай	0	0	0	-
25	Тусгай зөвшөөрлөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх тухай	7	4	-3	-42.9
26	Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэхийг сэргээх тухай	5	2	-3	-60.0

Нийт	6342	9103	6729	387
------	------	------	------	-----

Шүүх 2022 онд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн хүсэлтийг өнгөрсөн оны мөн үеэс 2.6 дахин их хүлээн авч хянан шийдвэрлэсэн байна. Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах тухай захирамж өнгөрсөн оны мөн үеэс 2.8 дахин их шийдвэрлэсэн бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжид гарсан гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай захирамж мөн 2.8 дахин их шийдвэрлэсэн байна.

2.3.3.Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж, ялаас чөлөөлсөн байдал

Шүүх 2022 онд Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14, ЭХХШТХ-ийн 37.5, 37.6, 37.7, 37.8, 37.9, 37.10-т тус тус заасны дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн нийт 1760 хүний материалыг хянан хэлэлцсэнээс 16 ялтныг өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлж, 834 ялтныг хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж, хяналт тогтоон, 112 ялтны хорих ял эдлэх дэглэмийг бууруулсан бол 13 ялтны хорих ялын дэглэмийг хүндрүүлж шийдвэрлэсэн байна.

Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Өршөөл үзүүлэх тухай хууль 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж 07 дугаар сарын 06-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд энэ хуулийн үйлчлэлийн хүрээнд 2021 онд хүлээн авч хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа өсөлттэй гарч байсан бол 2022 онд эргээд буурсан дүнтэй гарсан байна.


Хүснэгт 11. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө сулласан, ялаас чөлөөлсөн тухай мэдээллийг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

№	Утга	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	Хувь
1	ЭХ-ийн 6.12, 6.13, 6.14, ЭХХШТХ-ийн 37.5, 37.6, 37.7, 37.8, 37.9, 37.10-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн хүний тоо	6496	1760	-4736	-72.9
2	Өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлсөн	21	16	-5	-23.8
3	Хорих ял эдлэхээс хугацааны өмнө сулласан	1115	834	-281	-25.2
4	Үндсэн хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар сольсон	544	11	-533	-98.0
5	Үндсэн ялыг өршөөсөн	2189	108	-2081	-95.1
6	Нэмэгдэл ялыг өршөөсөн	437	4	-433	-99.1
7	Албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн	64	0	-64	-
8	Торгууль төлөх хугацааг хойшлуулсан	0	0	0	-
9.	Торгох ялаас чөлөөлсөн	560	3	-557	-99.5
10	Торгох ялыг хэсэгчлэн төлөх	42	0	-42	-
11	Торгох ялыг хорих ялаар сольсон	412	99	-313	-76.0
12	Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоосон	0	27	27	-
13	Бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн этгээдийг суллах	16	0	-16	-
	Суллахаас татгалзсан хүн	0	0	0	-
14	Ял эдэлсэн хугацаанд оруулан тооцсон	5	1	-4	-80.0
15	Хорих байгууллагад ял эдлэх дэглэмийг сольсон	153	125	-28	-18.3
16	Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялаар сольсон	267	162	-105	-39.3

17	Албадлагын арга хэмжээнээс чөлөөлсөн	24	0	-24	-
18	Ялаас чөлөөлсөн	308	11	-297	-96.4
19	Насанд хүрэгчдийн хорих ангид шилжүүлсэн	7	11	4	57.1
20	Торгох ялыг хорих ялаар сольсон, тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэсэн	31	8	-23	-74.2
21	Зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольсон	145	307	162	2.1 дахин

Улсын хэмжээнд 2022 онд нийт 112 ялтны хорих ял эдлэх дэглэмийг бууруулж, хаалттайгаас нээлттэй дэглэмд шилжүүлсэн нь өнгөрсөн онтой харьцуулбал 32 хүн буюу 22.2%-иар буурсан бол хорих ял эдлэх дэглэмийг хүндрүүлж, нээлттэйгээс хаалттай дэглэмд шилжүүлсэн хүний тоо 4 хүнээр буюу 44.4%-иар өссөн байна.

График 3. Хорих ялын дэглэмийн шилжсэн байдал




2.3.4. Ял шийтгүүлэгчид

2022 онд нийт ял шийтгүүлсэн 11263 хүнийг зарим бүлгээр авч үзвэл 1631 буюу 11.3% нь эмэгтэй, 209 буюу 1.5% нь өсвөр насны хүн, 3627 буюу 25.2% нь урьд ял шийтгүүлсэн, 713 буюу 5.0% нь бүлэглэж үйлдсэн, 3894 буюу 27.1% нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна.

Нийт ял шийтгүүлсэн 14934 хүнээс Монгол Улсын иргэн 14359 буюу 99.8%-ийг, гадаадын иргэн 34 буюу 0.2%-ийг эзэлж байна. Ял шийтгүүлсэн гадаад улсын иргэдийн тоо 2021 оноос 5 хүнээр буюу 17.2%-иар өссөн байна. Мөн тус онд 10 хуулийн этгээдийг гэм буруутайд тооцож, ял оногдуулж шийдвэрлэсэн байна.


Ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 585 буюу 16.3%-иар, бүлэглэж үйлдсэн хүний тоо 451 буюу 38.2%-иар, согтуугаар үйлдсэн хүний тоо 1037 буюу 36.3%-иар, өсвөр насны хүний тоо 84 буюу 67.2%-иар тус тус өссөн дүнтэй гарсан байна.

График 4. Ял шийтгүүлэгчдийн насны бүлэг



Ял шийтгүүлэгчдийг насны бүлгээр авч үзэж өмнөх онтой харьцуулахад 14-15 насны ял шийтгүүлэгчдийн тоо 11 хүнээр буюу 73.3%-иар, 16-17 настай ял шийтгүүлэгчдийн тоо 73 хүнээр буюу 66.4%-иар, 18-21 настай ял шийтгүүлэгчдийн тоо 363 хүнээр буюу 39.9%-иар, 22-29 настай ял шийтгүүлэгчдийн тоо 815 хүнээр буюу 26.9%-иар, 30-34 настай ял шийтгүүлэгчдийн тоо 648 хүнээр буюу 22.2%-иар, 35-аас дээш настай ял шийтгүүлэгчдийн тоо 953 хүнээр буюу 28.5%-иар тус тус өссөн байна. Мөн ял шийтгүүлэгчдийн дотор 35-аас дээш насны ял шийтгүүлэгчид 5501 байгаа нь нийт ял шийтгүүлэгчдийн 38.2%-ийг эзэлж байна.


График 5. Ял шийтгүүлэгчдийн боловсролын байдал



Ял шийтгүүлэгчдийн боловсролын байдлын хувьд, 2022 онд нийт ял шийтгүүлсэн хүмүүсээс 2900 буюу 20.1% нь дээд, 102 буюу 0.7% нь техникийн болон мэргэжлийн, 801 буюу 5.5% нь тусгай мэргэжлийн дунд, 6246 буюу 4.3% нь бүрэн дунд, 2031 буюу 14.1% нь суурь, 1285 буюу 8.9% нь бага боловсролтой, 1029 буюу 7.1% боловсролгүй иргэд тус тус эзэлж байна.

Энэхүү тоон мэдээллийг 2021 онтой харьцуулж үзвэл дээд боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 22.1%-иар, бүрэн дунд боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 26.5%-иар, суурь боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 39.8%-иар, бага боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 41.7%-иар, боловсролгүй ял шийтгүүлэгчдийн тоо 56.6%-иар тус тус өссөн бол техникийн болон мэргэжлийн боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 21.5%-иар, тусгай мэргэжлийн дунд боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 0.4%-иар тус тус буурсан байна.

График 6. Ял шийтгүүлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал



Ял шийтгүүлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлын хувьд, 2022 онд нийт ял шийтгүүлсэн иргэдийн 0.3% нь улс төрийн албан тушаалтан, 0.7% нь төрийн захиргааны албан хаагч, 1.2% нь төрийн тусгай албан хаагч, 2.9% нь төрийн үйлчилгээний албан хаагч, 0.6% нь төрийн бус байгууллагын ажилтан, 9.0% нь аж ахуйн нэгжийн ажилтан, 3.5% нь оюутан, 1.1% нь сурагч, 10.5% нь малчин, 41.5% нь ажилгүй, 0.4% нь ялтан, 28.4% нь бусад иргэд байна.

2.3.Хэргийн үлдэгдэл

2022 оны эцэст эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд нийт 1075 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь өнгөрсөн оноос 81 хэргээр буюу 7%-иар буурсан байна.

Үлдэгдэл хэргийг дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр авч үзвэл Багахангай дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2 хэргийн үлдэгдэлтэй байгаа бол сум дундын шүүхийн хувьд Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх 3 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь хамгийн бага байна.

Харин Хэнтий аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 36, Төв аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 49 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдээс хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдээс Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хамгийн их буюу 166 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 12. Анхан шатны шүүхийн хэргийн үлдэгдэл

№	Үзүүлэлт	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	Хувь
1	Тайлангийн эцсийн үлдэгдэл	1156	1075	-81	-7.0
2	Хуулийн хугацаа хэтэрсэн	5	0	-	-

2.4. Давж заалдах шатны шүүх

2022 онд Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд нийт 2473 хэрэг хүлээн авч, 2312 хэргийг хянан шийдвэрлэж, 110 хэргийн үлдэгдэлтэй, 7 хэрэгт шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах прокурорын дүгнэлтийг хүлээн авч, 44 хэрэгт давж заалдах шатны шүүхээр хэлэлцүүлэхгүй тухай шийдвэр гаргасан байна.

Давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо өмнөх оноос 207 хэргээр буюу 9.8%-иар өссөн бол үлдэгдэл хэргийн тоо 28 хэргээр буюу 20.3%-иар тус тус буурчээ.

Хүснэгт 13. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг

№	Утга	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Хянан шийдвэрлэсэн бүх хэрэг	2105	2312	207	9.8
2	Тогтоолыг хэвээр үлдээсэн	908	1242	334	36.8
3	Тогтоолд өөрчлөлт оруулсан бүгд	530	621	91	17.2
4	Тогтоолыг хүчингүй болгосон бүгд	667	449	-218	-32.7
5	Давж заалдах шатны шүүхээр хэлэлцүүлэхгүй тухай шийдвэр гаргасан	70	44	-26	-37.1
6	Үлдэгдэл хэрэг	138	110	-28	-20.3
Тогтоолд өөрчлөлт оруулсан					
7	Шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй /Ял гэмт хэргийн хүнд, хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй/	106	165	59	55.7
8	Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн	154	148	-6	-3.9
9	ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн	18	40	22	122.2
10	Ялыг хөнгөрүүлсэн /зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр/	252	268	16	6.3
11	Ялыг хүндрүүлсэн /зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр/	-	-	-	-
Тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн					
12	Тогтоолыг хүчингүй болгож, хэргийг шүүхээр хэлэлцүүлэхээр буцаасан	634	422	-212	-33.4
13	Тогтоолыг хүчингүй болгож хэргийг хэрэгсэхгүй болгосон	33	27	-6	-18.2
Тогтоолыг хүчингүй болгосон үндэслэл					
14	Шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй	362	247	-115	-31.8
15	Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн	172	116	-56	-32.6
16	ЭБШ, ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн	133	86	-47	-35.3

2022 онд улсын хэмжээнд эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд нийт 2312 хэрэг хянан шийдвэрлэснээс 1242 хэрэгт буюу 53.7%-д анхан шатны шүүхийн тогтоолыг

хэвээр үлдээж, 621 хэрэгт буюу 26.9%-д нь тогтоолд өөрчлөлт оруулсан бол 449 хэрэгт буюу 19.4%-д нь тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Үүнээс анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээсэн магадлалын тоо 334 хэргээр буюу 36.8%-иар, өөрчлөлт оруулсан магадлалын тоо 91 хэргээр буюу 17.2%-иар өссөн бол хүчингүй болгосон магадлалын тоо 218 хэргээр буюу 32.7%-иар буурсан байна.

Мөн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн тогтоолын 26.6%-ийг “Шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй”, 23.8%-ийг “Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн”, 6.4%-ийг “ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн”, 43.2%-ийг “Ялыг хөнгөрүүлсэн (зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр)” гэсэн үндэслэлээр тус тус өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүхээс хүчингүй болгож шийдвэрлэсэн хэргийн тухайд, анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн нийт 449 магадлалаас 247 буюу 55.0%-д нь “Шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй”, 116 буюу 25.8%-д нь “Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн”, 86 буюу 19.2%-д нь “ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн” үндэслэлээр тус тус хүчингүй болгож шийдвэрлэжээ.

2022 онд давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 46.3%-ийг нь анхан шатны шүүхийн тогтоолд өөрчлөлт оруулж, эсхүл хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Тус оны анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн хэргийг 2021 онд хянан шийдвэрлэсэн хэрэгт эзлэх хувиар авч үзвэл 10.6%-иар, өөрчлөлт оруулсан тогтоолын эзлэх хувь 1.7%-иар тус тус өссөн бол хүчингүй болгож шийдвэрлэсэн хэрэг 12.3%-иар буурчээ.

Түүнчлэн, давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн 145 буюу 6.3%-ийг “Хүнийг алах” гэмт хэрэг, 266 буюу 11.5%-ийг “Хүчиндэх” гэмт хэрэг, 243 буюу 10.5%-ийг “Хулгайлах” гэмт хэрэг, 237 буюу 10.3%-ийг “Залилах” гэмт хэрэг, 194 буюу 8.4%-ийг “Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын ашиглалтын журам зөрчих” гэмт хэрэг, 265 буюу 11.5%-ийг “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах” гэмт хэрэг тус тус эзэлж байна.

2.5.Хяналтын шатны шүүх

2022 онд Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим нийт 868 хэрэг хүлээн авч, 188 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, 670 хэргийг хянан буцааж, 10 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 188 хэргээс 129 хэргийг гомдлын дагуу, 35 хэргийг прокурорын эсэргүүцлээр, 24 хэргийг прокурорын дүгнэлтээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 14. Хяналтын шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны дүн, харьцуулсан байдал

№	Утга	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Хүлээн авсан бүгд	948	868	-80	-8.4
2	Хуралдаанаар хянаж шийдвэрлэсэн бүгд	322	188	-134	-41.6
3	Тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн	137	42	-95	-69.3
4	Тогтоол магадлалд өөрчлөлт оруулсан бүгд	87	72	-15	-17.2
5	Тогтоол, магадлалыг хүчингүй болгосон бүгд	98	74	-24	-24.5
Өөрчлөлт оруулсан үндэслэл					

6	Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн	62	51	-11	-17.7
7	ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн	3	1	-2	-66.7
8	Ялыг хөнгөрүүлсэн /зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр/	22	20	-2	-9.1
9	Ялыг хүндрүүлсэн /зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр/	0	0	0	0
Хүчингүй болгосон үндэслэл					
10	Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн	70	68	-2	-2.9
11	ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн	28	6	-22	-78.6

2022 онд хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн нийт 188 хэргээс 42 хэрэгт буюу 22.3%-д нь тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, 72 хэрэгт буюу 38.3%-д нь өөрчлөлт оруулж, 74 хэрэгт буюу 39.4%-д нь тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэжээ. Үүнийг 2021 онтой харьцуулан авч үзвэл, анхан болон давж заалдах шатны шүүхээс гаргасан тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн хэргийн тоо 95 хэргээр буюу 69.3%-иар, тогтоол магадлалд өөрчлөлт оруулсан хэргийн тоо 15 хэргээр буюу 17.2%-иар, тогтоол, магадлалыг хүчингүй болгосон хэргийн тоо 24 хэргээр буюу 24.5%-иар тус тус буурсан байна.

Шүүхийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан үндэслэлийг авч үзвэл 51 хэрэгт буюу 70.8%-д нь “Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн”, 1 хэрэгт буюу 1.4%-д нь “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтойгоор зөрчсөн”, 20 хэрэгт буюу 27.8%-д нь зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж шийдвэрлэжээ.

2022 онд хяналтын шатны шүүх нийт 74 тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэснээс анхан болон давж заалдах шатны шүүх “Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн” гэсэн үндэслэл 68 хэрэг буюу 91.9%-ийг, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтойгоор зөрчсөн” гэсэн үндэслэл 6 хэрэг буюу 8.1%-ийг тус тус эзэлж байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны журмаар шийдвэрлэсэн байдлын тухайд, эрүүгийн хэргийн тогтоол, магадлалын 77.6%-ийг өөрчилж болон хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. 2021 онд хянан шийдвэрлэсэн хэрэгт эзлэх хувиараа тогтоол магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн хэрэг 20.2%-иар өссөн бол тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан хэрэг 11.3%-иар, тогтоол, магадлалыг хүчингүй болгосон хэрэг 8.9%-иар тус тус буурчээ.

3.Зөрчлийн шийдвэрлэлт

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсгүүдэд эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхээс зөрчлийг хянах шүүхийн харьяаллыг зааж өгсөн. Энэ харьяаллын дагуу 2021 онд эрүүгийн хэргийн шүүх дээрх хуулийн 1.8 дугаар зүйлийн 1.8-7 дахь хэсэгт заасан зөрчлийг харьяаллын дагуу хүлээн авч, мөн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1.8 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.8, 6.9, 6.13, 6.26 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт (цаашид ЭБАТ гэх) гаргасан оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлт (эсэргүүцэл)-ийг тус тус хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан бол иргэн болон захиргааны хэргийн шүүхүүдээс Зөрчлийн тухай хуулийн 15.3, 15.4, 15.5, 15.7 дугаар зүйлд заасан зөрчлүүдийг шийдвэрлэсэн байна.

3.1. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг

2022 онд эрүүгийн хэрийг анхан шатны шүүхүүд нийт зөрчлийн 27872 хэргийг шийдвэрлэсэн байна. Үүнээс эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан 3756 шийдвэрийг хянаж, харьяаллын дагуу 24116 хэргийг хянан шийдвэрлэжээ.

2022 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд эрх бүхий албан тушаалтны шийдвэрт хамаарах 3756 зөрчлийн хэргийг хянаснаас 201 хэрэг буюу 6.4%-ийг хэвээр үлдээж, 2291 хэрэг буюу 61.0%-ийг өөрчлөлт оруулж, 1263 хэрэг буюу 33.6%-ийг хүчингүй болгож, 1 хэргийг шийтгэлээс чөлөөлж шийдвэрлэжээ. ЭБАТ-ны шийдвэрийг хянасан хэргийг өмнөх онтой харьцуулахад хянасан хэргийн тоо 4.5 дахин өссөн нь 2022 онд Улсын ерөнхий прокурорын газраас орон нутгийн прокурорын газруудад хүргүүлсэн чиглэлийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн гэж үзэхээр байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар 2022 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 24610 хүн, 43 хуулийн этгээдэд холбогдох 24162 хэргийг хүлээн авч, 24116 хэргийг хянан шийдвэрлэж, 2022 оны эцэст 46 хэргийн үлдэгдэлтэй байна.

2022 онд анхан шатны шүүхээс харьяаллын дагуу хүлээн авсан хэрэгт холбогдсон нийт 24497 байгаагаас 24454 нь хүн, 43 нь хуулийн этгээд байна. Шийтгэл оногдуулах саналтай ирүүлсэн 148 хүнд холбогдох саналыг хэрэгсэхгүй болгож, шийтгэлээс 83 хүнийг чөлөөлж, 24252 хүн, 43 хуулийн этгээдэд шийтгэл оногдуулжээ.

Хүснэгт 15. Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн мэдээлэл

№	Утга	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
Харьяаллын дагуу шийдвэрлэсэн					
1	Хүлээн авсан хэрэг бүгд	21162	24162	3000	14.2
2	Шийдвэрлэсэн хэрэг	21122	24116	2994	14.2
3	Зөрчлийн хэрэгт холбогдсон бүгд	22228	24610	2382	10.7
4	Шийтгэл оногдуулсан бүгд	21820	24370	2550	11.7
5	Хэрэгсэхгүй болгосон	243	154	-89	-36.6
6	Шийтгэлээс чөлөөлсөн	165	83	-82	-49.7
7	Торгуулсан бүгд	4863	4194	-669	-13.8
	Торгуулсан хүн	4863	4163	-700	-14.4
8	Торгуулсан эмэгтэй	1092	1045	-47	-4.3
9	Нийт торгуулийн хэмжээ /мян.төг/	2.231.805.600	838238000	-1393567600	-62.4
10	Баривчилсан бүгд	16865	20164	3299	19.6
11	Баривчлагдсан эмэгтэй	755	880	125	16.6
12	Эрх хассан	0	114	114	-
13	Үлдэгдэл хэрэг	40	45	5	12.5
ЭБАТ-ны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хянасан					
1	Хэвээр үлдээсэн	102	201	99	2.0 дахин
2	Өөрчлөлт оруулсан	93	2291	2198	24.6 дахин
3	Хүчингүй болсон	598	1263	665	2.1 дахин
4	Шийтгэлээс чөлөөлсөн	31	1	-30	-96.8
5	Бүгд	824	3756	2932	4.6 дахин

2021 онтой харьцуулахад нийт хянан шийдвэрлэсэн хэрэг 12.2%-иар, шийтгэл ногдуулсан хүний тоо 11.7%-иар, баривчилсан бүгд хүний тоо 19.6%-иар тус тус өссөн бол торгуулсан тоо 13.8%-иар, торгуулсан хүний тоо 14.4%-иар тус тус буурсан байна. 2022 онд харьяаллын дагуу хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн өсөлт өмнөх онтой харьцуулахад харьцангуй бага, оногдуулсан шийтгэлийн хувьд торгох зөрчил буурч, баривчлах зөрчил өсжээ. Мөн ЭБАТ-ны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хянасан 3756 хэрэг байгаагаас хэвээр үлдээсэн 5.4%, өөрчлөлт оруулсан 61.0%, шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгосон 33.6%, шийтгэлээс чөлөөлсөн 1 хэрэг тус тус байна.

Шийдвэрлэсэн зөрчлийн хэргийг нутаг дэвсгэрийн хэмжээнд авч үзвэл 2022 онд улсын хэмжээнд шийдвэрлэсэн 27872 хэргийн 12679 буюу 45.5%-ийг нийслэлд, 15198 хэрэг буюу 54.5%-ийг орон нутгийн хэмжээнд тус тус хянан шийдвэрлэсэн байна. Нийслэлд буюу 9 дүүргийн хэмжээнд хянан шийдвэрлэсэн 12674 хэрэг байгаагаас харьяаллын дагуу шийдвэрлэсэн 11130 хэрэг, ЭБАТ-ны шийдвэрийг хянасан 1544 хэрэг тус тус байгаа бол орон нутгийн хэмжээнд хянан шийдвэрлэсэн 15198 хэргээс харьяаллын дагуу шийдвэрлэсэн 12986 хэрэг, ЭБАТ-ны шийдвэрийг хянасан 2212 хэрэг тус тус байна.

Хүснэгт 16. Шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн мэдээлэл

№	Шүүх	2022 он			Харьяаллын дагуу шийдвэрлэсэн	ЭБАТ-ны Шийдвэрийг хянасан	Нийт	Өсөлт, бууралт (тоогоор)		
		Харьяаллын дагуу шийдвэрлэсэн	ЭБАТ-ны шийдвэрийг хянасан	Нийт				Харьяаллын дагуу шийдвэрлэсэн	ЭБАТ-ны Шийдвэрийг хянасан	Нийт
1	Баянзүрх	2753	166	2919	3323	138	3461	570	-28	542
2	Сүхбаатар	1027	37	1064	1152	104	1256	125	67	192
3	Чингэлтэй	784	94	878	1308	428	1736	524	334	858
4	Баянгол	1336	43	1379	1188	172	1360	-148	129	-19
5	Хан-Уул	1381	63	1444	1343	397	1740	-38	334	296
6	Сонгинохайрхан	1889	59	1948	2296	217	2513	407	158	565
7	Багануур	247	4	251	350	15	365	103	11	114
8	Багахангай	53	3	56	52	27	79	-1	24	23
9	Налайх	221	11	232	123	46	169	-98	35	-63
Улаанбаатар хот		9686	480	10166	11135	1544	12679	1449	1064	2513
10	Архангай	507	6	513	617	94	711	110	88	198
11	Баян-Өлгий	416	20	436	568	13	581	152	-7	145
12	Баянхонгор	701	47	748	800	170	970	99	123	222
13	Булган	535	22	557	543	71	614	8	49	57
14	Говь-Алтай	317	11	328	521	86	607	204	75	279
15	Говьсүмбэр	253	3	256	261	11	272	8	8	16
16	Дархан-Уул	416	10	426	633	75	708	217	65	282
17	Дорноговь	256	15	271	438	55	493	182	40	222
18	Дорнод	429	7	436	534	54	588	105	47	152
19	Дундговь	197	-	197	237	25	262	40	-	65
20	Завхан	251	3	254	283	49	332	32	46	78
21	Орхон	877	5	882	876	77	953	-1	72	71
22	Өвөрхангай	950	5	955	939	201	1140	-11	196	185
23	Өмнөговь	280	8	288	271	25	296	-9	17	8
24	Сүхбаатар	322	39	361	347	180	527	25	141	166
25	Сэлэнгэ	214	14	228	411	304	715	197	290	487
26	Төв	732	24	756	679	165	844	-53	141	88
27	Увс	554	23	577	541	64	605	-13	41	28
28	Ховд	329	6	335	395	39	434	66	33	99
29	Хөвсгөл	755	16	771	758	36	794	3	20	23
30	Хэнтий	434	8	442	460	85	545	26	77	103
31	Замын-Үүд	115	4	119	203	67	270	88	63	151
32	Тосонцэнгэл	230	5	235	238	50	288	8	45	53
33	Хархорин	420	5	425	161	115	276	-259	110	-149

34	Ханбогд	211	24	235	422	43	465	211	19	230
35	Мандал	263	-	263	295	11	306	32	-	43
36	Сайхан	129	2	131	136	7	143	7	5	12
37	Ховдын Булган	205	5	210	157	31	188	-48	26	-22
38	Бор-Өндөр	138	7	145	262	9	271	124	2	126
Орон нутаг		11436	344	11780	12986	2212	15198	1550	1868	3418
Улсын хэмжээнд		21122	824	21946	24116	3756	27872	2994	2932	5926

2022 онд хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн дүнгээр дүүргийн шүүхийн дундаж нь аймаг дахь сум дундын шүүхээс 2.3 дахин, сум дахь сум дундын шүүхээс 5.5 дахин их байна. Дүүргийн хэмжээнд гол төлөв 1 шүүгч зөрчлийн хэргийг дагнан шийдвэрлэж байсан бол өнгөрсөн онд шүүх дотроо зохион байгуулалт хийж ихэнх дүүргийн шүүхүүд шүүгч бүр дээр тойрч зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэдэг болсон байна. Сум болон сум дундын шүүхийн шүүгчдийн хувьд зөрчлийн, эрүүгийн, иргэний хэргийг шийдвэрлэдэг.

Хянан шийдвэрлэсэн хэргийн дүнгээр дүүргийн шүүхийн хэмжээнд Сүхбаатар, Баянгол, Хан-Уул дүүрэг, аймаг дахь сум дундын шүүхийн хэмжээнд Баянхонгор, Орхон, Өвөрхангай, сум дахь сум дундын шүүхийн хэмжээнд Ханбогд сум дахь сум дундын шүүх нь дээрх дунджааас алслагдсан утгатай буюу дунджаас их хэмжээгээр өндөр дүнтэй байгаа нь анхаарал татаж байна. Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн хувьд тогтолцоо дотроо болон улсын дунджаас дахин их байгаа нь эдгээр шүүхүүдийн хувьд ачаалал маш өндөр байгааг харуулж байна.

3.2. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг

2022 онд Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд 707 зөрчлийн хэрэг хүлээн авч, 53 хэргийг хүлээн авахаас татгалзан буцааж, 636 хэргийг хянан шийдвэрлэж, 23 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 17. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг

№	Зөрчлийн хэргийн төрөл	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	Хувь
1	Гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн	251	331	80	31.9
2	Шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон	35	67	32	91.4
3	Шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаасан	73	69	-4	-5.5
4	Албадлагын арга хэмжээг хөнгөрүүлж эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан	109	169	60	55.0
Нийт шийдвэрлэсэн хэрэг		468	636	168	35.9

Дээрх хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргээс 331 хэрэг буюу 52.0%-д нь гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, 67 хэрэг буюу 10.5%-д нь шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгож, 69 хэрэг буюу 10.8%-д нь шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцааж, 169 буюу 26.6%-д нь албадлагын арга хэмжээг хөнгөрүүлж эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 18. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоо

№	Шүүх	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Архангай аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	14	19	5	35.7
2	Баян-Өлгий аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	18	18	0	0.0
3	Баянхонгор аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	16	23	7	43.8
4	Булган аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	14	17	3	21.4
5	Говь-Алтай аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	14	28	14	2 дахин
6	Говьсүмбэр аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	2	0	-2	-100.0
7	Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	16	9	-7	-43.8
8	Дорноговь аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	20	20	0	0.0
9	Дорнод аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	2	3	1	50.0
10	Дундговь аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	11	2	-9	-81.8
11	Завхан аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	19	10	-9	-47.4
12	Орхон аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	23	31	8	34.8
13	Өмнөговь аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	5	4	-1	-20.0
14	Өвөрхангай аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	5	19	14	3.8 дахин
15	Сүхбаатар аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	10	7	-3	-30.0
16	Сэлэнгэ аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	35	30	-5	-14.3
17	Төв аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	9	8	-1	-11.1
18	Увс аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	19	20	1	5.3
19	Ховд аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	29	62	33	2.1 дахин
20	Хөвсгөл аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	19	25	6	31.6
21	Хэнтий аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	21	21	0	0.0
22	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	147	260	113	76.9

Давж заалдах шатны зарим шүүх 2022 онд зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн дүн өмнөх онтой адил шүүхүүд байна. Харин Өвөрхангай, Ховд аймаг дахь давж заалдах шатны шүүхийн хувьд хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн дүн их хэмжээгээр өссөн байна.

Орон нутгийн хэмжээнд дунджаар 18.8 зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн бол Нийслэл дэх эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс 260 хэрэг хянан шийдвэрлэсэн нь орон нутгийн дунджаас 13.8 дахин их байна.

4.Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил

Шүүхийн ерөнхий зөвлөл гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажлын хүрээнд хэд хэдэн чухал үйл ажиллагааг 2022 онд бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулжээ.

Монголын хуульчдын холбоо, Шүүхийн ерөнхий зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Хуульчийн про боно өдөрлөг”-ийг 2018 оноос хойш жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.

2022 оны хувьд “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь Та бидний үүрэг” сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Энэ удаагийн хуульчийн про боно өдөрлөг улс орон даяар нэгэн зэрэг зохион байгуулсан бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл, анхан болон давж заалдах шатны 41 шүүхийн тамгын газар, Шүүхийн тусгай архив дэмжин оролцож, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд дуу хоолойгоо хүргэсэн юм.

Тус ажлын хүрээнд Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газраас “Өсвөр насны хүүхдүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд гэмт хэрэгт холбогдохгүй байх, гэмт хэргээс өөрийгөө хамгаалах”, “Хувь хүний хөгжил, хүний эрхийн мэдрэмж”, Монгол Улсын шүүхийн тогтолцооны талаар ойлголт өгөх” уулзалт, ярилцлагыг 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 93 дугаар сургуулийн 120, Сонгинохайрхан дүүргийн “Өнөр цогцолбор” сургуулийн 260 ахлах ангийн сурагчдын дунд амжилттай зохион байгуулсан байна.

2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр тус өдөрлөгийн нээлтийн ёслол Сүхбаатарын талбайд болсон бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Э.Зоригтбаатар, Шүүхийн тусгай архивын дарга Ш.Отгонцэцэг нар оролцжээ.

“Про боно” өдөрлөгт Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн тусгай архив, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх оролцож, иргэдэд шүүхийн үйлчилгээтэй холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна.

Энэ үеэр Шүүхийн тусгай архив иргэдэд архивын лавлагаа, тодорхойлолт үнэ төлбөргүй гаргаж өгч үйлчиллээ. Түүнчлэн шүүхийн үйлчилгээ, шүүхэд мэдүүлэх эрх, шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сурталчилж, иргэдэд ном, гарын авлага тарааж, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч ажиллажээ.

---oOo---

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ – CORRECTION

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ХОРИХ ЯЛЫН ГҮЙЦЭТГЭЛ
3. ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛЫН ГҮЙЦЭТГЭЛ
4. БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ
5. ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ





ЯЛ ЭДЭЛСЭН
ХОРИГДЛЫН ТОО

4157 **+35.6%**

ЭРЭГТЭЙ **3903** **+38.7%**
ЭМЭГТЭЙ **254** **+52.1%**

ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДИЙН ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ



4129



20



1



БАРИВЧЛАГДСАН
ЭТГЭЭД **+82.8%**

11101

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛЫН ГҮЙЦЭТГЭЛ



ЗОРЧИХ ЭРХИЙГ
ХЯЗГААРЛАХ ЯЛ

1702



ЭРХ
ХАСАХ ЯЛ

320



НИЙТЭД ТУСТАЙ
АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ

1134



ТОРГОХ

7397

Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн

649

үлдэгдэл 1477

Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж,
хяналт тогтоосон

998

үлдэгдэл 958

Хүмүүжлийн чанартай албадлагын
арга хэмжээ авагдсан

89

үлдэгдэл 160

Эмнэлгийн чанартай албадлагын
арга хэмжээ авагдсан

21

үлдэгдэл 44

Хөрөнгө, орлогыг хураах албадлагын
арга хэмжээ авагдсан

1161

үлдэгдэл 479

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх
тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан

82

үлдэгдэл 75

Эрх хасах албадлагын
арга хэмжээ авагдсан

1

үлдэгдэл 7

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2022 оны үйл ажиллагааны товч танилцуулга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ, конвенц, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааврын хүрээнд ажилладаг.

Улсын хэмжээнд нээлттэй хорих анги 7, хаалттай хорих анги 5, нээлттэй, хаалттай хорих анги 5, өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага 1, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 2, эмэгтэйчүүдийн хорих анги 1, нийт 21 хорих анги, баривчлах төв 1, баривчлах байр 1, нийслэлд цагдан хорих төв 1, орон нутагт 28 цагдан хорих байр үйл ажиллагаа явуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2022 онд ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр дараах онцлох ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

1. Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн 14870 ялтнаас 10177 ялтны ялыг бүрэн эдлүүлж, 2022 оны эцсийн байдлаар 4693 ялтан бүртгэл хяналтад байна.

2. Гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох саналыг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар 4 иргэнд 29.755.320 төгрөгийг, мөн сайдын 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/168 дугаар тушаалаар 49 иргэнд 375.093.132 төгрөгийг, мөн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/311 дүгээр тушаалаар 8 иргэнд 88.433.865 төгрөгийг тус тус олгохоор шийдвэрлүүлж, төлбөрийн мөнгийг шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.

3. Торгох ялаар шийтгүүлсэн 83, нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 206, зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн 480, нийт 769 хүний ялыг хорих ялаар сольж шийдвэрлэсэн. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх 78 ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 154 дүгээр зүйлд заасан үндэслэлээр /торгох 14, нийтэд тустай ажил хийлгэх 35, зорчих эрхийг хязгаарлах 29/ түдгэлзүүлсэн. 84 /торгох 23, нийтэд тустай ажил хийлгэх 31, зорчих эрхийг хязгаарлах 30/ ялтанд холбогдох эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээсэн.

4. “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/167, А/233 дугаар хамтарсан тушаалаар баталсан.

5. 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр “Бодь Электроникс” ХХК-тай хамтран Цахим хяналт-удирдлагын төвийн зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын системд байршин ажиллаж байгаа сервер тоног төхөөрөмжийн системийн өгөгдлийн бааз болон үндсэн хяналтын программ хангамжийн ажиллах орчныг сайжруулсан. Нэмэлт сайжруулалтын хүрээнд дээрх сүлжээний дэд бүтцийн тохиргоог шинээр зохион байгуулсан. Dumpfile буюу мэдээллийн сангийн нөөц өгөгдлийг хуулбарлаж, сервер компьютерт зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем байршин ажиллах орчныг шинээр бүрдүүлж, 2228 цахим бугуйвчийн холболтыг үүсгэж, идэвхтэй 1342 цахим бугуйвчийг хяналтад оруулсан.

6. Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагааг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах ажлын хүрээнд зүүн бүсийн албадан эмчлэх эмнэлгийг Дорнод аймагт, баруун бүсийн албадан эмчлэх эмнэлгийг Баянхонгор аймагт тус тус байгуулсан ба Улаанбаатар хотын 300 ор бүхий төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг шинээр байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21

дүгээр хорооны нутаг дэвсгэр Ташрын хөндийд 150 га газарт Нийслэлийн Засаг даргын 2022.09.07-ны өдрийн А/1174 дүгээр захирамжаар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, эрхийн улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулсан.

7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь урьд онуудад зөвхөн нийслэлийн хэмжээнд баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн этгээдийн шийтгэлийг эдлүүлэх ажиллагааг зохион байгуулдаг байсан бол 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс Булган, Дундговь, Дорнод, Орхон, Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шүүхээс шинээр баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн этгээдийг хүлээн авсан.

8. Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвөөс “Монгол Улсад пробацын тогтолцоог бий болгох боломж, шийдэл” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Энэхүү судалгааны ажил нь 2021 онд хийж гүйцэтгэсэн “Пробацын үйл ажиллагааны харьцуулсан судлал” судалгааны ажлын үргэлжлэл бөгөөд гадаадын зарим улсын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны арга, хэлбэр болох пробацын хяналтын тогтолцооны талаар харьцуулсан судалгаанд түшиглэн Монгол Улсад энэхүү тогтолцоог бий болгох боломжийн талаар хийсэн судалгааны ажил юм.

9. 2022 онд нийт 1930 хоригдлыг хөдөлмөрөөр ханган ажилласан ба хоригдолд 2,023.8 сая төгрөгийн цалин бодогдсоноос хоригдлын гэм хорын төлбөрт 331.2 сая төгрөг, ар гэрээс нь шууд төлсөн болон ангийн дансаар дамжсан нийт 207.1 сая төгрөгийг шүүхийн төлбөрт барагдуулсан байна.

2.Хорих ялын гүйцэтгэл

2022 онд нийт 4157 хоригдол хорих ял эдэлсэн нь 2021 онд хорих ял эдэлсэн хоригдлын тоотой харьцуулахад 1113 буюу 35.6%-иар өссөн байна.

Хүснэгт 1. Хорих ял эдлэгсдийн судалгаа

д/д	Өсөлт, бууралт			
	2021	2022	Тоо	Аувь
1	3044	4157	1113	35.6%

2022 онд нийт хорих ял эдлэгсдийн 93.9% буюу 3903 хоригдол нь эрэгтэй, 6.1% буюу 254 нь эмэгтэй хоригдол байна.

Хүснэгт 2. Хорих ял эдлэгсдийн хүйсийн судалгаа

д/д	Хүйс	Өсөлт, бууралт			
		2021	2022	Тоо	Хувь
1	Эрэгтэй	2877	3903	1113	38.69
2	Эмэгтэй	167	254	87	52.1

2022 оны байдлаар нийт хоригдлын боловсролын түвшнийг судлахад 423 хоригдол дээд /доктор, магистр, дипломын дээд/ боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 95 буюу 28.96%-иар, 208 хоригдол тусгай мэргэжлийн дунд боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 56 буюу 30.84%-иар, 14 хоригдол техникийн болон мэргэжлийн боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 3 буюу 27.27%-иар, 1427 хоригдол бүрэн дунд боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 450 буюу 46.05%-иар, 1007 хоригдол суурь боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 242 буюу 31.63%-иар, 596 хоригдол бага боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 165 буюу 38.28%-иар, 482 хоригдол ямар нэг боловсролгүй байсан нь урьд оныхтой харьцуулахад 102 буюу 26.84%-иар тус тус өссөн байна.

Хүснэгт 3. Хорих ял эдлэгсдийн боловсролын судалгаа

д/д	Боловсролын зэрэг	Өсөлт, бууралт			
		2021	2022	Тоо	Хувь
1	Дээд /доктор, магистр, дипломын дээд/	328	423	95	28.96

2	Тусгай мэргэжлийн дунд	152	208	56	36.84
3	Техникийн болон мэргэжлийн	11	14	3	27.27
4	Бүрэн дунд	977	1427	450	46.05
5	Суурь	765	1007	242	31.63
6	Бага	431	596	165	38.28
7	Боловсролгүй	380	482	102	26.84

Хорих байгууллагад хоригдож буй хоригдлуудын нийт эдлэх ялын хугацааг судлан үзэхэд дийлэнх нь буюу 44.7% нь 0-5 жил хүртэл хоригдох хугацаатай байгаа бол 20 ба түүнээс дээш жил хорих ял эдлэх хоригдлын тоо 16 буюу 8.6%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4. Хорих ял эдлэх хугацааны судалгаа

д/д	Эдлэх хорих ялын хугацаа	Өсөлт, бууралт			
		2021	2022	Тоо	Хувь
1	0-1 жил	177	632	455	257.06
2	2 жил	192	402	210	109.38
3	3 жил	202	392	190	94.06
4	4 жил	199	215	16	8.04
5	5 жил	182	216	34	18.68
6	6 жил	252	306	54	21.43
7	7 жил	130	150	20	15.39
8	8 жил	250	267	17	6.8
9	9 жил	118	140	22	18.64
10	10 жил	160	177	17	10.63
11	11 жил	58	53	-5	-8.62
12	12 жил	219	260	41	18.72
13	13 жил	167	161	-6	-3.59
14	14 жил	82	112	30	36.59
15	15 жил	140	140	0	0
16	16 жил	133	130	-3	-2.26
17	17 жил	48	48	0	0
18	18 жил	97	119	22	22.68
19	19 жил	51	34	-17	-33.33
20	20 ба түүнээс дээш	187	203	16	8.56

Нийт хорих ял эдлэгсдийн 26.9% нь “Хүний амьд явах эрхийн эсрэг”, 27.1% нь “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг”, 34.7% нь “Өмчлөх эрхийн эсрэг” гэмт хэрэг үйлдсэн хоригдлууд байна.

Хүснэгт 5. Хорих ял эдлэгсдийн ял шийтгээгдсэн зүйлчлэлийн судалгаа

д/д	Гэмт хэргийн зүйлчлэл	Өсөлт, бууралт			
		2021	2022	Тоо	Хувь
1	Хүний амьд явах эрхийн эсрэг	1079	1120	41	3.8
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	271	369	98	36.16
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	824	952	128	15.53
4	Хүний халдашгүй, чөлөөт байх эрхийн эсрэг	22	27	5	22.73
5	Эрүүл мэндийн эсрэг	0	2	2	200
6	Хүүхдийн эсрэг	2	2	0	0
7	Өмчлөх эрхийн эсрэг	716	1443	727	101.5
8	Эдийн засгийн эсрэг	23	16	-7	-30.43
9	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	9	10	1	11.11
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	44	122	78	177.3
11	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг	0	2	2	200
12	Авлигын	10	9	-1	-10
13	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	2	2	0	0

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2022

14	Хүрээлэн байгаа орчны эсрэг	1	4	3	300
16	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	0	2	2	200
17	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	40	75	35	87.5
18	Цэргийн албаны эсрэг	1	0	-1	-100

Нийт хорих ял эдлэгсдийн 39.33% Улаанбаатар хотын харьяат байна.

Хүснэгт 6. Хорих ял эдлэгсдийн орон нутгийн харьяаллын судалгаа

д/д	Орон нутаг	Өсөлт, бууралт			
		2021	2022	Тоо	Хувь
1	Архангай	70	150	80	114.3
2	Баянхонгор	96	131	35	36.46
3	Баян-Өлгий	32	59	27	84.38
4	Булган	73	103	30	41.1
5	Говь-Алтай	50	88	38	76
6	Дорнод	142	204	62	43.66
7	Дорноговь	66	112	46	69.7
8	Дундговь	44	80	36	81.82
9	Завхан	60	104	44	73.33
10	Өвөрхангай	100	151	51	51
11	Өмнөговь	59	78	19	32.2
12	Сүхбаатар	60	84	24	40
13	Сэлэнгэ	132	171	39	29.55
14	Төв	105	160	55	52.38
15	Хөвсгөл	84	125	41	48.81
16	Хэнтий	106	193	87	82.08
17	Ховд	41	45	4	9.76
18	Увс	60	117	57	95
19	Говьсүмбэр	23	35	12	52.17
20	Дархан-Уул	123	156	33	26.83
21	Орхон	89	118	29	32.58
22	Улаанбаатар	1401	1635	234	16.7

Нийт хорих ял эдлэгсдийн 46.1% нь анх удаа ял шийтгэгдсэн 53.9% нь хоёр ба түүнээс дээш удаа ял шийтгэгдсэн хоригдлууд байна.

Хүснэгт 7. Хорих ял эдлэгсдийн шүүхээр хэдэн удаа ял шийтгүүлсэн талаарх судалгаа

д/д	Хэдэн удаа	Өсөлт, бууралт			
		2021	2022	Тоо	Хувь
1	Анх удаа	1446	1917	471	32.57
2	2 удаа	634	910	276	43.53
3	3 удаа	331	492	161	48.64
4	4 удаа	213	292	79	37.09
5	5 удаа	169	209	40	23.67
6	6 удаа	106	148	42	39.62
7	7 удаа	60	86	26	43.33
8	8 удаа	43	52	9	20.93
9	9 удаа	20	29	9	45
10	10 удаа	12	11	-1	-8.33
11	10-аас дээш удаа	10	11	1	10

2022 онд гадаад улсын харьяат 28 хоригдол ял эдэлснээс 20 буюу 71.4% нь БНХАУ-ын иргэн байжээ.

Хүснэгт 8. Хорих ял эдлэгсдийн иргэний харьяалал

д/д	Харьяалал	Өсөлт, бууралт			
		2021	2022	Тоо	Хувь
1	Монгол Улс	3018	4129	1111	36.81
2	БНХАУ	15	20	5	33.33
3	ОХУ	3	1	-2	-66.67
4	БНСУ	2	0	-2	-100
5	Бусад улс	6	7	1	16.67

2022 онд ШШГЕГ-ын харьяа хорих анги, цагдан хорих байрнаас 8 хоригдол оргосон нь урьд оноос 6 буюу 300% өссөн байна.

Хүснэгт 9. Хорих анги, цагдан хорих байрнаас хоригдол, хоригдогч оргосон судалгаа

д/д	Оргодлын тоо	Өсөлт, бууралт			
		2021	2022	Тоо	Хувь
1		2	8	6	300

3.Хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл

3.1.Хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хорихоос өөр төрлийн дараах ялыг гүйцэтгэж байна. Үүнд:

Нэг.Хорихоос өөр төрлийн ял:

1. Торгох ял;
2. Нийтэд тустай ажил хийлгэх ял;
3. Зорчих эрхийг хязгаарлах ял;
4. Эрх хасах ял.

Хүснэгт 10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гүйцэтгэсэн хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл:

Шүүхийн шийдвэрийн төрөл	Хэмжих нэгж	Гүйцэтгэвэл зохих		Гүйцэтгэсэн		Үлдэгдэл			
		2021	2022	2021	2022	2021	2022		
1. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн	Нийт ялтны тоо	12945	15261	9376	10555	3569	4706		
Үүнээс:	Торгох ял шийтгүүлсэн	Хүнд	Ялтны тоо	7659	8928	6617	7397	1042	1531
		Хуулийн этгээдэд	Мөнгөн дүн	11924432.8	13910588.4	8515044.4	8120463.6	3409388.4	5790124.8
	тоо		4	10	2	2	2	8	
	Зорчих эрхийг хязгаарлах ял	Мөнгөн дүн	250240.0	414500.0	116240.0	196977.0	134000.0	217523.0	
		Ялтны тоо	1602.0	3016	402	1702	1200	1314	
	Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн	Хоног	767211.0	1224497	256811.0	744603.0	510400.0	479894.0	
		Ялтны тоо	1647	1417	1364	1134	283	283	
	Эрх хасах ял шийтгүүлсэн	Цаг	540117	488639	459755	400525	80362	88114	
		Ялтны тоо	2033	1890	991	320	1042	1570	
	2. Албадлагын арга хэмжээ авагдсан	Хоног	1452545	1564732	678429	522812	774116	1041920	
Нийт этгээдийн тоо		8850	6201	6512	3001	2338	3200		
Үүнээс:	Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн	Этгээдийн тоо	4147	2126	3652	649	495	1477	
	Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан	Этгээдийн тоо	269	157	195	82	74	75	

Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон	Этгээдийн тоо	2743	1956	1596	998	1147	958
Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	Этгээдийн тоо	318	249	242	89	76	160
Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	Этгээдийн тоо	53	65	17	21	36	44
Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан	Этгээдийн тоо	1316	1640	808	1161	508	479
Эрх хасах албадлагын арга хэмжээ авагдсан	Хуулийн этгээдийн тоо	4	8	2	1	2	7

3.1.1. Торгох ялыг нэг зуун нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг (нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү) байхаар шүүх тогтоох ба шүүхийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор, хэрэв хэсэгчлэн төлөхөөр тогтоосон бол тогтоосон хугацаанд биелүүлэх үүрэгтэй байдаг. Хэрэв шүүхээс оногдуулсан торгуулийг төлөөгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ялтны хөрөнгөөс албадан гаргуулах журмаар гүйцэтгэж байна.

Хүснэгт 11. Торгох ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)

д/д	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	
			Нийт	Үүнээс ял сольсон		Нийт	Үүнээс ял сольсон
1	Архангай	163	147	2	189	171	-
2	Баян-Өлгий	119	97	1	106	74	-
3	Баянхонгор	183	160	1	107	89	-
4	Булган	128	105	2	163	146	1
5	Говь-Алтай	87	70	2	86	75	3
6	Говьсүмбэр	81	76	-	50	46	1
7	Дархан-Уул	273	234	4	299	250	2
8	Дорноговь	85	76	1	79	51	-
9	Замын-Үүд	78	60	-	76	71	-
10	Дорнод	286	259	5	274	234	4
11	Дундговь	84	79	-	129	114	-
12	Завхан	80	73	-	98	96	-
13	Тосонцэнгэл	35	30	1	46	45	-
14	Орхон	213	184	1	264	233	-
15	Өвөрхангай	92	80	-	139	126	2
16	Өмнөговь	105	100	1	104	85	-
17	Сүхбаатар	119	116	-	134	120	-
18	Сэлэнгэ	99	83	1	155	116	-
19	Хөтөл	29	22	1	42	33	-
20	Төв	245	228	1	279	249	3
21	Увс	93	82	-	126	98	-
22	Ховд	180	157	-	210	168	-
23	Хөвсгөл	201	196	1	215	183	-
24	Хэнтий	182	146	2	172	146	2
25	НШШГГ	3983	3360	43	4885	3956	71

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ – CORRECTION

26	Налайх	133	113	2	180	138	-
27	Багануур	106	99	3	91	79	1
28	Хархорин	53	50	-	67	64	-
29	Мандал	98	91	-	99	84	-
30	Ханбогд	46	44	-	64	57	1
Дүн		7659	6617	75	8928	7397	91

3.1.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нийтэд тустай ажил хийлгэх ялыг гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлсгүйгээр хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар хийлгэх үйл явцад хяналт тавин, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүснэгт 12. Нийтэд тустай ажил хийлгэх ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)

д/д	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	
			Нийт	Үүнээс ял сольсон		Нийт	Үүнээс ял сольсон
1	Архангай	36	34	3	22	22	6
2	Баян-Өлгий	31	30	3	14	10	0
3	Баянхонгор	45	41	3	29	27	1
4	Булган	25	23	5	18	16	2
5	Говь-Алтай	10	10	1	9	8	0
6	Говьсүмбэр	9	8	-	12	10	5
7	Дархан-Уул	43	38	9	31	28	9
8	Дорноговь	18	17	6	20	13	4
9	Замын-Үүд	10	7	1	5	4	1
10	Дорнод	67	51	7	47	40	6
11	Дундговь	12	12	1	11	9	5
12	Завхан	18	15	-	24	20	2
13	Тосонцэнгэл	3	3	-	2	2	0
14	Орхон	41	39	8	23	20	8
15	Өвөрхангай	19	18	1	18	16	0
16	Өмнөговь	16	15	2	10	10	4
17	Сүхбаатар	11	10	1	9	9	1
18	Сэлэнгэ	6	4	1	17	11	0
19	Хөтөл	4	4	-	3	2	0
20	Төв	46	38	1	40	33	10
21	Увс	36	33	2	26	22	0
22	Ховд	12	12	-	16	13	1
23	Хөвсгөл	38	37	1	36	29	1
24	Хэнтий	52	37	2	55	35	11
25	НШШГГ	959	753	112	862	671	125
26	Налайх	34	31	1	33	30	6
27	Багануур	20	20	3	13	13	3
28	Хархорин	19	17	3	7	7	0
29	Мандал	4	4	1	4	4	1
30	Ханбогд	3	3	-	1	0	0
Дүн		1647	1364	178	1417	1134	212

3.1.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхээс оногдуулсан нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хориглосон шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт 13. Эрх хасах ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)

Д/д	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл	Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл
1	Архангай	57	28	29	48	2	46
2	Баян-Өлгий	71	23	48	71	8	63
3	Баянхонгор	42	19	23	34	7	27
4	Булган	21	12	9	25	2	23
5	Говь-Алтай	26	13	13	23	5	18
6	Говьсүмбэр	22	16	6	10	1	9
7	Дархан-Уул	56	29	27	55	7	48
8	Дорноговь	23	13	10	24	1	23
9	Замын-Үүд	28	14	14	25	5	20
10	Дорнод	86	36	50	73	6	67
11	Дундговь	27	15	12	26	4	22
12	Завхан	16	11	5	14	1	13
13	Тосонцэнгэл	10	3	7	16	0	16
14	Орхон	66	41	25	48	4	44
15	Өвөрхангай	44	24	20	30	5	25
16	Өмнөговь	36	17	19	35	4	31
17	Сүхбаатар	43	20	23	36	6	30
18	Сэлэнгэ	43	21	22	38	9	29
19	Хөтөл	14	7	7	9	2	7
20	Төв	41	19	22	50	7	43
21	Увс	31	18	13	35	4	31
22	Ховд	48	21	27	61	6	55
23	Хөвсгөл	79	41	38	66	11	55
24	Хэнтий	44	25	19	30	6	24
25	НШШГГ	979	465	514	930	196	734
26	Налайх	28	17	11	24	5	19
27	Багануур	10	6	4	10	1	9
28	Хархорин	12	3	9	14	0	14
29	Мандал	18	7	11	18	2	16
30	Ханбогд	12	7	5	12	3	9
	Дүн	2033	991	1042	1890	320	1570

3.1.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхээс оногдуулсан нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хориглосон шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт 14. Зорчих эрхийг хязгаарлах ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)

Д/д	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл	Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл
1	Архангай	42	10	32	107	62	45
2	Баян-Өлгий	48	8	40	67	37	30
3	Баянхонгор	38	14	24	63	42	21
4	Булган	23	10	13	37	25	12
5	Говь-Алтай	20	2	18	29	13	16

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ – CORRECTION

6	Говьсүмбэр	27	6	21	15	11	4
7	Дархан-Уул	56	19	37	84	54	30
8	Дорноговь	26	12	14	49	30	19
9	Замын-Үүд	26	8	18	24	15	9
10	Дорнод	80	22	58	98	43	55
11	Дундговь	21	7	14	22	16	6
12	Завхан	17	5	12	55	21	34
13	Тосонцэнгэл	9	3	6	13	2	11
14	Орхон	59	22	37	129	73	56
15	Өвөрхангай	40	11	29	60	28	32
16	Өмнөговь	38	9	29	22	17	5
17	Сүхбаатар	30	5	25	49	25	24
18	Сэлэнгэ	32	7	25	37	24	13
19	Хөтөл	14	3	11	17	7	10
20	Төв	34	11	23	75	50	25
21	Увс	27	6	21	79	33	46
22	Ховд	42	17	25	42	21	21
23	Хөвсгөл	68	21	47	73	58	15
24	Хэнтий	35	10	25	151	95	56
25	НШШГГ	808	196	612	1490	821	669
26	Налайх	33	12	21	47	27	20
27	Багануур	12	4	8	29	22	7
28	Хархорин	13	6	7	22	9	13
29	Мандал	17	7	10	14	11	3
30	Ханбогд	8	1	7	17	10	7
Дүн		1743	474	1269	3016	1702	1314

3.1.5. Шүүхээс оногдуулсан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнссэн шийдвэрийг гүйцэтгэхдээ ялтны түүний оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, нэгж хяналт тавьж байна.

Хүснэгт 15. Тэнссэн этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

д/д	Үзүүлэлт	2021 он				2022 он			
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн	Одоо хяналтад байгаа	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн	Одоо хяналтад байгаа
1	Архангай	114	-	-	11	19	-	-	29
2	Баян-Өлгий	69	1	3	6	11	-	-	20
3	Баянхонгор	136	1	-	38	45	-	-	35
4	Булган	81	-	-	26	27	-	-	44
5	Говь-Алтай	54	-	1	18	17	-	1	36
6	Говьсүмбэр	23	-	-	3	2	-	-	6
7	Дархан-Уул	149	-	4	21	28	-	-	62
8	Дорноговь	32	-	-	5	11	-	1	30
9	Замын-Үүд	36	1	-	6	8	-	-	14
10	Дорнод	139	-	1	12	17	-	-	51
11	Дундговь	44	-	-	7	14	3	-	20
12	Завхан	63	-	-	4	8	-	-	29

13	Тосонцэнгэл	36	-	-	2	5	-	-	34
14	Орхон	125	-	1	11	17	-	-	53
15	Өвөрхангай	82	-	1	18	23	-	-	24
16	Өмнөговь	53	-	-	5	9	-	-	40
17	Сүхбаатар	24	-	-	0	0	-	-	15
18	Сэлэнгэ	105	1	1	4	12	2	-	34
19	Хөтөл	74	-	-	9	13	-	-	27
20	Төв	28	-	-	6	5	-	-	10
21	Увс	110	1	-	17	23	-	-	48
22	Ховд	47	-	-	21	12	1	1	47
23	Хөвсгөл	114	-	1	21	43	-	-	43
24	Хэнтий	173	-	-	33	16	-	-	73
25	НШШГГ	102	-	3	10	12	-	-	37
26	Налайх	1453	14	13	141	208	-	5	524
27	Багануур	57	-	-	7	10	-	-	13
28	Хархорин	38	-	-	2	1	-	-	5
29	Мандал	48	1	-	10	11	1	-	24
30	Ханбогд	43	-	-	21	22	-	1	50
Дүн		3652	20	29	495	649	7	9	1477

3.2. Албадлагын арга хэмжээний гүйцэтгэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан дараах албадлагын арга хэмжээг гүйцэтгэж байна. Үүнд:

1. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ;
2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;
3. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ;
4. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах;
5. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ.

Хүснэгт 16. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гүйцэтгэсэн хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл

Албадлагын арга хэмжээний төрөл		Хэмжих нэгж	Гүйцэтгэвэл зохих		Гүйцэтгэсэн		Үлдэгдэл	
			2021	2022	2021	2022	2021	2022
			8850	6201	6512	3001	2338	3200
Үүнээс:	Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн	Этгээдийн тоо	4147	2126	3652	649	495	1477
	Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан	Этгээдийн тоо	269	157	195	82	74	75
	Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон	Этгээдийн тоо	2743	1956	1596	998	1147	958
	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	Этгээдийн тоо	318	249	242	89	76	160

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	Этгээдийн тоо	53	65	17	21	36	44
Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан	Этгээдийн тоо	1316	1640	808	1161	508	479
Эрх хасах албадлагын арга хэмжээ авагдсан	Хуулийн этгээдийн тоо	4	8	2	1	2	7

3.2.1. Шүүхээс анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулсан шийдвэрийг ялтны оршин суугаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас хяналт тавьж, хэрэгжүүлж байна.

Хүснэгт 17. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

д/д	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн
1	Архангай	0	-	-	2	-	-
2	Баян-Өлгий	0	-	-	0	-	-
3	Баянхонгор	8	-	-	5	-	1
4	Булган	3	-	-	2	-	-
5	Говь-Алтай	5	-	-	1	-	-
6	Говьсүмбэр	1	-	-	0	-	-
7	Дархан-Уул	10	-	-	2	-	-
8	Дорноговь	2	-	-	3	-	-
9	Замын-Үүд	0	-	-	0	-	-
10	Дорнод	7	-	-	3	-	-
11	Дундговь	1	-	1	0	-	-
12	Завхан	0	-	-	0	-	-
13	Тосонцэнгэл	2	-	-	1	-	-
14	Орхон	2	-	-	1	-	-
15	Өвөрхангай	1	-	-	1	-	-
16	Өмнөговь	1	-	-	1	-	-
17	Сүхбаатар	2	-	-	3	-	-
18	Сэлэнгэ	0	-	-	0	-	-
19	Хөтөл	11	-	-	2	-	-
20	Төв	1	-	-	1	-	1
21	Увс	4	-	-	4	-	-
22	Ховд	7	-	-	4	-	-
23	Хөвсгөл	6	-	1	2	-	-
24	Хэнтий	1	-	-	1	-	-
25	НШШГГ	3	-	-	0	-	-
26	Налайх	109	1	11	38	1	1
27	Багануур	2	-	-	4	-	-
28	Хархорин	3	-	1	0	-	-

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2022

29	Мандал	1	-	-	1	-	-
30	Ханбогд	2	-	-	0	-	-
Дүн		195	1	14	82	1	3

3.2.2.Хорих анги нь хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай шүүгчийн захирамжийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хоригдлын зан байдал, засрал хүмүүжлийн талаарх тодорхойлолтыг шүүгчийн захирамжийн хамт түүний оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлж, тухайн алба хяналтыг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 18. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

д/д	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн
1	Архангай	56	-	-	30	1	1
2	Баян-Өлгий	31	-	-	14	-	-
3	Баянхонгор	54	-	5	39	-	2
4	Булган	16	-	-	12	-	-
5	Говь-Алтай	17	-	-	9	-	-
6	Говьсүмбэр	17	-	-	5	-	-
7	Дархан-Уул	71	-	3	31	-	2
8	Дорноговь	28	-	2	14	-	1
9	Замын-Үүд	15	-	-	9	-	-
10	Дорнод	49	-	-	35	-	-
11	Дундговь	12	-	1	6	-	-
12	Завхан	17	-	-	7	-	-
13	Тосонцэнгэл	11	-	-	4	-	-
14	Орхон	56	-	2	40	-	6
15	Өвөрхангай	23	-	-	11	-	2
16	Өмнөговь	28	-	-	16	-	-
17	Сүхбаатар	6	-	-	4	-	-
18	Сэлэнгэ	34	-	1	18	-	-
19	Хөтөл	30	-	-	15	-	-
20	Төв	15	-	-	9	-	-
21	Увс	45	-	1	33	-	-
22	Ховд	39	-	-	35	1	-
23	Хөвсгөл	26	-	-	13	-	1
24	Хэнтий	62	-	-	37	-	3
25	НШШГГ	37	1	1	27	-	-
26	Налайх	727	1	17	477	3	21
27	Багануур	28	-	-	15	1	-
28	Хархорин	14	-	1	13	2	-
29	Мандал	12	-	-	7	-	-
30	Ханбогд	20	-	-	13	-	-
Дүн		1596	2	34	998	8	39

3.2.3. Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэсэн шийдвэрийг хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэх ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, нэгдсэн тоо бүртгэл хөтөлж байна.

Хүснэгт 19. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

Д/Д	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн
1	Архангай	12	-	-	1	-	-
2	Баян-Өлгий	16	-	-	6	-	-
3	Баянхонгор	11	-	-	4	-	-
4	Булган	3	-	-	0	-	-
5	Говь-Алтай	3	-	-	2	-	1
6	Говьсүмбэр	1	-	-	0	-	-
7	Дархан-Уул	25	-	3	3	-	-
8	Дорноговь	8	-	-	7	-	1
9	Замын-Үүд	3	-	-	4	-	-
10	Дорнод	3	-	-	2	-	-
11	Дундговь	5	-	-	2	-	-
12	Завхан	1	-	-	0	-	-
13	Тосонцэнгэл	2	-	-	0	-	-
14	Орхон	7	-	-	4	-	1
15	Өвөрхангай	8	-	-	5	-	-
16	Өмнөговь	5	-	-	2	-	-
17	Сүхбаатар	1	-	-	1	-	-
18	Сэлэнгэ	3	-	-	1	-	-
19	Хөтөл	9	-	-	1	-	-
20	Төв	0	-	-	1	-	-
21	Увс	0	-	-	1	-	-
22	Ховд	8	-	-	1	-	-
23	Хөвсгөл	0	-	-	1	-	-
24	Хэнтий	5	-	-	6	-	-
25	НШШГГ	10	-	-	4	-	-
26	Налайх	84	1	1	28	-	-
27	Багануур	3	-	-	1	-	-
28	Хархорин	4	-	1	1	-	-
29	Мандал	1	-	-	0	-	-
30	Ханбогд	1	-	-	0	-	-
	Дүн	242	1	5	89	0	3

3.2.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2022

Хүснэгт 20. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

д/д	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Одоо хяналтад байгаа	Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Одоо хяналтад байгаа
1	Архангай	93	70	23	139	101	38
2	Баян-Өлгий	77	35	42	78	58	20
3	Баянхонгор	126	71	55	102	83	19
4	Булган	60	39	21	69	56	13
5	Говь-Алтай	74	37	37	84	55	29
6	Говьсүмбэр	0	-	0	0	0	0
7	Дархан-Уул	56	30	26	56	40	16
8	Дорноговь	15	6	9	27	11	16
9	Замын-Үүд	18	9	9	20	12	8
10	Дорнод	122	57	65	89	40	49
11	Дундговь	12	5	7	20	9	11
12	Завхан	45	31	14	67	53	14
13	Тосонцэнгэл	24	21	3	39	34	5
14	Орхон	23	17	6	37	30	7
15	Өвөрхангай	32	25	7	39	18	21
16	Өмнөговь	0	-	-	3	3	0
17	Сүхбаатар	0	-	0	20	17	3
18	Сэлэнгэ	25	23	2	20	18	2
19	Хөтөл	47	38	9	69	34	35
20	Төв	14	9	5	27	19	8
21	Увс	0	-	0	1	0	1
22	Ховд	117	80	37	120	90	30
23	Хөвсгөл	45	30	15	68	50	18
24	Хэнтий	80	63	17	75	63	12
25	НШШГГ	88	34	54	116	63	53
26	Налайх	39	19	20	114	78	36
27	Багануур	0	-	0	0	0	0
28	Хархорин	0	-	0	4	3	1
29	Мандал	64	51	13	68	60	8
30	Ханбогд	20	8	12	69	63	6
Дүн		1316	808	508	1640	1161	479

Хүснэгт 21. Хуулийн этгээдэд эрх хасах, татан буулгах албадлагын арга хэмжээ авсан судалгаа

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 он			2022 он		
			Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан
1	Баянхонгор	Этгээдийн тоо	1	2	1	2	-	1
2	Хэнтий	Этгээдийн тоо	1	-	1	-	-	-
3	Дорноговь	Этгээдийн тоо	-	-	-	-	2	-
4	Төв	Этгээдийн тоо	-	-	-	-	1	-
5	НШШГГ	Этгээдийн тоо	-	-	-	-	3	-
ДҮН			2	2	2	2	6	1

Хүснэгт 22. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 он			2022 он		
			Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан
1	НШШГГ	Этгээдийн тоо	37	16	17	36	29	21
ДҮН			37	16	17	36	29	21

4. Баривчлах шийтгэлийн гүйцэтгэл

Зөрчлийн тухай хуульд заасны дагуу зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулах, баривчлах шийтгэлийг Улаанбаатар хотод шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэж байна.

Хүснэгт 23. Баривчлагдсан этгээдийн судалгаа (Улаанбаатар хотын хэмжээнд)

д/д	Шийтгэлийн төрөл	Өсөлт, бууралт			
		2021	2022	Тоо	Хувь
1	Баривчлагдсан этгээд	5584	6074	490	8.8

Зөрчлийн тухай хуулийн:

5.1 дүгээр зүйл. Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах;

5.2 дугаар зүйл. Танхайрах;

5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих;

5.8 дугаар зүйл. Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих;

6.20 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг зөрчих;

6.26 дугаар зүйл. Бэлгийн дарамт учруулах;

8.6 дугаар зүйл. Хулгайлах;

8.7 дугаар зүйл. Хөрөнгө завших;

14.7 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зэрэг зөрчилд баривчлах шийтгэл ногдуулахаар тусгасан байна.

Хүснэгт 24. Баривчлагдсан этгээдүүдийн үйлдсэн зөрчлийн судалгаа (Улаанбаатар хотын хэмжээнд)

д/д	Зөрчлийн тухай хуулийн заалт	Өсөлт, бууралт			
		2021	2022	Тоо	Хувь
1	Танхайрах /ЗТХ-5.2.1 олон нийтийн газар/	365	93	-272	-74.5
2	Мансуурах /ЗТХ-5.1.3/	51	59	8	15.7
3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих /ЗТХ-5.4.4/	4029	1932	-2097	-52
4	Хулгайлах /ЗТХ-8.6.1/	390	111	-279	-71.5
5	Хөрөнгө завших /ЗТХ-8.7.1/	2	0	-2	2 нэгжээр буурсан
6	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих /ЗТХ-14.7.5 эрхгүй үедээ согтуугаар/	732	611	-121	-16.5
7	Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих /ЗТХ-5.13.2/	10	34	24	24 нэгжээр өссөн
8	Хүүхдийн эрх зөрчих /6.20.6/	5	3	-2	-40

5. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэл

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оргон зайлахыг завдсан, оргон зайлсан, шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй зэрэг үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлийг

ШШГЕГ-ын харьяа цагдан хорих төв, байрууд хэрэгжүүлж байна.

Хүснэгт 25. Цагдан хоригдсон хоригдогсдын судалгаа

д/д	Цагдан хорих байр	Өсөлт, бууралт			
		2021	2022	Тоо	Хувь
1.	Хоригдогч	1169	1082	-87	-7.4

---o0o---

ТАВДУГААР БҮЛЭГ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР - ANTI-CORRUPTION AGENCY

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
3. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА
4. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛ
5. МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКС
6. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НИЙТЛЭГ АЖИЛ



ГЭМТ ХЭРГИЙН
ШИНЖТЭЙ

1413

ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ
БҮРТГЭЛД ОРУУЛАН ШАЛГАСАН

ХУУЛЬД ЗААСАН ХАРЬААЛЛЫН

1806 үйлдэлтэй
1184 холбогдогчтой
1520 хэрэгт



ХЭРЭГ БҮРТГЭЛТ,
МӨРДӨН БАЙЦААЛТЫН
АЖИЛЛАГАА ЯВУУЛАВ

ШҮҮХЭЭР **188** хэрэг эцэслэн
ШИЙДВЭРЛЭГДСЭН



МӨРДӨН ШАЛГАХ
АЖИЛЛАГААНЫ
ЯВЦАД



518.039.332.298
ТӨГРӨГИЙГ БИТҮҮМЖЛЭН
ХАМГААЛАВ



2.374.934.309.243
ТӨГРӨГИЙН ХОХИРЛЫГ
НӨХӨН ТӨЛҮҮЛЭВ

1.Товч танилцуулга

2005 онд Монгол Улсын Их Хурал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 дүгээр тогтоолоор баталсан Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсан.

Монгол Улсын Их Хурлаас 2006 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталж, 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан. Уг хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталснаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн түүхтэй.

Авлигатай тэмцэх газар нь дараах чиг үүрэгтэй:

- Улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;

- Авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх;

- Төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

- Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;

- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх;

- Төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх;

Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар сургалт явуулах, гарын авлага, зааварчилгаа гаргах;

- Мэдүүлэг гаргагчийн амаар болон бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдүүлгийг хэрхэн бөглөх, нэмэлт оруулах, бүртгэх, шилжүүлэх талаар урьдчилан зөвлөгөө өгөх, бичгээр хариу мэдэгдэх, асуулт хариултын нууцыг хадгалах.

Авлигатай тэмцэх газар нь дараах бүрэн эрхтэй:

- Авлигын эсрэг явуулах төрийн бодлого, шийдвэр, түүнчлэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагад оруулах;

- Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж, эрх бүхий байгууллагад оруулах;

- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайланг гаргуулан авах;

- Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;

- Авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагуудтай хамтран ажиллах;

- Авлигын холбогдолтой өргөдөл гомдлыг хүлээн авч шалгах;

- Гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан тушаалтан буюу иргэд ил болсон нууцыг задруулахгүйн тулд уг этгээдээс бичгээр баталгаа гаргуулан авах, баталгааг зөрчсөн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;

- Хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх, хуульд заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

- Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргавал зохих этгээдийн жагсаалтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч хянах;

- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын биелэлтийг шалгах;

- Мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, шалгах, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авахуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

- Хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар бичгээр дүгнэлт, зөвлөмж гаргах;

- Авлигатай тэмцэх асуудлаар гадаад орнуудын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;


- Улсын ерөнхий прокурорын шийдвэрээр тодорхой хэрэгт цагдаа, тагнуулын байгууллагатай хамтран ажиллах.

2. Гомдол, мэдээлэл

2022 онд өмнөх оны үлдэгдэл 125, шинээр хүлээн авсан 1716, нийт 1841 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллээс 336-г “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-д заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлж, гэмт хэргийн шинжтэй 1413 гомдол, мэдээллийг бүртгэлд оруулан шалгасан байна.

Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл өмнөх оны мөн үеэс 350 нэгжээр буюу 23.5%-иар өссөн үзүүлэлттэй байна.

График 1. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 621 буюу 43.9%-д хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 684 буюу 48.4%-д хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 52 буюу

3.7%-ийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 56 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 96.0%-тай байв.

Хүснэгт 1. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

д/д	Үзүүлэлт		2019	2020	2021	2022
1	Үүнээс	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	362	487	594	684
2		Харьяаллын дагуу шилжүүлсэн	34	27	44	52
3		Эрүүгийн хэрэг үүсгэсэн буюу хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	489	462	460	621
4		Ажиллагаанд	9	44	46	56
1	Нийт шалгасан гомдол, мэдээлэл		894	1020	1144	1413

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1413 гомдол, мэдээллийн 767 буюу 54.3% нь нийслэл, 646 буюу 45.7% нь орон нутгийн прокурорын газрын хяналтын харьяалалтай гомдол, мэдээлэл байна.

2022 онд гомдол, мэдээлэлд холбогдсон этгээдийг албан тушаалаар нь ангилбал төрийн улс төрийн албан тушаалтан 233, төрийн захиргааны албан тушаалтан 393, төрийн тусгай албан тушаалтан 418, төрийн үйлчилгээний албан тушаалтан 142, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 158, хувийн хэвшил, аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагын албан тушаалтан 69 тус тус холбогдож шалгагдсан байна.

Хүснэгт 2. Гомдол, мэдээлэлд холбон шалгасан этгээдийн албан тушаалын байдал

д/д	Албан тушаалын төрөл	Тоо	Хувь
1	Төрийн улс төрийн	233	16.5
2	Төрийн захиргааны	393	27.9
3	Төрийн тусгай	418	29.6
4	Төрийн үйлчилгээний	142	10.1
5	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд	158	11.2
6	Хувийн хэвшил, аж ахуй нэгж болон төрийн бус байгууллагын албан тушаалтан	69	4.8
7	Нийт холбогдож шалгагдсан албан тушаалтан	1413	100

3. Мөрдөн шалгах ажиллагаа

Авлигатай тэмцэх газар 2022 онд хуульд заасан харьяаллын 1806 үйлдэлтэй, 1184 холбогдогчтой, 1520 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 16.3%-иар өссөн байна.

Хүснэгт 3. Шалгасан хэрэг

Он	Хэргийн тоо	Өссөн, буурсан хувь	Холбогдогчийн тоо	Өссөн, буурсан хувь
2019	1300	-	481	-
2020	1331	+2.3	696	+44.6
2021	1307	-1.8	909	+30.6
2022	1520	+16.2	1184	+30.2

2022 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилбал “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэрэг 1011 буюу 55.9%, “Хахууль авах” гэмт хэрэг 239 буюу 13.2%, “Хахууль өгөх” гэмт хэрэг 138 буюу 7.6%, “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах” гэмт хэрэг 22 буюу 1.2%, “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэг 52 буюу 2.9%, “Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах” гэмт хэрэг 34 буюу 1.9%, “Мөнгө угаах” гэмт хэрэг 37 буюу 2.0%, “Эрүү шүүлт тулгах” хэрэг 15 буюу 0.8%, бусад хэрэг 258 буюу 14.3%-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 4. Шалгасан хэрэг /төрлөөр/

д/д	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг	Тоо	Хувь
1	22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	1011	55.9

2	22.4 дүгээр зүйл. Хахууль авах	239	13.2
3	22.5 дугаар зүйл. Хахууль өгөх	138	7.6
4	22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	22	1.2
5	22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	52	2.9
6	22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	34	1.9
7	18.6 дугаар зүйл. Мөнгө угаах	37	2.0
8	21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах	15	0.8
9	Бусад	258	14.3
10	Нийт	1806	100

Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 56 буюу 4.7%-ийг төрийн улс төрийн, 127 буюу 10.7%-ийг төрийн захиргааны, 103 буюу 8.7%-ийг төрийн тусгай, 84 буюу 7.1%-ийг төрийн үйлчилгээний, 814 буюу 68.8%-ийг бусад этгээд эзэлж байна.

Хүснэгт 5. Авлигын гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

д/д	Албан тушаалын байдал	2021	2022
1	Төрийн улс төрийн албан тушаалтан	91	56
2	Төрийн үйлчилгээний албан тушаалтан	175	84
3	Төрийн тусгай албан тушаал	145	103
4	Төрийн захиргааны албан тушаалтан	149	127
5	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, хувийн хэвшил	349	814

График 2. Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн албан тушаалын байдал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



2022 онд 1520 хэргээс 262 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 17.2%-ийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 3.4%-иар буурсан байна.

Хүснэгт 6. Шалгасан хэргийн шийдвэрлэлт

Он	Шүүхэд шилжүүлэх саналтай	Хэрэг бүртгэлтийг хаах саналтай	Харьяаллын дагуу шилжүүлсэн	Түдгэлзүүлсэн	Бусад хэрэгт нэгтгэсэн
2019	156	556	80	1	22
2020	236	509	48	6	46
2021	269	429	61	5	63
2022	262	389	50	11	93

2022 онд Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах ажиллагаа явуулан шүүхэд шилжүүлсэн хэргээс 188 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 17.5%-иар өссөн байна.

Хүснэгт 7. Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Он	Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	Өмнөх онтой харьцуулахад өссөн, буурсан хувь
2019	68	-
2020	114	+67.6 хувь
2021	160	+40.3 хувь
2022	188	+17.5 хувь

2022 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 5,024,895,829,317.00 /таван их наяд, хорин дөрвөн тэрбум, найман зуун ерэн таван сая, найман зуун хорин есөн мянга, гурван зуун арван долоо/ төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 2,374,934,309,243.00 /хоёр их наяд гурван зуун далан дөрвөн тэрбум, есөн зуун гучин дөрвөн сая, гурван зуун есөн мянга, хоёр зуун дөчин гурав/ төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 518,039,332,298.00 /таван зуун арван найман тэрбум, гучин есөн сая, гурван зуун гучин хоёр мянга, хоёр зуун ерэн найм/ төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал гэмт хэргийн улмаас учирсан хохирол 5 дахин, нөхөн төлүүлэлт 24.7 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 4.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Нийт учирсан хохирлын 47.3%-ийг нөхөн төлүүлж, хахуулийн 18,874,521,566 төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан байна.

Хүснэгт 8. Хохирол

Он	Учирсан хохирол	Мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн	Битүүмжлэн хамгаалсан
2019	12.1 их наяд	11.3 тэрбум	9.7 тэрбум
2020	12.1 их наяд	35.6 тэрбум	10.1 их наяд
2021	1.2 их наяд	96.2 тэрбум	119.5 тэрбум
2022	5.024 их наяд	2 их наяд	518 тэрбум

4. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил

Авлигатай тэмцэх газар нь улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих, авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг судлан авлигыг олон нийтэд мэдээлэх, судалгаанд суурилсан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг тасралтгүй гүйцэтгэж, үр дүнг тооцон ажиллаж байна.

НҮБ-ын Авлигын эсрэг конвенц батлагдсаны 20 жилийн ойг угтан “Дэлхий нийтээрээ авлигын эсрэг нэгдье” уриан дор “Авлигын эсрэг олон улсын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлсэн.

Энэхүү өдрийг тохиолдуулан их, дээд сургуулийн оюутнуудын дунд “Оюутны эрдэм шинжилгээний илтгэл, эссе бичлэгийн уралдаан”, хувийн хэвшлийн салбар, бизнес эрхлэгчид, мэргэжлийн холбоодын санал санаачилга, хүчин чармайлтыг идэвхжүүлэх, өргөжүүлэх, бизнесийн орчин дахь авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангах, бизнесийн ёс зүйг дээшлүүлэх зорилгоор “Бизнес ёс зүйг эрхэмлэнэ” уулзалт, “Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо”-той хамтран “Авлигын хор хөнөөл” сэдэвт гэрэл зургийн уралдаан, “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” фейсбүүк хуудсыг сурталчлах зорилгоор “Таны эрх, таны оролцоо-авлигад үгүй гэж хэлье” соён гэгээрүүлэх өдөрлөгийг Багануур, Налайх дүүрэгт болон Төв, Говьсүмбэр, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Орхон аймагт зохион байгуулав.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн 665 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр төрийн албаны хүнд суртал, чирэгдлийг арилгах ач холбогдолтой ажил болсон

талаар олон нийтэд сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэднийг татан оролцуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол, санал хүлээн авах, “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв фэйсбүүк” хуудсыг сурталчлах зорилгоор “Цахим хөгжил, харилцаа холбооны яам, E-Монголиа академитай хамтран “Хүнд сурталгүй цахим үйлчилгээ” өдөрлөг зохион байгуулсан.

Иргэдээс төрийн үйлчилгээний хүнд суртал, шат дамжлага бусад хүндрэлийн талаар мэдээлэл авах цахим цонхыг e-Mongolia системд байршуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах ажлын хүрээнд E-Mongolia платформ дээр contact@iaас.mn хаягт хандан авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол гаргах тусдаа талбар үүсгэн мэдээлэл хүлээн авах цонхны хөгжүүлэлтийг хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээний иргэд, олон нийттэй харилцах төвийн “11-11” тусгай утсаар төрийн байгууллагын хүнд суртал, авлигын шинж чанартай гомдол, мэдээллийг АТГ-ын 110 тусгай дугаарт шууд шилжүүлэн холбох ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулан ажилласан.

Авлигын нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд ухуулан таниулах ажлыг нийгмийн салбар, бүлэг тус бүрээр ангилан авч үзэж, тухайн салбар, бүлгийн онцлогт тохирсон агуулга, хэлбэрээр зохион байгууллаа. Авлигын эсрэг сурталчилгааг видео болон контент, онлайн телевиз, зурагт хуудас, брошюр, подкаст, үзүүлэн таниулах хуудас, авто стикер, номын сангийн үйлчилгээ, мэдээллийн самбар, видео болон цахим хичээл, тик ток цуврал, орон нутаг дахь сурталчилгаа, нийтийн тээвэр, сурталчилгаа, гудамжны самбар болон дэлгэцийн, цахилгаан шатны сурталчилгаа, түгээлтийн машинд сурталчилгаа, нийтлэл, нэвтрүүлэг зэрэг хэд хэдэн төрөл хэлбэрээр бэлтгэн, түгээсэн.

“Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” чиг үүргийн хүрээнд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулав. Үүнд: Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг ухуулан сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах зорилгоор “Түрийвч”, “Цахим хичээл” “Сонголт”, “Үйлийн үр хаяг андуурдаггүй юм”, “Ачлалт багш”, “Зохиолчид авлигын эсрэг”, “Уран зохиолоор дамжуулж нөлөөлөх нь”, “Түүний түүх” сэдэвт нийт 14 видео контентыг, мөн “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд 18 шторк, олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх, эерэг, зөв хандлагыг төлөвшүүлэх, түүнд уриалсан агуулга бүхий богино хэмжээний цуврал видео контент буюу “Тик Ток” 10 цувралыг бүтээж, Улаанбаатар хотын 7 байршилд 7 лед дэлгэцээр, R&P Entertainment TV, Оргил TV, Богц TV, Гэгээ TV, Дуу шүлэг TV, Сэдэв TV зэрэг онлайн телевизүүдээр дамжуулан олон нийтэд түгээх, сурталчлах ажлыг зохион байгуулсан.

Улаанбаатар хот, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг “Тэнгис”, “Гэгээнтэн”, “Prime cinema”, “Өргөө-1, 2, 3, Дархан-Уул, Орхон аймгийн салбар зэрэг нийт 9 кино театраар үйлчлүүлэгчдэд зөв дадал, шударга ёсыг хэвшүүлэх болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр видео шторк, богино хэмжээний контентыг толилуулсан.

Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн элсэлтийн бүртгэлийн үйл ажиллагааг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн 6 дүүргийн 20 сургууль, 9 цэцэрлэгийн элсэлт, түүнтэй холбогдох бусад үйл ажиллагаанд хяналт тавьж, сургууль, цэцэрлэгийн элсэлтийн үйл ажиллагаанд хамран сургах тойргийн бус хүүхдийг элсүүлэх явдлыг таслан зогсоох, авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж өгсөн.

Нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулагдсан хугацаат цэргийн албаны татлагын үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил, бусдад давуу байдал олгох нөхцөл гаргахаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн зөрчил гаргахгүй байх шаардлагаар тандалт хийж, тухайн ажиллагаанд оролцож байгаа албан хаагчдад мэдээлэл, сурталчилгаа хийсэн.

“Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудад “Шударга ёсны клуб” байгуулах санал санаачилга, үйл ажиллагааг дэмжсэнээр Нийслэлийн ерөнхий боловсролын 24, 12, 1, 40, 32, 84 дүгээр сургууль, Багануур дүүргийн ерөнхий боловсролын лаборатори цогцолбор сургууль, Хэнтий аймгийн Хэрлэн 2 дугаар сургууль, Тэмүүжин цогцолбор, Бор-Өндөр сумын цогцолбор сургуульд “Шударга ёсны клуб” байгуулан тус байгууллагаас клубийн үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч, сургалт, сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулж байна.

Батлан хамгаалах яамтай хамтран Зэвсэгт хүчний жанжин штабын тусгай хүчний командлалын харьяа 013, 084, 150, 350, 345 дугаар нэгтгэл ангиудын бие бүрэлдэхүүнд сургалт, соён гэгээрүүлэх өдөрлөг, Үндэсний Батлан хамгаалах Их сургууль, Дотоод хэргийн Их сургуультай хамтран “Таны эрх, таны оролцоо-өнөөдрийг маргаашийн бахархал болгоё” соён гэгээрүүлэх өдөрлөг, МУИС-ийн “Бизнесийн сургууль”, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн оюутнуудтай хамтран “Таны эрх, таны оролцоо”, “Залуучууд авлигыг тэвчихгүй” арга хэмжээг тус тус зохион байгуулсан.

5.Монгол Улсын Авлигын индекс

Транспэрэнси Интернэшнл олон улсын байгууллагаас жил бүр боловсруулдаг Авлигын төсөөллийн индексийн дүнгээр 180 улс орны авлигын төсөөллийн индексийг боловсруулжээ.

Манай улсын авлигын индексийн сүүлийн таван жилийн оноо:

2017 онд 36 оноо авч, 180 улсаас 103 дугаар байрт
2018 онд 37 оноо авч, 180 улсаас 93 дугаар байрт
2019 онд 35 оноо авч, 180 улсаас 106 дугаар байрт
2020 онд 35 оноо авч, 180 улсаас 111 дүгээр байрт
2021 онд 35 оноо авч, 180 улсаас 110 дугаар байрт
2022 онд 33 оноо авч, 180 улсаас 116 дугаар байрт

Индексийн дүнгээр Монгол Улс 2022 онд 33 оноо авч 180 улс орноос 116 дугаар байрт эрэмбэлэгдэж, 2021 онтой харьцуулахад 5 байраар ухарсан байна. Сүүлийн таван жилийн хугацаанд авлигын оноо буурч, индекс нэмэгдсэн 10 орны тоонд манай улс багтжээ.Тэгвэл дэлхийн улс орнуудын сүүлийн таван жилийн авлигын түвшнийг харьцуулахад ахиц дэвшил гараагүй байна.

Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан нийт улсын 95 хувийнх нь авлигын түвшин бага зэрэг буурсан. Зарим бүс нутагт авлигын түвшин өссөн үзүүлэлт гарсан бол Скандинавын улс оронд авлигын индекс бага болжээ.

Түүнчлэн авлигажсан улс оронд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэж чадахгүй байгааг судалгааны үр дүн харуулсан.

6.Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар авлигын гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан,



нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мөрдөгчийн мэдэгдэл бичиж, үр дүнг тооцон ажиллаж байна.

Мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, таслан зогсоох чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээтэй газар дээр нь танилцах, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал боловсруулах зорилгоор 18 байгууллагад ажиллаж, зөвлөмж, шаардлага хүргүүлсэн.

2022 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгахаар хуулийн этгээд, эрх бүхий албан тушаалтанд мөрдөгчийн 156 мэдэгдэл хүргүүлэн, 138 мэдэгдлийн хариуг хүлээн авсан. Мөн аж ахуй нэгж, байгууллага, албан тушаалтанд хууль хэрэгжүүлэх, зөрчил арилгуулах, авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахуулахаар 81 албан бичгийг хүргүүлэн холбогдох хариуг авч ажилласан. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хууль хэрэгжүүлэх, зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн тоо 20 буюу 32.8%-иар өссөн үзүүлэлттэй байна.

---oOo---



ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭ – FORENSIC

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ШИНЖИЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭ
3. ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ОРОЛЦСОН
БАЙДАЛ
4. САН БАЯЖУУЛАЛТ, АШИГЛАЛТЫН
СТАТИСТИК
5. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НИЙТЛЭГ АЖИЛ





1.Товч танилцуулга

Улсын Их Хуралаас Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталж, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд үйл ажиллагааг өргөжүүлж, Шүүх шинжилгээний ерөнхий газар байгуулагдсан.

Шүүх шинжилгээний байгууллага нь улсын хэмжээнд эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэх, түүнд үзлэг, үнэлгээ, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэгтэй ажилладаг.

Дээрх чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд “Шүүх шинжилгээ нь нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шинжлэх ухааны баталгаа болно” гэсэн зорилгыг дэвшүүлсэн ба дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана. Үүнд:

1. Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулж, олон улсын стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
2. Шинжилгээний лабораториудыг магадлан итгэмжлүүлж, орчин үеийн шаардлага хангасан техник, тоног төхөөрөмжөөр хангах;
3. Шинжээч нарыг гадаад, дотоодын урт, дунд, богино хугацааны сургалтад хамруулж, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлж ур чадварыг ахиулах, гадаад улс, орнуудын их, дээд сургууль болон холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах;
4. Үйлчилгээний соёлыг дээшлүүлж, иргэд, аж ахуйн нэгж, хууль хяналтын байгууллагуудад түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх.

Шүүх шинжилгээний байгууллага нь 2022 онд “Байгууллагын ажил үйлчилгээний чанарын түвшинг нэмэгдүүлж, цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бүх шатны удирдлагын манлайллыг дээшлүүлэх, сургалтын чанарыг сайжруулж, албан хаагчдын мэдлэг ур чадварыг ахиулах, албаны шуурхай бэлэн байдлыг хангаж, сахилга, ёс зүйг төлөвшүүлэх” зорилтыг дэвшүүлэн ажилласан ба өнөөдрийн байдлаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн баталсны дагуу 10 газар, 4 хэлтэс, 21 алба, 8 хэсэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.



Шүүх шинжилгээний тухай хуулийн 51.2-т “Шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүх шинжилгээний төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагаас бүрдэнэ” гэж тус байгууллагын зохион байгуулалтын бүтцийг заасантай уялдуулан Шүүх шинжилгээний ерөнхий газар нь Дарга, Тэргүүн дэд дарга, Дэд дарга гэсэн удирдлагатай байх бөгөөд дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй байна.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/216 дугаар тушаалаар Криминалистикийн шинжилгээний газрын харьяанд “Экологийн шинжилгээний лаборатори”-ийг шинээр байгуулан ажиллуулж эхэлсэн бөгөөд мөн сайдын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар Экологийн шинжилгээний лабораторийн статусыг шинжилгээний бие даасан үндсэн нэгж болгон өөрчлөн зохион байгуулсан бөгөөд аймаг, орон нутаг бүсчлэн хариуцах шинжээчийн орон тоог нэмэгдүүлсэн байна.



Зураг 1. Шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО





2. Шинжилгээний тоон мэдээ

Шүүх шинжилгээний байгууллага 2022 онд улсын хэмжээнд нийт 69201 шинжилгээ хийсэн байх ба үүнээс 41699 буюу 60.3%-ийг шүүх эмнэлгийн шинжилгээ, 18364 буюу 26.5%-ийг тусгай шинжилгээ, 8877 буюу 12.8%-ийг криминалистикийн шинжилгээ, 169 буюу 0.25%-ийг шүүх эдийн засгийн шинжилгээ, 92 буюу 0.15%-ийг экологийн шинжилгээ эзэлж байна.

Энэ нь өмнөх оны шинжилгээний статистик үзүүлэлтээс 10777 шинжилгээгээр их буюу 18.4%-иар өссөн үзүүлэлттэй байна. Нийт шинжилгээний 62.4%-ийг шүүх шинжилгээний төв байгууллага, 31.4%-ийг орон нутгийн шүүх шинжилгээний хэлтсүүд, 6.1%-ийг нийслэлийн шүүх шинжилгээний газрын хэргийн газрын үзлэгийн багууд хийжээ.

Хүснэгт 1. Улсын хэмжээнд шүүх шинжилгээний ерөнхий газарт хийгдсэн шинжилгээний тоон үзүүлэлт /сүүлийн 5 жил/

Шинжилгээний чиглэл, төрөл		2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Криминалистикийн шинжилгээ	Гарын мөр	9550	7499	6660	5384	5249
	Мөр судлал	1553	1740	1556	1394	1300
	Бичиг судлал, бичиг техник	906	1147	915	684	902
	Дүр зураг	72	53	37	15	21
	Галт зэвсэг	604	937	877	677	736
	Тэсрэх төхөөрөмж	2	6	13	2	6
	Дүрс бичлэг	251	237	244	243	204
	Авто техник	165	164	215	226	261
	Компьютер судлал	111	85	119	77	100
	Дуу авиа	28	24	23	15	17
	Материал судлал	32	52	5	40	48
	Бусад	19	17	29	9	33
		Бүгд	13293	11961	10693	8766
Тусгай шинжилгээ	Хими	6814	7524	6976	6931	8091
	Физик	210	238	249	133	150
	Биологи	6056	6560	6125	5977	6504
	ДНХ	1685	2046	2030	1757	2240
	Бактерлоги	1049	989	1062	1038	1379
		Бүгд	15814	17357	16442	15836
Шүүх эмнэлгийн шинжилгээ	Цогцост хийсэн шинжилгээ	4492	4659	4455	4561	5353
	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох	27493	27138	25919	22949	29010
	Хэргийн материалаар хийх	1430	1649	1504	1178	1401

	Хүний биед хийсэн бусад шинжилгээ /бэлгийн холбогдолтой, нас тогтоох/	1425	1575	1734	1686	2102
	Шарилд хийсэн шинжилгээ	26	24	17	11	10
	Гистологийн шинжилгээ	4913	5110	3345	3246	3823
	Бүгд	39779	40155	36974	33631	41699
Шүүх эдийн засгийн шинжилгээ	Татвартай холбоотой	20	9	11	7	
	НД-ын шимтгэлтэй холбоотой	21	3	14	8	
	Бэлэн мөнгөтэй холбоотой	53	64	75	51	61
	Эд хогшил, бараа	36	46	46	35	31
	Бусад зөрчил	13	30	20	16	14
	Буцсан	90	85	0	74	62
	Бүгд	233	237	260	191	169
Экологийн шинжилгээ	Мод	-	-	-	-	55
	Ургамал	-	-	-	-	8
	Амьтан	-	-	-	-	27
	Бусад	-	-	-	-	2
	Бүгд	-	-	-	-	92
Нийт		69119	69710	64369	58424	69201

График 1. Шүүх шинжилгээний ерөнхий газарт 2022 онд хийгдсэн нийт шинжилгээний тоо /шинжилгээний төрлөөр/




График 2. Шүүх шинжилгээний байгууллагад хийсэн нийт шинжилгээ /сүүлийн 5 жил/





График 3. Шинжилгээний тоон үзүүлэлт /сүүлийн 5 жил/



Хүснэгт 2. 2022 онд хийсэн шүүх шинжилгээ /аймаг, шинжилгээний төрлөөр/


№	Шинжилгээний газар, хэлтэс, алба	Нийт шинжилгээ	Шүүх эмнэлгийн шинжилгээ	Криминалистикийн шинжилгээ	Тусгай шинжилгээ	Эдийн засгийн шинжилгээ	Экологийн шинжилгээ
1	Архангай	961	573	95	293	-	-
2	Баян-Өлгий	1099	927	57	115	-	-
3	Баянхонгор	882	805	77	-	-	-
4	Булган	362	289	73	-	-	-
5	Говь-Алтай	637	396	24	217	-	-
6	Говьсүмбэр	276	273	3	-	-	-
7	Дархан-Уул	1773	1352	106	315	-	-
8	Дорноговь	979	880	99	-	-	-
9	Дорнод	1431	1013	120	298	-	-
10	Дундговь	499	425	74	-	-	-
11	Завхан	880	720	76	84	-	-
12	Орхон	1506	961	191	354	-	-
13	Өвөрхангай	1011	880	131	-	-	-
14	Өмнөговь	794	772	22	-	-	-
15	Сүхбаатар	795	652	66	77	-	-
16	Сэлэнгэ	1183	786	155	242	-	-
17	Төв	1665	1459	206	-	-	-
18	Увс	1054	759	63	232	-	-
19	Ховд	1550	1208	106	236	-	-
20	Хөвсгөл	1119	856	71	192	-	-
21	Хэнтий	1294	1040	254	-	-	-
22	НШШГ	4236	1014	3222	-	-	-
23	ШШЕГ	43123	23659	3586	15709	169	92
Бүгд		69201	41699	8877	18364	169	92

2.1.Криминалистикийн шинжилгээ

Шүүх шинжилгээний байгууллага 2022 онд криминалистикийн шинжилгээний 54935 объектод, 8877 шинжилгээ хийсэн бөгөөд 3586 буюу 40.4%-ийг Нийслэлийн шүүх шинжилгээний газрын Криминалистикийн шинжилгээний хэлтэст, 322 буюу 36.3%-ийг Нийслэлийн шүүх шинжилгээний газрын Хэргийн газрын үзлэгийн багт, 2069 буюу 23.3%-ийг Аймгийн шүүх шинжилгээний хэлтсийн криминалистикийн лабораторид хийсэн байна. Үүнийг хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 8012, иргэний 456, захиргааны 360, зөрчлийн 49 хэрэг эзэлж байна.

Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 241, мөрдөгч, прокурорын тогтоолоор 8521, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны хүсэлтээр 115 шинжилгээ хийсэн.

График 4. Криминалистикийн шинжилгээ



Хүснэгт 3. 2022 оны Криминалистикийн шинжилгээний тоо /шинжилгээний төрөл, аймаар/

№	Аймаг	Нийт шинжилгээ	Шинжилгээний төрөл											
			Гарын мөр	Мөр судлал	Баримт бичиг	Галт зэвсэг	Тэсрэх төхөөрөмж	Дүр зураг	Дүрс бичлэг	Авто техник	Компьютер	Дуу авиа	Материал судлал	Бусад
1	Архангай	95	46	18	31	-	-	-	-	-	-	-	-	-
2	Баян-Өлгий	57	12	28	16	1	-	-	-	-	-	-	-	-
3	Баянхонгор	77	52	16	8	1	-	-	-	-	-	-	-	-
4	Булган	73	53	17	2	-	-	-	-	1	-	-	-	-
5	Говь-Алтай	24	7	8	3	6	-	-	-	-	-	-	-	-
6	Говьсүмбэр	3	1	2	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Дархан-Уул	106	44	45	17	-	-	-	-	-	-	-	-	-
8	Дорноговь	99	80	19	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Дорнод	120	95	24	1	-	-	-	-	-	-	-	-	-
10	Дундговь	74	68	4	2	-	-	-	-	-	-	-	-	-
11	Завхан	76	33	39	3	1	-	-	-	-	-	-	-	-
12	Орхон	191	144	36	11	-	-	-	-	-	-	-	-	-
13	Өвөрхангай	131	103	23	3	2	-	-	-	-	-	-	-	-
14	Өмнөговь	22	15	5	1	1	-	-	-	-	-	-	-	-
15	Сүхбаатар	66	53	9	2	2	-	-	-	-	-	-	-	-
16	Сэлэнгэ	155	128	22	5	-	-	-	-	-	-	-	-	-
17	Төв	206	197	9	-	-	-	-	-	-	-	-	-	-
18	Увс	63	30	20	10	3	-	-	-	-	-	-	-	-
19	Ховд	106	60	27	13	5	1	-	-	-	-	-	-	-
20	Хөвсгөл	71	41	18	10	2	-	-	-	-	-	-	-	-
21	Хэнтий	254	217	27	7	3	-	-	-	-	-	-	-	-
22	КШХ	3586	571	873	745	709	5	21	204	260	100	17	48	33
23	НШШГазар	3222	3199	11	12	-	-	-	-	-	-	-	-	-
Бүгд		8877	5249	1300	902	736	6	21	204	261	100	17	48	33

2.2. Шүүх эмнэлгийн шинжилгээ

Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд шүүх эмнэлгийн **41699** шинжилгээ хийсэн бөгөөд энэ нь өмнөх оныхоос 8068 шинжилгээгээр их буюу 24%-иар өссөн үзүүлэлттэй байна. Эдгээрийн 31112 буюу 74.6% нь хүний биед хийсэн шинжилгээ, 9186 буюу 22% нь цогцос болон шарилд хийсэн шинжилгээ /үүний 41.6% нь эд эсийн шинжилгээ/, 1401 буюу 3.4% нь хэргийн материалаар хийсэн шинжилгээ эзэлж байна.


Шүүх эмнэлгийн нийт шинжилгээний 23659 буюу 56.8%-ийг Шүүх анагаах ухааны шинжилгээний хэлтэст, 1014 буюу 2.4%-ийг Нийслэлийн шүүх шинжилгээний газарт, 17026 буюу 40.8%-ийг аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст тус тус хийжээ. Үүнийг хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 33126, иргэний 147, зөрчлийн 4603 хэрэг эзэлж байна.

Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 71, мөрдөгч, прокурорын тогтоолоор 35216, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны хүсэлтээр 2589 шинжилгээ хийсэн.

Хүснэгт 4. Шүүх шинжилгээний байгууллагад хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээ

Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Шүүх эмнэлгийн цогцос шинжилгээ	5353
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	29010
Хүний биед хийсэн бусад шинжилгээ /бэлгийн холбогдолтой, нас тогтоох/	2102
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	1401
Эксгумаци	10
Эд эсийн шинжилгээ	3823
НИЙТ	41699

График 5. Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээ /төрлөөр/



Хүснэгт 5. Шүүх эмнэлгийн шинжилгээ /шинжилгээний төрөл, аймгаар/

№	Шинжилгээний алба	Нийт шинжилгээ	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	Хүний биед хийсэн бусад шинжилгээ	Цогцост хийсэн шинжилгээ	Эксгумац	Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	Гистологи
1	Архангай	573	434	20	107	-	12	-
2	Баян-Өлгий	927	858	21	46	2	-	-
3	Баянхонгор	805	597	69	106	-	33	-
4	Булган	289	179	32	76	-	2	-
5	Говь-Алтай	396	314	24	58	-	-	-
6	Говьсүмбэр	273	236	6	31	-	-	-
7	Дархан-Уул	1352	1139	36	152	-	2	23
8	Дорноговь	880	744	30	106	-	-	-
9	Дорнод	1013	711	41	127	-	20	114
10	Дундговь	425	319	17	68	-	21	-
11	Завхан	720	578	28	91	-	-	23
12	Орхон	961	718	72	149	1	21	-
13	Өвөрхангай	880	707	42	131	-	0	-
14	Өмнөговь	772	538	35	171	-	22	6
15	Сүхбаатар	652	559	42	51	-	-	-
16	Сэлэнгэ	786	623	9	154	-	-	-
17	Төв	1459	805	22	245	-	142	245
18	Увс	759	555	21	86	-	8	89
19	Ховд	1208	976	55	74	-	30	73
20	Хөвсгөл	856	556	68	232	-	-	-
21	Хэнтий	1040	825	50	156	-	9	-
22	ШЭШГ	23659	15189	1337	2810	7	1066	3250
23	НШШГ	1014	850	25	126	-	13	-
24	Бүгд	41699	29010	2102	5353	10	1401	3823

Шүүх шинжилгээний байгууллагад сүүлийн 7 жилд хийгдсэн нийт шинжилгээний 58.2%-г шүүх эмнэлгийн шинжилгээ дангаараа эзэлж байна.

Хүснэгт 6. Улсын хэмжээнд хийсэн нийт шинжилгээ /сүүлийн 7 жилээр/


Он	Нийт хийсэн шинжилгээний тоо	Шүүх эмнэлгийн шинжилгээний тоо	Шүүх эмнэлгийн шинжилгээний эзлэх хувь
2016	68525	40423	59%
2017	65525	38090	58,1%
2018	68424	39084	57,1%
2019	69710	40155	57,6%
2020	64369	36974	57,4%
2021	58424	33631	57,6%
2022	69201	41699	60,3%

2.3. Эдийн засгийн шинжилгээ

Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн дагуу эдийн засгийн 169 хэрэг хүлээн авснаас 28 аж ахуйн нэгж, байгууллага, 89 иргэдэд холбогдох өмчийн болон татварын маргаантай хавтаст хэрэг, санхүүгийн баримт материалд шинжилгээ хийж, 2.436.445.694 төгрөг, 932.495.668 валютын хохирлын хэмжээ, шалтгааныг тогтоож, шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Үүнийг хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 131, иргэний 23, захиргааны 15 хэрэг эзэлж байна. Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 41, мөрдөгч, прокурорын тогтоолоор 127, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр 1 шинжилгээ хийсэн.

Үүнээс 107 шинжилгээний дүгнэлт гаргасан бөгөөд шинжээч томилох эрх бүхий этгээдийн хүсэлтээр, санхүүгийн баримт ирүүлээгүй, эрх бүхий байгууллагын акт дүгнэлт гараагүй зэрэг шалтгаанаар 61 шинжилгээ буцсан байна.

График 6. Эдийн засгийн шинжилгээ хэргийн төрлөөр



2.4. Тусгай шинжилгээ


Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд тусгай шинжилгээний чиглэлээр нийт 38730 объекттой, 18364 шинжилгээ хийснийг өмнөх жилтэй харьцуулахад 2528 шинжилгээгээр их буюу 15.9%-иар өссөн байна. Нийт шинжилгээний 85.5%-ийг тусгай шинжилгээний газарт, 14.5%-ийг аймгуудын шүүх шинжилгээний хэлтсүүдэд хийгджээ.

Тус онд тусгай шинжилгээний чиглэлээр хийгдсэн нийт шинжилгээний 8091 буюу 44.1%-ийг химийн шинжилгээ, 6504 буюу 35.4%-ийг биологийн шинжилгээ, 2240 буюу 12.2%-ийг ДНХ-ийн шинжилгээ, 1379 буюу 7.5%-ийг бактериологийн шинжилгээ, 150 буюу 0.8%-ийг физикийн шинжилгээ тус тус эзэлж байна. Үүнийг хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 17515, иргэний 575, зөрчлийн 274 хэрэг эзэлж байна. Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 552, мөрдөгч, прокурорын тогтоолоор 8058, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны хүсэлтээр 93, тогтоолыг үндэслэж ирүүлсэн шинжээч эмчийн илгээх бичгээр 9661 шинжилгээ хийсэн.

Тусгай шинжилгээний хэлтсийн шинжээчид хэргийн газрын үзлэгт 512 удаа оролцож, 29 ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, “ДНХ-ийн мэдээллийн сан”-г 1236 хүний мэдээллээр баяжуулсан байна.

Шүүх шинжилгээний байгууллагын ДНХ-ийн шинжилгээний лабораторид өнөөдрийн байдлаар хорих ангид ял эдэлж буй хоригдол, өршөөлийн хуулиар суллагдсан ялтан, орон гэргүй тэнэмэл, захиргааны хяналтад байгаа зэрэг нийт 17800 орчим хүний генетикийн дээж хадгалагдаж байна.

График 7. Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд хийгдсэн тусгай шинжилгээ /хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ/



Хүснэгт 7. Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд хийгдсэн тусгай шинжилгээ /шинжилгээний төрөл, аймаг/


№	Аймаг	Нийт шинжилгээ	Шинжилгээний төрөл				
			Хими	Физик	Биологи	ДНХ	Бактериологи
1	Архангай	293	184	-	109	-	-
2	Баян-Өлгий	115	115	-	-	-	-
3	Баянхонгор	-	-	-	-	-	-
4	Булган	-	-	-	-	-	-
5	Говь-Алтай	217	173	-	44	-	-
6	Говьсүмбэр	-	-	-	-	-	-
7	Дархан-Уул	315	159	-	156	-	-
8	Дорноговь	-	-	-	-	-	-
9	Дорнод	298	189	-	109	-	-
10	Дундговь	-	-	-	-	-	-
11	Завхан	84	84	-	-	-	-
12	Орхон	354	281	-	73	-	-
13	Өвөрхангай	-	-	-	-	-	-
14	Өмнөговь	-	-	-	-	-	-
15	Сүхбаатар	77	77	-	-	-	-
16	Сэлэнгэ	242	159	-	83	-	-
17	Төв	-	-	-	-	-	-
18	Увс	232	139	-	93	-	-
19	Ховд	236	182	-	54	-	-
20	Хөвсгөл	192	192	-	-	-	-
21	Хэнтий	-	-	-	-	-	-
22	ТШГ	15709	6157	150	5783	2240	1379
Бүгд		18364	8091	150	6504	2240	1379

2.5. Экологийн шинжилгээ

Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд мөрдөгч, прокурорын тогтоолоор эрүүгийн хэрэгт 53176 шинжилгээний объекттой, модны 55, ургамлын 8, амьтны 27, бусад 2, нийт эрүүгийн хэрэгт холбогдох экологийн 92 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна. Мөн тогтоолыг үндэслэн модны шинжилгээний объектыг 18 ширхэг гэрэл зургийн хамт хүлээн авч,

48957 ширхэг модны 13.872.847.176 төгрөгөөр тооцогдох экологи-эдийн засгийн үнэлгээг дүгнэлтээр гаргасан.

График 8. Экологийн шинжилгээ эрүүгийн хэргийн төрлөөр



3.Хэргийн газрын үзлэгт оролцсон байдал

Шүүх шинжилгээний байгууллагын криминалистикийн шинжээчид 2022 онд нийт 26596 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон бөгөөд үүнийг өмнөх онтой харьцуулахад 4643 буюу 21.4%-иар өссөн байна.


Криминалистикийн шинжилгээний газрын шинжээчид 55, Нийслэлийн шүүх шинжилгээний газрын криминалистикийн шинжээчид 18617, аймгуудын шүүх шинжилгээний хэлтсийн криминалистикийн шинжээчид 7924 удаа хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцжээ.

Хэргийн газрын үзлэг, шинжилгээний явц, байдлыг гэрэл зургаар бэхжүүлэн авсан ба хэргийн газрын үзлэгийн 356902, шинжилгээний 67001, цогцосны үзлэг, задлан шинжилгээний 112346, бусад 261280, нийт 797529 гэрэл зураг авч, үзлэг, шинжилгээний баримтад хавсаргасан байна.

Хүснэгт 8. Хэргийн газрын үзлэг хэргийн өнгөөр

д/д	Хэргийн өнгө	Хэргийн тоо
1	Хүний амь нас хохирсон	5733
2	Хулгайлах	7635
3	Дээрэмдэх	433
4	Зам тээврийн осол	4599
5	Бусад	8196
	Нийт	26596

График 9. Хэргийн газрын үзлэг хэргийн өнгөөр



Хүснэгт 9. 2022 онд хэргийн газрын үзлэгт оролцсон байдал /хэргийн өнгө, аймаар/


№	Аймаг	Нийт хэргийн газрын үзлэг	Хэргийн өнгө				
			Хүний амь нас хохирсон	Хулгайлах	Дээрэмдэх	Зам тээврийн осол	Бусад
1	Архангай	212	108	46	-	40	18
2	Баян-Өлгий	338	36	59	3	110	130
3	Баянхонгор	368	103	109	1	100	55
4	Булган	256	110	55	-	36	55
5	Говь-Алтай	228	58	16	-	80	74
6	Говьсүмбэр	156	30	23	1	28	74
7	Дархан-Уул	468	140	67	-	141	120
8	Дорноговь	526	145	112	5	124	140
9	Дорнод	482	140	167	2	83	90
10	Дундговь	263	70	62	-	96	35
11	Завхан	365	86	56	-	93	130
12	Орхон	489	119	189	2	27	152
13	Өвөрхангай	348	132	85	4	82	45
14	Өмнөговь	413	166	100	2	88	57
15	Сүхбаатар	261	59	84	-	54	64
16	Сэлэнгэ	612	231	77	1	161	142
17	Төв	513	243	74	6	140	50
18	Увс	343	91	73	-	70	109
19	Ховд	354	77	98	-	115	64
20	Хөвсгөл	389	222	90	1	41	35
21	Хэнтий	540	165	97	-	186	92
22	НШШГ	18617	3182	5891	398	2704	6442
23	КШГ	55	20	5	7	-	23
Бүгд		26593	5733	7635	433	4599	8196

Хэргийн газрын үзлэгээр нийт 64897 ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлсэн ба хэргийн газрын үзлэгийн 356902, шинжилгээний 67001, цогцосны үзлэг, задлан шинжилгээний 112346, бусад 261280 зураг буюу нийт 797529 гэрэл зургаар үзлэг шинжилгээний явцыг бэхжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 10. Хэргийн газраас илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт төрлөөр

д/д	Илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт	Ул мөр, эд мөрийн баримтын тоо
1	Гарын мөр	16613
2	Гутлын мөр	4058
3	Тээврийн хэрэгслийн мөр	4266
4	Бичил мөр	80
5	Эвдлэгч багаж хэрэгслийн мөр	1580
6	Биологийн гаралтай ул мөр	3464
7	Бусад ул мөр, эд мөрийн баримт	34836
	Нийт	64897

График 10. Хэргийн газраас илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт төрлөөр



Хүснэгт 11. 2022 онд хэргийн газрын үзлэгээр илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт /аймаг тус бүрээр/

№	Аймаг	Нийт ул мөр, эд мөрийн баримт	Ул мөр, эд мөрийн баримт						
			Гарын мөр	Гутлын мөр	Тээврийн хэрэгслийн мөр	Бичил мөр	Эвдлэгч багаж, хэрэгслийн мөр	Биологийн гаралтай ул мөр	Бусад ул мөр, эд мөрийн баримт
1	Архангай	1198	326	136	349	-	68	42	277
2	Баян-Өлгий	1014	86	71	84	1	6	60	706
3	Баянхонгор	1416	650	151	257	-	31	48	279
4	Булган	611	87	52	129	-	28	59	256
5	Говь-Алтай	340	9	27	188	-	4	15	97
6	Говьсүмбэр	176	33	18	43	16	4	12	50
7	Дархан-Уул	641	152	55	35	-	-	8	391
8	Дорноговь	642	152	74	110	-	6	93	207
9	Дорнод	843	312	130	189	-	6	51	155
10	Дундговь	713	227	56	200	-	28	59	143
11	Завхан	813	133	106	112	-	8	46	408
12	Орхон	1846	925	166	18	2	27	335	373
13	Өвөрхангай	1150	263	88	234	21	55	93	396
14	Өмнөговь	543	221	92	95	-	15	21	99
15	Сүхбаатар	676	127	96	155	-	16	31	251
16	Сэлэнгэ	707	200	77	130	-	-	62	238
17	Төв	1307	271	50	294	-	39	204	449
18	Увс	447	125	40	106	-	-	-	176
19	Ховд	1760	355	129	207	7	11	84	967
20	Хөвсгөл	826	86	151	118	-	23	92	356
21	Хэнтий	2440	380	164	450	2	80	309	1055
22	НШШГ	43955	11117	2062	759	31	1125	1724	27137
23	КШГ	833	376	67	4	-	-	16	370
Бүгд		64897	16613	4058	4266	80	1580	3464	34836


4. Сан баяжуулалт, ашиглалтын статистик

Шүүх шинжилгээний байгууллага нь галт зэвсгийн хонгио хошууны Арсенал болон гарын мөр, дардасны Папилон сан, ДНХ-ийн мэдээллийн санг үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд 2022 онд галт зэвсгийн Арсенал санг 4109 сумны хонгионы мөрөөр, 3669 сумны хошууны мөрөөр буюу нийт 7778 мөрөөр баяжуулсан.

Мөн гарын мөр, дардасны Папилон санг 35853 гарын дардсаар, 8680 гарын мөрөөр буюу нийт 44533 мөр, дардсаар, “ДНХ-ийн мэдээллийн сан”-г 1236 хүний мэдээллээр баяжуулж гэмт хэрэг илрүүлэх чиглэлээр үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нийслэлийн Засаг даргын 627 дугаар захирамжаар баталсан “Эзэнгүй цогцос оршуулах журам”, 2013 оны А/117 дугаар захирамжаар баталсан “Захирамжид өөрчлөлт оруулах журам”-ыг тус тус үндэслэн тус хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын цогцос хадгалах байранд хадгалагдаж байгаа хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй 91 цогцсыг холбогдох журмын дагуу оршуулсан.

График 11,12. 2022 оны сангийн баяжуулалт /Арсенал, Папилон/



Хүснэгт 12. 2022 оны сан баяжуулалт, ашиглалтын статистик /аймаг тус бүрээр/

№	Аймаг	Арсенал			Папилон		
		Сумны хонгио	Сумны хошуу	Нийт	Гарын мөр	Гарын дардас	Нийт
1	Архангай	-	-	-	55	419	474
2	Баян-Өлгий	-	-	-	14	401	415
3	Баянхонгор	25	-	25	241	676	917
4	Булган	-	-	-	20	459	479
5	Говь-Алтай	2	1	3	7	544	551
6	Говьсүмбэр	-	-	-	-	161	161
7	Дархан-Уул	4	2	6	64	815	879
8	Дорноговь	-	-	-	69	1297	1366
9	Дорнод	3	3	6	125	1090	1215
10	Дундговь	4	-	4	79	362	441
11	Завхан	57	4	61	84	434	518
12	Орхон	78	76	154	464	793	1257
13	Өвөрхангай	6	3	9	101	272	373
14	Өмнөговь	2	2	4	184	1077	1261

15	Сүхбаатар	166	24	190	78	1089	1167
16	Сэлэнгэ	16	9	25	87	2159	2246
17	Төв	-	-	-	86	709	795
18	Увс	2	2	4	32	942	974
19	Ховд	44	34	78	148	449	597
20	Хөвсгөл	15	8	23	48	604	652
21	Хэнтий	4	-	4	135	1194	1329
22	НШШГ	-	-	-	5720	15576	21296
23	КШГ	3681	3501	7182	839	4331	5170
Бүгд		4109	3669	7778	8680	35853	44533

5.2022 онд зохион байгуулсан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой бусад ажил, онцлог үр дүн

Шүүх шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангах, криминалистик, тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулан, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлж, Олон Улсын стандартад нийцүүлэн техник, технологи, тоног төхөөрөмжөөр ханган, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулах зорилгоор БНСУ-ын “Эксим банк”-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл” болон “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар “Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд шүүх шинжилгээний байгууллагын шинжилгээний лабораториудад засвар, үйлчилгээ хийх, стандартад нийцүүлэн шинэчлэн тоноглох, шинжилгээний лабораториудыг шинээр байгуулах, шинжээчдийг урт, богино хугацааны сургалтад хамруулах, БНСУ-ын шинжээч, мэргэжилтнүүдийг урьж сургалт зохион байгуулах зэрэг ажлыг үе шаттайгаар амжилттай зохион байгуулж байна.

2022 онд Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт 92.0 сая төгрөгийн өртөг бүхий “Зөөврийн дижитал рентген аппарат”, Физикийн шинжилгээний лабораторид натригаас уран хүртэлх химийн элементийг тодорхойлдог, нэг удаад 16 дээж хэмжих хүчин чадалтай 199.7 сая төгрөгийн өртөг бүхий “EDX-7200” маркийн рентген спектрометр, мөн экологийн үзлэг шинжилгээ хийхэд шаардлагатай 216.2 сая төгрөгийн өртөг бүхий нийт 23 нэр төрлийн техник, тоног төхөөрөмжийг тус тус худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн ГХУСАЗЗ-ийн санхүүжилтээр Биологийн шинжилгээний лабораторид “Olympus” DX-53 маркийн 3 ширхэг микроскопыг худалдан авч шинжилгээ хийж байна.

---o0o---

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ – CRIMINAL DAMAGE

1. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИК
2. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИК
3. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИК
4. ШҮҮХИЙН СТАТИСТИК
5. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ, ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ




ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ (2022)

НИЙТ ХОХИРОГЧ

35220 +40.9%

НИЙСЛЭЛД **23908** +16.3%

ОРОН НУТАГТ **11312** +5.0%



ХҮҮХЭД **2014** +47.5%

УЧИРСАН ХОХИРОЛ

347900.1 САЯ

НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН

183243.9 САЯ

ХУВЬ

52.7% +5.1%



НАС БАРСАН

766 +12.2%



ГЭМТСЭН

10310 +24.2%

Гэмт хэргийн хохирол

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт болон Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт "...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх" эрхийг баталгаажуулж, энэхүү эрхийг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд гэмт хэргийн хохирол, хор уршгийн ялгааг нарийвчлан тодорхойлсон нь оновчтой болсон төдийгүй, эрүүгийн эрх зүйн онол, хууль зүйн практикт ч чухал ач холбогдолтой.

Гэмт хэргийн хохирол, хор уршгийг шударгаар барагдуулах нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх төдийгүй, нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй үр нөлөөтэй тэмцэхэд чухал нөлөөтэй. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон бие махбод, сэтгэл санааны хохирол өнөөдөр зөвхөн гэмт хэргийн хохирогч гэлтгүй улс, нийгэм, эдийн засагт ноцтой хор уршиг учруулж байна.

Хохирол, хор уршгийг тогтоох, тодорхойлох, мөнгөн дүнгээр илэрхийлж, үнэлэх ажиллагаа одоо ч хуучин арга барилаар явагдаж, хохирол нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг нөхөн сэргээх явдал хангалтгүй байна гэх шүүмжлэл хэргийн оролцогч нараас гарсаар байна.

Хэдийгээр Эрүүгийн хуулийн "Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, хохирлоо нөхөн төлсөн этгээдийг ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэх" эрх зүйн зохицуулалтын нөлөөгөөр хохирол нөхөн төлүүлэх байдалд зарим нэг ахиц гарсан боловч илүү боловсронгуй болгох шаардлагатай байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал" (Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power) баталсан нь дэлхийн улсуудад өөр өөрсдийн онцлогт тохирсон хохирогч судлалын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болсон байна³.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр шинэчлэн найруулсан "Засгийн газрын тусгай сангийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан"⁴-г бий болгож, хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдох бөгөөд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээр санд буцаан төвлөрүүлэхээр хуульчилсан.

Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл /Хүнийг алах/, 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/, 13.2 дугаар зүйл /Хүн хулгайлах/, 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 13.4 дүгээр зүйл /Хүнийг хүчээр алга болгох/, 15.3 дугаар зүйл /Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /Хууль бусаар үр хөндөх/, 16.1 дүгээр зүйл /Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 16.3 дугаар зүйл /Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /Хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /Хүүхэдтэй хэрцгий харьцах/, 16.11 дүгээр зүйл /Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 19.3 дугаар зүйл /Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 29.1 дүгээр зүйл /Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/-д заасан гэмт

³ <https://legal.un.org/avl/ha/dbpjvcap/dbpjvcap.html>

⁴ "Засгийн газрын нөөц сангийн тухай хууль" шинэчилсэн найруулга, 2019
<https://www.legalinfo.mn/>



хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дараах хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна” гэж ялгамжтай байхаар зааж өгсөн. Дээрх хуулийн заалтаас харахад хүний амь нас, эрүүл мэндэд хүч хэрэглэж үйлдсэн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгож байхаар хуульчилсан ч процессын нарийн зохицуулалт тодорхой бус байна.

Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт “Шинжилгээний байгууллага Эрүүгийн хуулийн Аравдугаар бүлэг/Хүний амьд явах эрхийн эсрэг/, Арван нэгдүгээр бүлэг/Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг/, Арван хоёрдугаар бүлэг/Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг/, Арван гуравдугаар бүлэг/Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг/, 14.1 дүгээр зүйл /Ялгаварлан гадуурхах/, 14.2 дугаар зүйл /Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах/, 14.3 дугаар зүйл /Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах/, 14.4 дүгээр зүйл /Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах/, 14.8 дугаар зүйл /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/, Арван тавдугаар бүлэг/Эрүүл мэндийн эсрэг/, Арван зургадугаар бүлэг/Хүүхдийн эсрэг/, 17.1 дүгээр зүйл /Хулгайлах/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 17.3 дугаар зүйл /Залилах/, 17.6 дугаар зүйл /Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх/, 17.8 дугаар зүйл /Эд хөрөнгө устгах, гэмтээх/, 17.10 дугаар зүйл /Нотариатч, улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих/, 17.12 дугаар зүйл /Мал хулгайлах/, 20.11 дүгээр зүйл /Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях/, 20.12 дугаар зүйл /Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх/, 20.13 дугаар зүйл /Чанар муутай барилга байгууламж ашиглалтад оруулах/, 20.14 дүгээр зүйл /Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх/, 20.16 дугаар зүйл /Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах/, 21.5 дугаар зүйл /Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 21.13 дугаар зүйл /Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих/, 24.1 дүгээр зүйл /Байгаль орчныг бохирдуулах/, 24.3 дугаар зүйл /Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах/, 24.7 дугаар зүйл /Ой, хээрийн түймэр тавих/, 27.3 дугаар зүйл /Төмөр замын, агаарын, усан замын тээврийн хөдөлгөөний ба ашиглалтын аюулгүй байдлын журам зөрчих/, 27.7 дугаар зүйл /Агаарын хөдөлгөөний аюулгүй байдалд халдах/, 27.8 дугаар зүйл /Агаарын хөлгийг авч зугтаах/, 27.10 дугаар зүйл /Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих/, 28.3 дугаар зүйл /Дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх/, 28.4 дүгээр зүйл /Бие биедээ захирагдахгүй цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих/, 28.10 дугаар зүйл /Байлдааны машин жолоодох, ашиглалтын журам зөрчих/, 28.11 дүгээр зүйл /Байлдааны, сургуулийн нислэг хийх, түүнд бэлтгэх журам зөрчих/, 29.4 дүгээр зүйл /Дайны үед хориглосон арга, хэрэгсэл хэрэглэх/, 29.5 дугаар зүйл /Төрлөөр устгах/, 29.7 дугаар зүйл /Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах/, 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/-д заасан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргана.” гэж хуульчилсан. Гэтэл гэмт хэргийн улмаас бусдын сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлж, үнэлж байгаа шүүхийн практик хангалтгүй байна. Сэтгэл санааны хохирлыг үнэлэх, үнэлгээжүүлэх, тооцох аргачлал байхгүй учир гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг иргэний нэхэмжлэл гаргах замаар эрүүгийн болон иргэний шүүхийн шатанд нөхөн төлүүлэх боломжгүй байна.


Шүүх шинжилгээний тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.6 дахь хэсэгт “Сэтгэцэд учирсан хор уршгийг үнэлэх, хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгуулахтай холбоотой Шүүх шинжилгээний тухай хууль болон дагалдах бусад хуулийн зохицуулалтыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж хуульчилсан нь сэтгэл санаа, нэр төр, алдар хүндэд учирсан хохиролд үнэлгээ хийх, хохирлыг тогтоох аргачлал удахгүй гарч, мөрдөгдөх эрх зүйн орчин шинээр бий болоод байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн талаар шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагуудын статистик мэдээллийг нэгтгэлээ.

1.Цагдаагийн байгууллагын статистик


Улсын хэмжээнд 2022 онд үйлдсэн гэмт хэргийн улмаас 35220 хүн, 87 хуулийн этгээд хохирч, үүнээс 766 хүн нас барж, 10310 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 10226 буюу 40.9%-иар, гэмтсэн хүн 2011 буюу 24.2%-иар, нас барсан хүн 83 буюу 12.2%-иар тус тус өссөн байна.

График 1. Хохирсон хүн, хуулийн этгээдийн байдал /өмнөх оны мөн үетэй харьцуулбал/



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 347900.1 сая төгрөгийн хохирлын 183243.9 сая төгрөг буюу 52.7%-ийг нөхөн төлүүлж, 5695.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 167526.2 сая төгрөг буюу 92.9%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 92841.1 сая төгрөг буюу 2.0 дахин тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 846.2 сая төгрөг буюу 12.9%-иар буурсан байна.

График 2. Нийт хохирол, нөхөн төлүүлсэн байдал /өмнөх оны мөн үетэй харьцуулбал/



Орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2022 оны байдлаар 11312 иргэн, 31 хуулийн этгээд хохирч, үүнээс 434 хүн нас барж, 4179 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 2391 буюу 26.8%-иар, гэмтсэн хүн 557 буюу 15.4%-иар, нас барсан хүн 90 буюу 26.2%-иар, хуулийн этгээд 4 буюу 14.8%-иар тус тус өссөн байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 63640.9 сая төгрөгийн хохирлын 25443.5 сая төгрөг буюу 40.0%-ийг нөхөн төлүүлж, 4484.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 33452.9 сая төгрөг буюу 2.1 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 9072.9 сая төгрөг буюу 55.4%-иар, битүүмжилсэн хөрөнгө 1470.3 сая төгрөг буюу 48.8%-иар тус тус өссөн байна.

Харин нийслэл, дүүргүүдэд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2022 оны байдлаар 23899 иргэн, 56 хуулийн этгээд хохирч, үүнээс 332 хүн нас барж, 6128 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 7839 буюу 48.8%-иар, хохирсон хуулийн этгээд 24 буюу 75.0%-иар, гэмтсэн хүн 1451 буюу 31.0%-иар тус тус өсөж, нас барсан хүн 7 буюу 2.1%-иар буурсан байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 284052.9 сая төгрөгийн хохирлын 55.5%-ийг нөхөн төлүүлж, 1210.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 134740.3 сая төгрөг буюу 90.2%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 83756.9 буюу 2.1 дахин тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 2316.5 сая төгрөг буюу 65.7%-иар буурсан байна.

Энэхүү тоон мэдээллийг дараах хүснэгтээр өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулж харуулав.

Хүснэгт 1. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

№	Бүс	Аймаг, нийслэл, дүүрэг	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол												
			Хохирсон			Гэмтсэн хүн		Нас барсан хүн		Нийт хохирлын хэмжээ /сая.төг/		Нөхөн төлүүлсэн /сая.төг/		Битүүмжилсэн хэмжээ /сая.төг/	
			Иргэн	Хуулийн этгээд	Гэмтсэн хүн	Нас барсан хүн	Нийт хохирлын хэмжээ /сая.төг/	Нөхөн төлүүлсэн /сая.төг/	Битүүмжилсэн хэмжээ /сая.төг/						
1	Орон нутаг		8921	11312	31	3622	4179	344	434	30188.0	63640.9	16370.6	25443.5	3014.3	4484.6
2	Баруун бүс	Баян-Өлгий	198	317	3	68	109	12	8	761.8	1329.3	646.8	1038.2	93.4	288.1
3		Говь-Алтай	238	247	-	94	82	8	9	756.8	681.8	437.4	570.9	93.9	117.5
4		Завхан	385	422	1	140	157	13	22	1951.3	2694.5	1031.5	1836.2	370.6	519.7
5		Увс	245	292	1	74	117	10	11	944.6	1101.7	649.0	753.7	216.3	57.6
6		Ховд	403	556	1	162	211	16	20	862.6	1876.0	491.5	1095.5	45.4	33.5
7		Архангай	416	555	-	148	178	22	19	1350.5	1518.5	760.6	858.8	42.4	81.9
8	Хангайн бүс	Баянхонгор	433	443	-	196	173	14	17	681.8	756.8	570.9	437.4	117.5	93.9
9		Булган	402	464	-	131	143	29	27	2718.9	1705.2	826.5	839.2	371.4	127.4
10		Орхон	491	741	-	238	276	18	19	1321.3	1720.6	546.8	962.9	44.9	149.8
11		Өвөрхангай	455	712	2	181	221	16	33	725.0	1931.8	422.1	868.8	35.7	22.7
12		Хөвсгөл	725	887	1	224	284	22	37	1607.8	4642.5	979.8	2148.4	35.1	899.6
13	Төвийн бүс	Говьсүмбэр	139	150	-	84	81	5	2	319.7	246.9	231.9	154.9	92.8	20.0
14		Дархан-Уул	532	679	-	110	117	7	12	1732.1	5251.4	433.8	2193.0	78.0	3.9
15		Дорноговь	471	608	11	175	221	11	7	1551.2	3276.3	767.6	1094.6	265.8	200.3
16		Дундговь	247	266	-	110	117	7	12	711.9	1091.5	311.2	484.5	8.0	579.8
17		Өмнөговь	445	567	6	218	223	14	26	1011.0	2321.4	647.0	845.7	-	46.0
18		Сэлэнгэ	644	822	3	287	291	24	23	2261.7	5663.9	1207.9	2377.2	775.2	305.4
19	Төв	634	767	2	311	361	31	51	3744.9	6691.9	2996.5	3521.4	251.9	624.8	
20	Зүүн бүс	Дорнод	539	572	-	235	254	24	18	2149.6	2058.7	1222.9	1089.5	49.9	158.2
21		Сүхбаатар	343	521	-	116	159	11	15	1207.5	12436.3	524.0	941.6	6.5	149.2
22		Хэнтий	546	724	-	210	268	28	30	1573.0	3315.7	664.2	1459.9	46.8	48.0
23	Нийслэл		16060	23899	56	4677	6128	339	332	149312.6	284052.9	74028.5	157785.4	3526.9	1210.4
24	Баянгол		2668	4422	3	604	838	35	51	19471.0	36399.7	6998.0	22672.9	1796.8	44.0
25	Баянзүрх		4041	6081	25	1247	1541	101	95	24936.5	45867.4	10434.1	15859.2	957.0	218.8
26	Сүхбаатар		2235	3564	6	574	794	33	24	42811.0	47558.2	27301.9	22623.5	709.1	150.9
27	Сонгинохайрхан		2861	3312	1	1030	1327	78	71	11059.7	14507.1	4303.2	6027.0	23.1	81.8
28	Хан-Уул		2010	3168	14	444	749	45	56	35747.8	106134.2	16998.0	70124.8	2.0	144.8
29	Чингэлтэй		1782	2808	23	506	617	33	23	13898.8	32307.7	7577.5	19909.7	29.5	556.5
30	Багануур		159	203	2	92	101	2	4	393.5	320.2	57.1	201.3	-	-
31	Багахангай		21	20	-	14	14	-	-	40.0	91.8	40.0	43.8	-	-
32	Налайх		283	321	-	166	147	14	8	954.4	866.6	318.7	323.1	9.4	13.5
33	Улсын дүн		24981	35211	87	8299	10307	683	766	179500.6	347693.8	90399.1	183228.9	6541.2	5695.0
	Өсөлт бууралт/тоогоор/		+10230			+2008		+83		+168193.2		+92829.8		-846.2	
	Өсөлт бууралт /хувиар/		+40.9			+24.1		+12.1		+93.7		+102.6		-12.9	

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зарим төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 2. Тодорхой төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол

№	Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол												
		Хохирсон			Гэмтсэн хүн		Нас барсан хүн		Нийт хохирлын хэмжээ /сая.төг/		Нөхөн төлүүлсэн /сая.төг/		Битүүмжилсэн хэмжээ /сая.төг/	
		Иргэн	Хуулийн этгээд	Гэмтсэн хүн	Нас барсан хүн	Нийт хохирлын хэмжээ /сая.төг/	Нөхөн төлүүлсэн /сая.төг/	Битүүмжилсэн хэмжээ /сая.төг/						
1	Хүнийг алах	206	202	-	29	21	171	183	1042.8	4005.4	919.8	3865.7	46.1	118.9

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ – CRIMINAL DAMAGE

2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	8072	9736	-	7299	9058	27	23	8963.1	12410.9	7238.9	9830.8	484.0	447.3
3	Хүчиндэх	458	552	-	51	59	-	-	-	-	-	-	-	-
4	Хулгайлах	4569	6094	15	-	-	-	-	11074.1	20493.1	3880.5	6062.4	208.3	240.4
5	Хувийн өмчийг хулгайлах	3929	5292	4	-	-	-	-	9512.7	16879.6	3255.8	4784.8	173.3	201.0
6	Халаасны хулгай	364	451	-	-	-	-	-	425.6	663.3	59.4	157.7	0.0	1.2
7	Мал хулгайлах	755	798	1	-	-	-	-	3766.4	3353.1	1931.8	1694.6	318.7	289.2
8	Дээрэмдэх	373	495	-	35	45	-	-	541.9	9428.4	298.5	1536.3	11.2	67.1
9	Залилах	6523	11786	19	-	-	-	-	104522.6	229193.4	44931.3	116161.3	3004.2	1876.6
10	Хүрээлэн байгаа орчны эсрэг	536	485	9	-	-	-	-	5398.2	4872.0	2095.1	3411.8	1066.3	818.5
11	Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, Ашиглалтын журам зөрчих	1037	1357	-	772	1039	238	279	4962.6	7432.9	4282.6	6526.4	609.4	703.6
12	Цахим орчинд үйлдэгдсэн	4103	8438	-	-	-	-	-	18508.7	32662.6	9228.8	10413.8	34.4	275.6
13	Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, Алдуул мал завших	594	861	-	-	-	-	-	1909.8	5888.8	335.9	730.7	36.8	9.2

Гэмт хэрэгт холбогдсон зарим этгээд болон гэмт хэргийг үйлдэх үеийн нөхцөл байдал, түүний улмаас учирсан хохирлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах 3, 4 дүгээр хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 3. Гэмт хэргийн онцлог, нөхцөл байдлын улмаас учирсан хохирол

№	Гэмт хэргийн онцлог, нөхцөл байдал	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол												
		Хохирсон			Гэмтсэн хүн		Нас барсан хүн		Нийт хохирлын хэмжээ /сая.төг/		Нөхөн төлүүлсэн /сая.төг/		Битүүмжилсэн хэмжээ /сая.төг/	
		Иргэн	Хуулийн этгээд	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
1	Согтуугаар үйлдсэн	6319	7525	-	4579	5507	279	297	9428.3	16251.7	7588.1	13145.9	935.6	817.2
2	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн	1489	1664	-	1228	1432	14	28	-	-	-	-	-	-
3	Гэр, орон сууцанд үйлдэгдсэн	9685	12453	1	3782	3862	213	237	37376.5	92679.5	19430.0	59750.1	1982.1	662.6
4	Олон нийтийн газарт үйлдэгдсэн	2044	3656	5	525	1207	13	23	17284.3	19426.1	10877.9	9302.5	556.3	186.5
5	Гудамж талбайд үйлдэгдсэн	4864	7008	1	2015	2494	75	80	15003.7	29159.8	8166.9	14570.9	805.8	388.6

Хүснэгт 4. Гэмт хэрэгт холбогдсон хүний онцлог байдлын улмаас учирсан хохирол

№	Гэмт хэрэгт холбогдсон хүний онцлог	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол												
		Хохирсон			Гэмтсэн хүн		Нас барсан хүн		Нийт хохирлын хэмжээ /сая.төг/		Нөхөн төлүүлсэн /сая.төг/		Битүүмжилсэн хэмжээ /сая.төг/	
		Иргэн	Хуулийн этгээд	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
1	Эмэгтэй хүн үйлдсэн	11275	16099	-	3070	3704	176	210	68802.3	114269.8	-	-	-	-
2	Насанд хүргээгүй хүн үйлдсэн	1365	2014	-	550	852	83	92	2489.2	3438.3	-	-	-	-
3	Гадаадын иргэний үйлдсэн	42	114	-	14	24	-	-	3019.2	27894.4	-	-	-	-

Улсын хэмжээнд 2022 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 35211 иргэн, 87 хуулийн этгээд хохирч, үүнээс 766 хүн нас барж, 10307 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нас барсан хүн 83 буюу 12.1%-иар, гэмтсэн хүн 2008 буюу 24.1%-иар тус тус өссөн байна.


Харин гэмт хэргийн улмаас нийт 347693.8 сая төгрөгийн хохирол учирч, үүнээс 183228.9 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 5695.0 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирол 168193.2 сая төгрөг буюу 93,7%-иар, нөхөн

төлүүлсэн хохирол 92829.8 сая төгрөг буюу 102,6%-иар тус тус өсөж, эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа 846.2 сая төгрөг буюу 12,9%-иар буурсан статистик үзүүлэлт гарсан байна.

2. Авлигатай тэмцэх байгууллагын статистик

2022 онд Авлигатай тэмцэх газарт шалгагдсан гэмт хэргийн улмаас 5,024,895,829,317.00 /таван их наяд, хорин дөрвөн тэрбум, найман зуун ерэн таван сая, найман зуун хорин есөн мянга, гурван зуун арван долоо/ төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 2,374,934,309,243.00 /хоёр их наяд гурван зуун далан дөрвөн тэрбум, есөн зуун гучин дөрвөн сая, гурван зуун есөн мянга, хоёр зуун дөчин гурав/ төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 518,039,332,298.00 /таван зуун арван найман тэрбум, гучин есөн сая, гурван зуун гучин хоёр мянга, хоёр зуун ерэн найм/ төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

График 3. Учирсан хохирол, битүүмжилсэн хөрөнгө, нөхөн төлүүлсэн байдал /өмнөх оны мөн үетэй харьцуулбал/



Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 5 дахин, нөхөн төлүүлэлт 24.7 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 4.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Нийт учирсан хохирлын 47.3 хувийг нөхөн төлүүлж, хахуулийн 18,874,521,566 төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан байна.

2021 онд тус байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлсэн хэргээс 160 эрүүгийн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол 2022 онд 188 хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж, шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг өмнөх оныхоос 17.5%-иар өссөн байна. Мөрдөн шалгах ажиллагааны явцад 2021, 2022 онд гадаад улсаас нийт 12.2 сая ам.доллар авах үндэслэлийг тогтоож, шүүхийн шийдвэрээр улсын орлого болгосон. Үүнд:

- ИБУИНВУ-д байрлах 1 орон сууц, 1.8 тэрбум төгрөг (бэлэн мөнгө), 269.0 сая төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө 2 ширхэг, нийт 6.4 тэрбум төгрөг буюу 4.7 сая ам. долларыг улсын орлого болгосон.

- Их Британийн Виржинийн арлаас 2.2 тэрбум төгрөгийн буюу 1.6 сая ам.долларын үнэ бүхий газар, үл хөдлөх хөрөнгийг улсын өмчид бүртгүүлж, мөн арлаас 11.3 тэрбум төгрөг буюу 5.7 сая ам, долларыг тус тус улсын орлого болгон хураан авсан байна.

3.Прокурорын байгууллагын статистик

2022 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн улмаас 39258 хүн хохирсноос, 18369 эмэгтэй, 2101 насанд хүрээгүй хүн байна. Мөн амь насаа алдсан 2417 хүн, гэмтэл авсан 12083 хүн, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас 737 хүн тус тус хохирсон байна.

График 4. Хохирогчид /өмнөх оны мөн үетэй харьцуулбал/



Хүснэгт 5. Прокурорын байгууллагад бүртгэгдсэн хохирогч

		Прокурорын байгууллага					
		Хохирогч	Үүнээс		Амь насаараа хохирсон хүн	Эрүүл мэндээрээ хохирсон хүн	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн
			Эмэгтэй	Насанд хүрээгүй хүн			
Нийт		39258	18369	1383	2417	12083	737
Нийслэл		28111	13624	1431	1395	7491	258
1	Тээврийн ПГ	978	436	90	66	843	0
2	Нийслэл ПГ	169	82	3	4	20	1
3	Багануур ДПГ	145	55	6	10	90	0
4	Налайх,Багахангай ДПГ	531	252	22	77	187	25
5	Баянгол ДПГ	3503	1698	168	94	817	16
6	Баянзүрх ДПГ	7752	3759	469	557	1850	105
7	Сонгинохайрхан ДПГ	4010	1770	223	180	1344	40
8	Сүхбаатар дүүргийн ПГ	3924	1971	169	58	813	24
9	Хан-Уул ДПГ	3300	1539	152	284	825	32
10	Чингэлтэй ДПГ	4232	2272	137	65	702	15
Орон нутаг		11277	4811	673	1022	4592	479
1	Архангай АПГ	402	128	11	22	179	9
2	Баян-Өлгий АПГ	554	161	38	16	130	13
3	Баянхонгор АПГ	448	205	30	14	201	30
4	Булган АПГ	395	170	23	44	157	3
5	Говь-Алтай АПГ	235	96	17	11	76	4
6	Говьсүмбэр АПГ	169	72	22	15	90	14
7	Дархан-Уул АПГ	676	356	50	73	281	53
8	Дорноговь АПГ	581	306	29	30	227	19
9	Дорнод АПГ	513	198	17	29	290	10
10	Дундговь АПГ	263	105	14	31	123	13
11	Завхан АПГ	334	123	18	46	162	23

12	Орхон АПГ	916	445	66	85	311	41
13	Өвөрхангай АПГ	712	330	57	106	269	44
14	Өмнөговь АПГ	642	261	30	139	232	26
15	Сүхбаатар АПГ	509	195	33	23	181	14
16	Сэлэнгэ АПГ	680	277	46	44	305	32
17	Төв АПГ	819	302	28	100	412	23
18	Увс АПГ	327	112	15	20	154	15
19	Ховд АПГ	522	226	32	21	225	39
20	Хөвсгөл АПГ	854	500	49	49	296	16
21	Хэнтий АПГ	751	255	50	104	291	38

4. Шүүхийн статистик

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2022 онд 20199 шүүгдэгч, 17 хуулийн этгээдэд холбогдох 16355 хэрэг хянаснаас 16736 шүүгдэгч, 11 хуулийн этгээдэд холбогдох 14202 хэргийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн улмаас 2022 онд 19376 хүн хохирогчоор бүртгэгдсэнээс 6953 эмэгтэй, 909 хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1132 хүн байна. Албан тушаалаар нь авч үзвэл, улс төрийн албан тушаалтан 20, төрийн захиргааны албан хаагч 208, шүүгч 1, прокурор 2, мөрдөгч 26, хууль сахиулах байгууллагын ажилтан 198, эмч 174, багш 367, оюутан 1034, сурагч 810, малчин 2414, ажилгүй 3689 зэрэг тус тус бүртгэгджээ. Боловсролын хувьд дээд боловсролтой 5552, бүрэн дунд боловсролтой 6999, суурь боловсролтой 2403, бага боловсролтой 1439, боловсролгүй 749 байна.

Гэмт хэргийн улмаас 592 хуулийн этгээд хохирогчоор тогтоогдсон бөгөөд Төрийн байгууллага 480, хязгаарлагдмал хариуцлагатай компани 110, холбоо 1, төрийн бус байгууллага 1 байна.

Хохирогч хүнийг иргэний харьяаллаар нь авч үзвэл, Монгол Улсын иргэн 19365, гадаадын иргэн 11, харьяалалгүй хүн бүртгэгдээгүй байна.

Гэмт хэргийн улмаас 530 хүн нас барснаас 103 эмэгтэй, 61 хүүхэд байна. Гэмт хэргийн улмаас 8591 хүн гэмтсэнээс 2168 эмэгтэй, 280 хүүхэд, мөн 817 хүнд, 1308 хүндэвтэр, 6466 хөнгөн гэмтэл учирчээ.

Гэмт хэргийн улмаас 264.184.886.537 төгрөгийн хохирол учирснаас хүнд 84.434.061.758 төгрөг, хуулийн этгээдэд 179.750.824.779 төгрөгийн хохирол учирчээ. Хохирол нөхөн төлүүлэлт нийт 58.085.344.188 төгрөг болсноос хүнд 41.599.071.565 төгрөг, хуулийн этгээдэд 16.486.272.623 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын статистик

Төрөөс олгосон нөхөн төлбөрийн тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэргийн шүүхээс тогтоосон торгох ялыг гүйцэтгэсэн үнийн дүнгийн 60%, гэм буруутай төлбөр төлөгчөөс нөхөн төлүүлсэн төлбөрийн мөнгийг “Гэмт хэргийн нөхөн төлбөрийн сан”-д байршуулж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21 зүйлд хамаарах гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэж байна.

Төрөөс нөхөн төлбөр олгох үндэслэлийн дагуу 2021 онд 347.731.619 төгрөг, 2022 онд 493.282.317 төгрөгийг тус тус төлбөр авагч иргэдэд олгуулж, уг мөнгийг зохих санд буцаан төвлөрүүлэх, мөнгөн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэсэн.

2021-2022 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1, 11.1, 11.4, 12.1, 17.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн улмаас хохирсон төлбөр авагч иргэдэд нөхөн төлбөр олгож, төлбөр төлөгчөөс 2021 онд 51.939.535 төгрөг, 2022 онд 150.4 сая төгрөгийг зохих санд төвлөрүүлэн ажилласан.

Төрөөс 2014-2022 онд олгосон гэмт хэргийн нөхөн төлбөрт хамаарах эрүүгийн хэргийн шийдвэрүүдийг авч үзвэл:

- 2014-2015 оны шүүхийн шийдвэрээр 3 төлбөр авагчид 17.351.751 төгрөг;
- 2016-2017 оны шүүхийн шийдвэрээр 13 төлбөр авагчид 79.958.227 төгрөг;
- 2018-2019 оны шүүхийн шийдвэрээр 56 төлбөр авагчид 536.739.368 төгрөг;
- 2020-2021 оны шүүхийн шийдвэрээр 89 төлбөр авагчид 759.512.371 төгрөг;
- 2021-2022 оны шүүхийн шийдвэрээр 61 төлбөр авагчид 493.282.317 төгрөгийн нөхөн төлбөрийг төрөөс олгуулсан байна.

Зөрчлийн хариуцлага тооцсон тухай

Иргэний, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч, гуравдагч этгээдийн саад учруулсан, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах хууль ёсны шаардлага биелүүлээгүй, төлбөр төлөхөөс зайлсхийсэн үйлдэл, эс үйлдэхүйг үндэслэн ахлах шийдвэр гүйцэтгэгчдээс Зөрчлийн тухай хуулийн 6.20, 15.2, 15.27 дугаар зүйлийг үндэслэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг үндэслэн 2021 онд 118 холбогдогчид 32.6 сая төгрөгийн торгох шийтгэл, 30 холбогдогчид баривчлах шийтгэл, 2022 онд 54 холбогдогчид 18.4 сая төгрөгийн, 18 холбогдогчид 1.8 сая төгрөгийн торгох шийтгэл, 34 холбогдогчид баривчлах шийтгэл, албадан сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ тогтоолгож, шийтгэлийн хуудасны биелэлтийг хангуулсан.

2022 онд шийтгэл оногдуулсан зөрчлийн холбогдогчийг авч үзвэл:

- Төлбөрийн үүрэг хүлээсэн 74 холбогдогч;
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус, гуравдагч этгээд болох 26 холбогдогч
- Хүүхдийн тэтгэлэг төлөх үүргээ биелүүлээгүй 18 холбогдогчид тус тус зөрчлийн хариуцлага тооцох арга хэмжээ авсан.

Ахлах шийдвэр гүйцэтгэгчдээс нийслэлд 116, орон нутагт 38 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан байна.

Гэмт хэргийн хохирол, төлбөр барагдуулалт

2021 онд 89.7 тэрбум төгрөгийн 1383 төлбөртэй хоригдол, 2022 онд 107.3 тэрбум төгрөгийн 1621 төлбөртэй хоригдол хорих ангид ял эдэлж байсан.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулах ажлын хүрээнд 2021 онд хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс 241.8 сая төгрөг, 2022 онд 308.4 сая төгрөг суутгасныг гүйцэтгэх баримт бичигт заасан хохирол, төлбөрт тооцон шилжүүлсэн байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрээр хохирол, төлбөр гаргуулах гүйцэтгэх баримт бичгийг албадан гүйцэтгүүлэхээр 2021-2022 онд нийт 161.990.208,0 төгрөгийг төлбөр авагч иргэнд, 117.404.143,6 төгрөгийг төлбөр авагч-хуулийн этгээдэд, 31.743.449,6 төгрөгийг улсын орлогод оруулах нийт 15753 гүйцэтгэх баримт бичгийг шүүх, төлбөр авагчдаас тус тус ирүүлсэн байна.

- 2021 онд 53.486.746,2 төгрөгийн 4743 гүйцэтгэх баримт бичгийг;
- 2022 онд 72.015.294,3 төгрөгийн 6082 гүйцэтгэх баримт бичгийг тус тус шинээр хүлээн авчээ.



2021 онд улсын хэмжээнд эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрээр хохирол, төлбөр гаргуулах 154.420.081,7 төгрөгийн 7358 гүйцэтгэх баримт бичигт, 2022 онд 156.717.719,5 төгрөгийн 8395 гүйцэтгэх баримт бичигт тус тус шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж, 2021 онд 44.095.992,3 төгрөгийг, 2022 онд 30.794.877,1 төгрөгийн хохирол, төлбөрийг барагдуулсан.

Эрүүгийн хохирол, төлбөр барагдуулах ажлын хүрээнд 2021 онд 4279, 2022 онд 4769 гүйцэтгэх баримт бичгийг эцэслэн шийдвэрлэж, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангажээ.

Зөрчлийн шийтгэл, хохирол барагдуулалт

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан 5.4 тэрбум төгрөгийн 2589 гүйцэтгэх баримт бичигт 2021 онд, 20.2 тэрбум төгрөгийн 3571 гүйцэтгэх баримт бичигт 2022 онд зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, нийт 12.0 төгрөгийн 3189 гүйцэтгэх баримт бичгийг эцэслэн шийдвэрлэсэн.

2021 онд Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болсон гүйцэтгэх баримт бичгийг авч үзвэл:

- 2361 гүйцэтгэх баримт бичгийн 3.6 тэрбум төгрөгийн торгох шийтгэл;
- 44 гүйцэтгэх баримт бичгийн 11.3 сая төгрөгийн зөрчил үйлдэж, олсон хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээг;
- 112 гүйцэтгэх баримт бичигт холбогдох зөрчлийн үр дагавар, хохирол 1.8 тэрбум төгрөгийн төлбөрийн албадан гүйцэтгэх ажиллагаа явагдсан.

2022 онд Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болсон гүйцэтгэх баримт бичгийг авч үзвэл:

- 177 гүйцэтгэх баримт бичгийн 107.3 сая төгрөгийн торгох шийтгэл;
- 7 гүйцэтгэх баримт бичгийн 13.1 сая төгрөгийн зөрчил үйлдэж, олсон хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээг;
- 171 гүйцэтгэх баримт бичигт холбогдох зөрчлийн үр дагавар, хохирол 1 тэрбум төгрөгийн төлбөрийн албадан гүйцэтгэх ажиллагаа явагдсан байна.

Монгол Улсад гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг мөнгөн дүнгээр үнэлэн тогтоох практик янз бүрээр тогтож байгаа бөгөөд ихэнх мөрдөгч, прокурор, шүүгч гэмт хэргийн хор уршгийг иргэний гэм хор, 2002 оны ЭБШХ үйлчилж байх үед тогтсон эрүүгийн процесс дахь иргэний нэхэмжлэлтэй андуурах ойлголтын зөрүү байсаар байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, гэмт хэргийн улмаас учирсан амь нас, сэтгэл санаа, эрүүл мэнд, эд хөрөнгө, эдийн бус хохирлыг мөнгөн дүнгээр үнэлэх, тооцох аргачлалыг бий болгох шаардлага үүсэж байна.

Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн гэмт хэргийн улмаас хүний бие махбод, сэтгэл санаанд учирсан хохирлын үнэлгээний заавар, журам, аргачлалыг шинээр боловсруулж, хэрэгжүүлэх хүний бие махбод, эд эрхтний үнэлгээг бий болгох нь зүйтэй. Тухайлбал Оросын Холбооны Улсад сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг шүүхийн журмаар шийдвэрлэн олгож, нөхөн төлбөр олгохдоо тухайн гэм буруутай этгээдээс гаргуулж, эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Эрделевскийн хүснэгтийг ашиглаж байна.

Гадаадын зарим улсын сайн жишгийг судлах замаар сэтгэл санааны хохирлыг тооцож үнэлэх, нөхөн олгох эрх зүйн орчин, практикийг бий болгох шаардлагатай. Тухайлбал, шүүх эмнэлгийг сэтгэц гэм судлалын шинжлэх ухаантай хослуулан хөгжүүлж, хүний сэтгэл санааны хохирол тооцох аргачлалыг бий болгож, хэрэгжүүлэх нь зүйтэй.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллагаас гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг зөв тогтоох, бодит үнэлгээг гаргуулах, нөхөн төлбөрийг баталгаатай болгох

зорилгоор хөрөнгө битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагааг мөрдөн шалгах ажиллагааны явцад өргөн хэрэглэх нь хохирогчийн эрхийг хангахад ач холбогдолтой.

Эрүүгийн хэрэгт гэмт хэргийн хор уршгийг иргэний хэргийн гэм хортой андуурч тусад нь шийдвэрлэхээр шүүхийн тогтоолд дурдаж байгаа явдлыг халах, хохирогчийн эрхийг хамгаалах, хохирлыг барагдуулах процессыг нэг мөр шийдвэрлэж байх хэрэгтэй байна.

---o0o---



НАЙМДУГААР
БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН
БАЙГУУЛСАН АЖИЛ-
PREVENTIVE
MAINTENANCE



1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээний хүрээнд

1.1. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус нэмэлт, өөрчлөлтөөр:

✓ Зохицуулах зөвлөлийн орон тооны ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан нь төрийн албан хаагч байх бөгөөд албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтоох,

✓ Олон нийтийн байцаагчийн ажиллах нийтлэг журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах,

✓ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд төсөвт тусгаж санхүүжүүлэх зэрэг зохицуулалтууд хуульчлагдсан.

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 28 дугаар тогтоолоор байгуулсан.

Ажлын хэсгээс хуулийн төсөл боловсруулсан холбогдох хууль тогтоомжийн дагуу уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал зөвлөмжийг авч, төслийг боловсруулсан.

Улсын Их Хурал 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг баталсан ба хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 14.5-д заасан Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар тогтооно”, Засгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт “Хууль тогтоомжид заасан байнгын үйл ажиллагаатай, орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, зөвлөл, ажлын хэсэг байгуулахдаа энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай” гэж заасны дагуу Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулахаар Засгийн газрын “Журам, тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” тогтоолын төслийг боловсруулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 247 дугаар тогтоолоор Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

Монгол Улсын нэгдэн орсон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн оролцогч талуудын Бага хурлын 2018 оны 9/1, 2020 оны 10/1 тоот тогтоолын дагуу Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц болон түүний нэмэлт протоколуудын хэрэгжилтийн талаар Монгол Улсын тайланг боловсруулж, 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдөр ажлын хэсгийн хуралд танилцуулан эцэслэсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор баталсан Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад шалгарсан “Эс Ай Си Эй” ХХК гүйцэтгэж, “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг гүйцэтгэж, хэрэгжилтийн нийт үнэлгээ 90%” гэж үнэлсэн болно.

1.2.Төрийн албан хаагч, мэргэжилтэн, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр



Монгол Улсын Засгийн газар 2018 онд “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг сайжруулахын тулд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Улсын ерөнхий прокурорын газар,

Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Дотоод хэргийн их сургууль, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль болон Иргэдийн оролцоо төслийн оролцоотойгоор Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Ажлын хэсэг нь хүүхэд, залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой “Эрх зүйн мэдлэг олгох албан бус сургалтын хөтөлбөр” боловсруулах үүрэгтэй бөгөөд ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн 10-12 дугаар ангийн сурагчид, их, дээд сургуулийн эрх зүйн бус мэргэжлийн ангийн 1, 2 дугаар дамжааны оюутнууд, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийн суралцагчдад зориулсан эрх зүйн мэдлэг олгох албан бус сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Энэхүү ажлыг цогц байдлаар хэрэгжүүлэхээр зорьж байгаа бөгөөд 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Нэгдүгээрт: Уг ажлын хүрээнд юуны өмнө албан боловсролын түвшин дэх эрх зүйн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг илрүүлж, цаашид сайжруулах, улмаар эрх зүйн албан бус боловсролын хөтөлбөр боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулан шинжилгээ хийх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд Боловсролын хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын дэмжлэгээр албан боловсролын түвшин дэх эрх зүйн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийн, цаашид сайжруулах, эрх зүйн албан бус боловсролын хөтөлбөр боловсруулахад шаардлагатай судалгааны ажлыг хийсэн.

Хоёрдугаарт: Цуглуулсан мэдээлэл, дүгнэлтэд үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчид, их, дээд сургуулийн эрх зүйн бус мэргэжлийн ангийн 1, 2 дугаар дамжааны оюутнууд, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад зориулсан эрх зүйн мэдлэг олгох албан бус сургалтын хөтөлбөрийг боловсруулж, багшийн болон суралцагчийн гарын авлагыг бэлэн болгосон байна.

Гуравдугаарт: “Эрх зүйн мэдлэг олгох албан бус сургалтын хөтөлбөр”-ийг заах багш нарыг бэлтгэх, заах арга зүйг сайжруулах, гарын авлага хэвлэж бэлтгэх, сургалтаа эхлүүлэх, явцын болон эцсийн үр дүнг тооцох, ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчид, их, дээд сургуулийн эрх зүйн бус мэргэжлийн ангийн 1, 2 дугаар дамжааны оюутнууд, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын албан сургалтын хөтөлбөрт тусгуулахаар санал хүргүүлж, албан бусаар сургалтын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ерөнхий боловсролын сургуулийн багш, нийгмийн ажилтан, цагдаагийн



байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан алба хаагч нарт зориулсан сургагч багш бэлтгэх сургалтыг 2022 оны 5 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулсан ба нийт 120 сургагч багшийг бэлтгэв.

Сургалтын гарын авлага нь дараах агуулгаар бэлтгэгдсэн. Үүнд:

- ✓ Гэр бүлд хүүхдийн оролцоо (эрх ба үүрэг)
- ✓ Хүүхдийн эрх
- ✓ Сурч боловсрох эрхээ хэрэгжүүлэхэд сурагчийн оролцоо
- ✓ Эрүүл мэндээ хамгаалах нь
- ✓ Олон нийтийн хэв журмыг сахихад оролцох нь
- ✓ Байгаль орчноо хамгаалахад оролцох нь
- ✓ Хэлцэл хийх
- ✓ Насанд хүрээгүй байхдаа хөдөлмөр эрхлэх нь
- ✓ Эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оролцох нь
- ✓ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оролцох нь
- ✓ Монгол Улсын иргэн
- ✓ Сонгууль, ард нийтийн санал асуулгад оролцох нь зэрэг болно.

2022-2023 оны хичээлийн жилд Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн 388 сурагчид туршилтын сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон.

НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Цахим орчинд үйлдэгддэг хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх нь” сургалтыг 2022 оны 01 дүгээр сарын 10-наас 12-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг сургалт нь цахим орчинд үйлдэгдэж буй хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдүүдийг илрүүлэх, гэмт хэрэгтнүүдийг мөрдөх, гэмт хэргийн хянан шийдвэрлэх явцад анхаарах асуудлаар цагдаа, прокурор болон шүүхийн байгууллагын алба хаагчдын чадавхыг бэхжүүлэх зорилготой байв. Сургалтыг АНУ-ын “Сураггүй алга болсон болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд туслах олон улсын төв”-ийн мэргэжилтнүүд, АНУ-ын Хойд Виржиния мужийн Фэйрфакс хотын прокурор, Холбооны мөрдөх товчооны хүүхдийн эсрэг мөлжлөг, хүний наймаатай тэмцэх тасгийн мөрдөгч болон АНУ-ын Маршалын албаны Зан үйлийн шинжээч зэрэг туршлагатай мэргэжилтнүүд чиглүүлэн явууллаа.

Хил хамгаалах ерөнхий газар, Олон Улсын шилжилт хөдөлгөөний байгууллага хамтран хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж тогтоох, туслалцаа үзүүлэх сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад Монгол Улсын хилийн 34 боомт дахь шалган нэвтрүүлэх албаны 55 удирдах албан тушаалтан хамрагдсан. Сургалтаар хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд хил хамгаалах байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хохирогчийг таних илрүүлэх ур чадвар, техник арга барил олгох, хохирогчдод туслалцаа үзүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр мэдээлэл хүргэсэн.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид тусламж, үйлчилгээг үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, салбар дундын уялдаа холбоог сайжруулах зорилгоор “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж тогтоох, холбогдох талд мэдэгдэх, богино болон урт хугацаанд туслалцаа үзүүлэх тухай сургалт”-ыг 2022 оны 09 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Сургалтад Дархан, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Баян-Өлгий аймаг, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Налайх дүүргийн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны

нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон Нийслэлийн цагдаагийн удирдах газрын алба хаагчид нийт 50 хүн хамрагдав.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны даргын 2022 оны А/05 дугаар тушаалаар Хүчирхийллийн хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр шүүгч, прокурор, цагдаа, хуульч, өмгөөлөгчдөд зориулсан сургалт зохион байгуулах салбар дундын ажлын хэсэг байгуулж, сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 10, 13, 16-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтад дүүргийн цагдаагийн алба хаагч, прокурор, шүүгч зэрэг 120 албан хаагчийг хамруулсан.

Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагын “Монгол улсад хүүхдийн хууль зүйн туслалцаа авах хүртээмжийг нэмэгдүүлэх замаар “Ковид-19” цар тахлын үр нөлөөг бууруулах” төслийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 13 аймгийн нийт 183 гишүүдийг хамруулан сургалт зохион байгуулав.

Хүний эрхийн Үндэсний комисс, Цагдаагийн ерөнхий газар, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх, алба хаагчдыг хохирогч төвтэй хандлагад суралцуулах, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлогийн талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор 21 аймгийн нийт 120 алба хаагчдад “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь” сэдэвт сургалтыг 2022 оны 05 дугаар сард бүсчилсэн байдлаар зохион байгуулсан.

Цагдаагийн алба хаагч нарт стрессийг удирдах, даван туулах арга барилд сургах сургалтыг үе шаттай зохион байгуулах зорилгоор цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчдийг стрессийг даван туулах арга стратеги, сэтгэл зүйн хамгаалах механизмын талаарх мэргэшүүлэх сургалтад хамруулж, сургагч багшаар бэлтгэх сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 06-наас 11-ний өдрүүдэд зохион байгуулав.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктэй хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд боловсруулсан хамтарсан багийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багийн гишүүдэд зориулсан багц гарын авлагын хэлэлцүүлгийг 2022 оны 12 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд, сургагч багш бэлтгэх сургалтыг 2022 оны 12 дугаар сарын 05-09-ний өдөр тус тус зохион байгуулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх тасгийн дарга, боомтын дарга нарын чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт арга зүйн нэгдсэн сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Хил хамгаалах ерөнхий газарт зохион байгууллаа. Сургалтад хилийн 26 боомтын 55 алба хаагч оролцсон.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас Шүүх шинжилгээний ерөнхий газар, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сантай хамтран “Шүүх шинжилгээний ерөнхий газрын Экологийн шинжээчдийг мэргэшүүлэх сургалт”-ыг Ханнс-Зайделийн сангийн байранд 2022 оны 4 дүгээр сарын 28, 29-ний өдөр зохион байгуулсан. Тус сургалтыг шинжээч нарын тусгай мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, ул мөр, эд мөрийн



баримтыг илрүүлж, бэхжүүлэх ажиллагаанд шинжлэх ухаанд суурилсан арга, аргачлалын дагуу шинжээчийн дүгнэлт гаргах ажилд мэргэшүүлэх чиглэлээр зохион байгууллаа.

Ажлын албанаас Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран “Зэрлэг амьтад, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний хил дамнасан хууль бус худалдааг бууруулах боломж, Алба хаагчдын манлайллын ур чадвар, ажлын гүйцэтгэлийг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 02-ноос 10-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтад хил, мэргэжлийн хяналт, гаалийн 53 алба хаагчийг хамруулсан.



Ажлын албанаас Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран “Байгалийн ургамлын эд эрхтэн, бүтээгдэхүүний хил дамнасан хууль бус худалдаа, түүний илрүүлэлт, хяналт, хамтын ажиллагааг сайжруулах нь” сэдэвт хөдөлгөөнт сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 01-нээс 11-ны өдрүүдэд Говь-Алтай аймгийн Бургастай, Ховд аймгийн Булган, Баян-

Өлгий аймгийн Цагааннуур, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь хилийн боомтуудад зохион байгууллаа. Сургалтад Говь-Алтай аймгийн Бургастай, Ховд аймгийн Булган, Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь хилийн боомтод үүрэг гүйцэтгэж байгаа хил, гаалийн 100 орчим алба хаагчид хамрагдаж, “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх: Хууль бусаар мод, байгалийн ургамал бэлтгэх гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд” сургалтын гарын авлагыг тараасан.

1.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах сонгон шалгаруулалт болон шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын чиглэлээр

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 250 дугаар тушаалаар баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 8 төсөл, арга хэмжээний 20 багц тендер холбогдох хууль тогтоомжийн дагуу зарлагдаж, 3 үнэлгээний хороо, 2 ажлын хэсэг хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг явуулж, дараах бараа бүтээгдэхүүнийг холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн байна. Үүнд:

- ✓ Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай 3 ширхэг микроскоп, хэргийн газрын үзлэгт хэрэглэгдэх kastle meyer test bluestar, Lumminol, LMG зэрэг урвалж, хэргийн газарт биологийн ул мөрийг илрүүлэх зориулалт бүхий цэнхэр гэрэл болон металл хайгч;
- ✓ ЦЕГ-ын Эрүүлжүүлэх саатуулах байр, Дорнод аймагт байгуулах албадан эмчлэх төвд, эмнэлгийн болон харуул хамгаалалтын тоног төхөөрөмжийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, 27 нэр төрлийн тоног төхөөрөмж;
- ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх үйл ажиллагаанд шаардлагатай урвалж бодис;
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх хөтөлбөрийн хүрээнд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай 80 ширхэг энгэрийн камерыг худалдан авч, холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн.

Монгол Улсын Засгийн газар болон Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департамент хамтран хэрэгжүүлж байгаа “Хүүхэд хамгааллын компакт гэрээ”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг худалдан авч, хүлээлгэн өгсөн.

2.Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

2.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, гэмт хэргийн нөхцөл байдал болон энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын өнгөрсөн онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар мэдээлэл сонсож, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, чиг үүргийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, сургаж мэргэшүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж багаж хэрэгслээр хангах, донтогчдод үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг шинэ шатанд гаргах талаар хэлэлцэв.

2.2.Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 онд

- ✓ Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын Нидерланд Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсад хүн худалдаалахтай тэмцэх”,
- ✓ Монгол Улсын Засгийн газар болон Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департамент хамтран хэрэгжүүлэх Монгол Улсад хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах, хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн Хүүхэд хамгааллын компакт гэрээний төсөл,
- ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хүйсийн тэгш эрхийн төв” төрийн бус байгууллага, БНСУ-ын Жендэрийн тэгш эрхийн, гэр бүлийн яам хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх төсөл” тус тус хэрэгжиж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр “Хүйсийн тэгш эрх төв” төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, 8 төрлийн үйлчилгээг 11 хохирогч, үйлчлүүлэгчдэд үзүүлсэн байна. Үүнээс 5 нь анх удаа, 6 нь давтан хандсан байна. Энэ ажлын хүрээнд:



- ✓ Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн 11 хохирогч (үйлчлүүлэгч)-ийг шууд туслалцаа болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулсан байна. Тухайлбал, 11 хохирогч (үйлчлүүлэгч)-д хүнсний, 7 хохирогч (үйлчлүүлэгч)-ийг ахуйн болон нэг удаагийн хувцас, 5 хохирогч (үйлчлүүлэгч)-д эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээнд хамруулсан.
- ✓ Мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор Update сургалтын төвд 5 хохирогч (үйлчлүүлэгч)-ийг маникюр, үсчний сургалтад хамруулсан байна.

- ✓ 5 хохирогчид хууль зүйн болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн.
- ✓ Зураг зурах, бүжгийн аргаар сэргээх, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготой дэмжих бүлгийн хичээлийг 10 удаа, амьдрах ухааны сургалтыг 20 удаа тус тус зохион байгуулсан.


2.3. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

- ✓ НҮБ-ын Хүн амын сангийн “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”,
- ✓ Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагын “Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх”
- ✓ Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагын Монгол Улсад хүүхдийн хууль зүйн туслалцаа авах хүртээмжийг нэмэгдүүлэх замаар “Ковид-19” цар тахлын үр нөлөөг бууруулах”
- ✓ Азийн хөгжлийн банкны “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”
- ✓ Азийн хөгжлийн банкны “Ковид-19 цар тахлын үед гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” төсөл тус тус хэрэгжиж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, УИХ-ын Нутгийн удирдлагын дэд хороо, Хүчирхийллийн эсрэг лобби бүлэгтэй хамтран Хүүхэд хамгааллын чиг үүрэгтэй байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, зөвлөлдөх уулзалтыг 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтаар бүх орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлж, ажлын уялдаа холбоог хангах, 2022 онд хүүхэд хамгааллын чиглэлээр төлөвлөж буй ажил арга хэмжээний талаар зөвлөлдөж санал солилцсон.

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын “Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийн хүрээнд байгуулсан жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах чиглэлээр иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах, 17 аймгийн 49 төрийн бус байгууллагуудын форумын найм дахь удаагийн уулзалтыг 2022 оны 03 дугаар сарын 30, 31-ний өдөр зохион байгуулсан.


Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, “Каритас Монгол” төрийн бус байгууллага, эрчүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, эрчүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх талаар “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд эрчүүдийн манлайлал” хэлэлцүүлгийг 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Монголын эрэгтэйчүүдийн холбоо, Зөв эрчүүд, Хөгжлийн төлөөх монгол эрчүүд, 20к клуб зэрэг 40 гаруй төрийн бус байгууллагын төлөөлөл оролцож, эрчүүдийн өмнө тулгамдаж буй асуудал, сөрөг зан үйлд нөлөөлж буй шалтгаан, нөхцөл болон түүнийг арилгах арга замын талаар хэлэлцэж, цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд эрчүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, архинаас үүдэлтэй сөрөг зан үйлийг өөрчлөх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулах зэрэг ажлыг хамтран хэрэгжүүлэхээр болсон.



НҮБ-ын Хүн амын сангийн “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд Баян-Өлгий, Завхан аймаг, Баянзүрх дүүргийн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор нийт 172.926.778 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.

Улсын хэмжээнд ажиллаж байгаа нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрнуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хяналт, дүн шинжилгээ, хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолтод хийсэн дүн шинжилгээний тайлангийн хэлэлцүүлгийг 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс хамтарсан багийн гишүүдийн жишиг ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх, аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нарт харьяалах нутаг дэвсгэрт ажиллаж байгаа нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байруудын үйл ажиллагааг тогтмолжуулах, орон тооны ажилтантай болгох, орон нутгийн төсөвт зардал тусгуулах асуудлаар ажлын чиглэл хүргүүлэхээр тогтов.

Шүүх шинжилгээний байгууллагын дэргэдэх гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудыг чадавхжуулах, хохирогчдод үзүүлж буй тусламж үйлчилгээг сайжруулах, сэтгэл зүйчийг сургалтад хамруулах зэрэг ажилд НҮБ-ын Хүн амын сангаас дэмжлэг үзүүлэн ажиллав.



Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, жендэрт суурилсан аливаа ялгаварлан гадуурхалт, хэвшмэл ойлголтыг өөрчлөх, энэ төрлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн 16 хоногийн хугацаанд тэмдэглэн өнгөрүүлдэг “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ыг

энэ жил “Нандин бүхнээ хамгаалъя” уриан дор зохион байгуулж, салбар дундын хамтын ажиллагаа, тэгш оролцоог ханган ажиллалаа.

2.4. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

Хил болон хилийн бүс, зурваст үйлдэгдэж байгаа хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Улсын тусгай хэрэгцээний газарт ойн дагалт баялаг бэлтгэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт зөвлөгөөнийг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд зохион байгуулсан. Зөвлөгөөнд 120 орчим албан хаагчид оролцсон.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг “Ногоон дуу хоолой” нэрийн доор “Зөв мод-зөв арчилгаа” уриатайгаар дэд зөвлөлийн гишүүн байгууллагууд болон 21 аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд харьяалах нутаг дэвсгэртээ 2022 оны 04 дүгээр сарын 15-наас 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулав.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран “Хүрээлэн байгаа орчинд ээлтэй аялал жуулчлал ба гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт салбар дундын хамтарсан зөвлөгөөнийг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Хэнтий аймгийн Хэрлэн суманд зохион байгуулсан.

2.5. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

